



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-6</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>7-64</i>

1. Монгол Улсын Ерөнхий прокурорыг томилох саналыг зөвшилцөх тухай	7-41
2. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	42-58
3. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/	58-64

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Х.Булгантуяа, Г.Ганбаатар, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Б.Найдалаа, Н.Наранбаатар, О.Номинчимэг, Г.Очирбат, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Л.Соронзонболд, Р.Сэддорж;

Чөлөөтэй: А.Ганбаатар, П.Ганзориг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Э.Бат-Амгалан, Ж.Баярмаа, Ж.Ганбаатар, Т.Мөнхсайхан;

Тасалсан: Х.Баттулга, Л.Гантөмөр;

Хоцорсон:Ж.Алдаржавхлан-30 минут, Н.Алтанхуяг-02 минут, Б.Батбаатар-05 минут, Д.Батбаяр-49 минут, Ж.Батсуурь-02 минут, Б.Батцэцэг-16 минут, П.Батчимэг-2 цаг 44 минут, Ж.Бат-Эрдэнэ-1 цаг 19 минут, Х.Болормаа-01 минут, С.Ганбаатар-10 минут, Д.Ганмаа-08 минут, Т.Доржханд-2 цаг 16 минут, Б.Дэлгэрсайхан-08 минут, Б.Жаргалан-04 минут, Д.Жаргалсайхан-24 минут, Ч.Лодойсамбуу-01 минут, Г.Лувсанжамц-01 минут, П.Мөнхтулга-2 цаг 48 минут, З.Мэндсайхан-18 минут, М.Нарантуяа-Нара-03 минут, Н.Номтойбаяр-04 минут, С.Одонтуяа-01 минут, Ц.Туваан-46 минут, Н.Учрал-2 цаг 01 минут, Г.Уянгахишиг-13 минут, Ж.Чинбүрэн-09 минут, Б.Чойжилсүрэн-03 минут, Ж.Энхбаяр-1 цаг 24 минут, Д.Энхтуяа-13 минут, С.Эрдэнэбат-38 минут, Р.Эрдэнэбүрэн-02 минут.

Нэг.Монгол Улсын Ерөнхий прокурорыг томилох саналыг зөвшилцөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын ерөнхий прокурорт нэр дэвшигч Б.Жаргалсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Ц.Гантулгат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Монгол Улсын ерөнхий прокурорыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшилцөх саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Улсын ерөнхий прокурорыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшилцөх саналыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал нар танилцуулав.

Нэр дэвшигч болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Эрдэнэболд, Б.Энхбаяр, Ц.Даваасүрэн, О.Цогтгэрэл, Х.Ганхуяг, Д.Пүрэвдаваа, Ж.Баясгалан, Ж.Батжаргал, Д.Ганбат, Х.Баасанжаргал, С.Замира, Р.Эрдэнэбүрэн, Б.Жаргалан, Н.Номтойбаяр, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Тэмүүжин, Л.Энх-Амгалан, Л.Мөнхбаатар, С.Бямбацогт, Ц.Баатархүү, Ц.Идэрбат, Г.Дамдинням, П.Сайнзориг нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын ерөнхий прокуророор Банзрагчийн Жаргалсайханыг томилох Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 16
Бүгд: 97
83.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Ганхуяг, С.Цэнгүүн, Ц.Даваасүрэн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 87.6 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Чуулганы нэгдсэн хуралдааны санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 12 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 16 минут үргэлжилж, 12 цаг 16 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 01 минутад эхлэв.

Хоёр.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Зээлийн мэдээллийн албаны дарга М.Баттулга, Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудал асуулт, хариултаар үргэлжлэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, М.Мандхай, Н.Алтаншагай, Б.Батбаатар, Д.Амарбаясгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Батбаатар нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 50
Бүгд: 98
49.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 50
Бүгд: 99
49.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарч байгаа тул Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан горимын саналын санал хураалтыг хүчингүйд тооцох горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 49
Бүгд: 99
50.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 47
Бүгд: 99
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 43
Бүгд: 100
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 44
Бүгд: 100
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, ахлах мэргэжилтэн Б.Батнасан, мөн газрын Төмөр замын тээврийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, С.Бямбацогт нарын тавьсан асуултад Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:29/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 45 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 66 гишүүн ирж, 52,4 хувьтай болсон тул 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт Улсын ерөнхий прокурорыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

3 дугаарт “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудалд оръё.

Улсын ерөнхий прокурорыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Гомбожавын Занданшатар танилцуулна. Индэрт урьж байна.

Улсын Их Хурлын чуулганы танхимд Монгол Улсын ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Банзрагчийн Жаргалсайхан ирсэн байна. Ажлын хэсгийн гишүүдээр Гомбожавын Занданшатар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Жаргалсайханы Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, Отгонбаярын Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Цогтбаярын Гантулгабат Улсын ерөнхий прокурорын туслах, Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байна.

Занданшатар даргыг индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 14, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны

дагуу Банзрагчийн Жаргалсайханыг Монгол Улсын ерөнхий прокуророор улируулан томилох асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр танилцуулж байна.

Банзрагчийн Жаргалсайхан 1964 онд Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумд төрсөн. Ам бүл 4. Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. 1973-1983 онд Өвөрхангай аймгийн 2 дугаар 10 жилийн дунд сургууль, 1983-1988 онд Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн ухааны факультетын хуулийн салбарыг хуульч мэргэжлээр төгссөн. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх зэрэг дэвтэй. Жаргалсайхан нь прокурорын байгууллагад нийтдээ 37 жил ажиллаж байна.

1988-1996 онд Өвөрхангай аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, хяналтын прокурор, туслах прокурор, орлогч прокурор, 1996-2000 онд Өвөрхангай аймгийн прокурор, 2000-2001 онд Улсын ерөнхий прокурорын газарт Хяналтын прокурор, 2001-2009 онд Тээврийн прокурор, 2009-2011 онд Улсын ерөнхий прокурорын газарт Хэрэг эрхлэх газрын дарга, 2011-2014 онд Тээврийн прокурор, 2014-2016 онд Улсын ерөнхий прокурорын газарт Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дарга, 2016-2017 онд Улсын ерөнхий прокурорын газарт Тамгын газрын орлогч дарга, 2017-2019 онд Улсын ерөнхий прокурорын газарт Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, 2019 оноос Монгол Улсын ерөнхий прокуророор ажиллаж байна. Иймд Банзрагчийн Жаргалсайханыг Улсын ерөнхий прокуророор томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Банзрагчийн Жаргалсайханыг Монгол Улсын ерөнхий прокурорын албан тушаалд томилох асуудлыг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Гомбожавын Занданшатар нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Улсын ерөнхий прокурорыг томилох тухай асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нэр дэвшигчээс шүүн таслах үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх тэгш мэтгэлцэх зарчмын шинэчлэлийг дэмжиж байгаа эсэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаас Прокурорын тухай хууль, Төрийн албаны тухай хуультай нийцэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат нэр дэвшүүлж байгаа байгууллагын төлөөллөөс Улсын ерөнхий прокуророор томилогдсоны дараа хуульд заасан хугацааг дуустал ажиллуулах талаар, олон нийтийн анхааралд байгаа ногоон автобусны хэрэгт холбогдсон хүмүүс ялгүй өнгөрч байгаа талаар болон шүүхээр шийдэгдсэн этгээдүүдийн ял эдлүүлэх ажиллагаанд хэрхэн хяналт тавьж

байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төрийн өндөр албан тушаалтнуудын авлига, албан тушаалын хэрэгт прокурорын байгууллагаас яллах дүгнэлт гарсан хэргүүдийн хэдэн хувь нь шүүхээр шийтгэгдсэн тоон мэдээлэл, судалгааны талаар өмнөх бүрэн эрхийн хугацаанд төрийн өндөр албан тушаалтнуудаас нөлөөлөх оролдлого байсан эсэх талаар, хэрэгт нэр холбогдсон прокуроруудад хариуцлага тооцсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хавтаст хэргийг цахимжуулах ажлын явцын талаар болон прокурорын байгууллага дахь цахимжилтыг дэмжиж байгаа эсэх, прокурорын ёс зүйн хуулийн төсөл боловсруулахад дэмжиж ажиллах эсэх, прокуроруудыг дагнасан чиглэлээр мэргэшүүлэх талаар хэрхэн ажиллаж байгаа болон прокурорын байгууллагын албан хаагчид дүрэмт хувцастай байх нь зохимжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нэр дэвшүүлж байгаа хуулийн үндэслэлээ тодорхой болгох, прокуроруудын шүүхэд төлөөлөх эрхийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, шүүх танхимд прокурор болон өмгөөлөгчид тусгай өмсгөл өмсөхгүй байх талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихаас гадна прокурорын байгууллагыг институцийн хувьд бэхжүүлэх, үйл ажиллагаагаа илүү нээлттэй ил тод болгож, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, прокуроруудыг мэргэшүүлэхэд анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б. Заяабал хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашгийг хангах асуудлыг тэргүүн ээлжид тавьж, улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнуудын оролцсон хэргүүд дээр ил тод, нээлттэй, шударга ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны цахимжилтын хүрээнд хиймэл оюун ухаан ашиглах, энэ чиглэлээр дэмжиж ажиллах талаар үг хэллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын ерөнхий прокурорыг томилох тухай Улсын Их Хуралтай зөвшилцөх саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 75 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын ерөнхий прокурорыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшилцөх саналыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье. 22 гишүүн байна. Дашдондогийн Ганбат гишүүн.

Ирсэн ирцийн дагуу Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Ганбат гишүүн орой ирсэн байна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2016 онд Их Хурлын гишүүнээр дөнгөж сонгогдоод 2017 оны төсөв ярьж байхад ер нь шүүгч нарын цалин хэтэрхий өндөр, прокуроруудын цалин бага байсан. Тэгээд энэ төсвийн хэлэлцүүлэг явж байхад прокуроруудын цалингийн санг 9,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй

санал гаргаад, тэрийг нь Ардын нам дэмжих болов уу, дэмжихгүй болов уу гээд бас санаа зовж байх үед Нямдорж сайд тухайн үед бас саналаа гаргадгаараа гаргачих манайхаас дэмжчихье гээд хамтдаа прокуроруудын цалинг нэмэгдүүлж байсан ийм байгаа. Тэгэхээр үүний үр дүнд прокурорууд цалин нэмэгдэж, ажлаа бас шударгаар хийх ийм боломжийг нээж өгсөн. Дараа дараа нь олон олон нэмэгдлүүдийг нэмэх талаар Байнгын хороо, Их Хурал дээр байнга дэмжээд явсан. Тэгээд өнөөдөр прокуроруудын ажиллах орчин, гадаад харилцаа, мөн түүнчлэн цалин бас нэлээн гайгүй түвшинд Их Хурлаас харж шийдвэрлэж байгаа шүү гэдгийг хэлье.

Тэгэхээр яг мэргэжлийн яг прокуророор олон жил ажилласан хүн прокурорын дарга байхын бас зөвийг би мэдрээд байгаа юм. Яагаад гэвэл 1 улс төрч байсан. Та нар бүгдээрээ санаж байгаа. Манай намын нэг улс төрч прокурорын даргаар байгаад, хэрэг уншиж мэдэхгүй. Хэрэг уншиж мэдэхгүй хүн чинь яах вэ гэхээр улс төрийн өнгө аясаар асуудалд ханддаг. Тэгээд доод талын хүмүүс нь хэрэг уншихаад дарга ийм байна гээд худлаа үнэн, янз янзын юм хэлдэг, түүнийх нь дагуу шийдвэр гаргадаг. Үүний үр дүнд прокурорын байгууллага бас эвгүй байдалд нэг хэсэг орох шахсан шүү дээ. Тэрнийх нь үзүүрт намайг жишээ нь хэлмэгдүүлсэн маягтай ингээд явж байсан. Тийм учраас хэргээ уншиж мэддэг хүн прокурорын даргаар байна гэдэг хүмүүсийг хэлмэгдүүлэхгүй байх тэр боломжийг бас сайн хийж чадаж байна л гэж би харж байгаа.

2 дугаарт нь бас улс төрийн нөлөөнд бас өнгөрсөн хугацаанд Жаргалсайхан прокурор ажиллахдаа ордоггүй юм байна гэж би нэг зүйлээс харсан. Өөрөөр хэлбэл төрийн өндөр албан тушаалтан ийм асуудлыг шийдвэрлэх дээр нь тэрийг нь хүлээж авдаггүй. Тэгээд 1 хэсэг бас би өвчтэй гээд нэлээн хэдэн сар гадаад дотоодод байсан байх. Тэрний ардуур 1 эмэгтэй прокурор орлогч нь бас будилуулсан ийм зүйлүүд зөндөө байгаа шүү дээ. Тийм учраас тийм дээрээс үүрэг өгөөд л, ингээдэх тэгээдэх гэдэг ийм чиглэлд хүн автдаггүй юм байна гэсэн ийм итгэл үнэмшил байгаа.

Ийм 2 итгэл үнэмшлийн үндсэн дээр би энэ хүнийг дахин томилох тэр асуудлыг бол дэмжиж байгаа. Ер нь төрд олон жил хатаагдсан, ноён нуруутай тэгээд янз янзын ашиг сонирхлын юм нь буучихсан, тэгээд дахиад улс төрч болно гээд энэ албыг улс төрийн зорилгоор ашиглахгүй ийм хүн сонгогдож байгаа нь би зөв л гэж үзэж байгаа. Тийм учраас таныг прокуророор ажиллаж байгааг дэмжиж байгаа шүү гэдгээ хэлье. Улам их амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Отгоншарын Батнайрамдал гишүүн үг хэлье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Энэ асуултыг би бүлэг дээр асуусан л даа. Гэхдээ яг өнөөдөр чуулганаар олон нийтэд бас олон эцэг эхчүүд, хүүхдүүд, суралцагсад бас хариулт хүлээж байгаа учраас өнөөдөр бас дахиад танаас асуучихъя гэж бодсон юм.

Тэгэхээр Боловсролын зээлийн сантай л холбоотой юм л даа. Тэгэхээр Боловсролын зээлийн сан өөрөө Монгол Улсын Засгийн газрын 24 тусгай сангийн 1 явж ирсэн. Нийт санхүүжилт ингээд том дүнгээр аваад үзэх юм чинь 1,4 их наяд төгрөгийн хэмжээний татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжсэн. 1,3 сая суралцагчдад бас хүрсэн. Гэхдээ энэ дотроос өнөөдөр хүртэл асуудал дагуулсаар байгаа яг 1 хэсэг яалт ч үгүй гадаадад суралцагсдад олгосон зээл байгаа юм л даа. Сүүлийн 30 жилийн хугацаанд өнөөдрийн байдлаар аваад үзэх юм бараг 460 гаруй тэрбум төгрөг гадаадад суралцах 3700 орчим суралцагчид олгосон. Гэхдээ өнөөдөр эргэн

төлөлтийг нь аваад үзэхээр гадаадад суралцагсад олгосон зээл, дотоодод суралцагсад олгосон зээл 2-ын хооронд өдөр шөнө шиг ялгаатай хэвээрээ байгаад байгаа юм. Дотоодод суралцсан оюутнуудын зээлийн эргэн төлөлт 98 хувьтай. Маш сайн. Яагаад гэвэл тэд нар эр зээлээ эргэн төлөхгүй Монголбанкны бид бүхний хэлдэг саарал жагсаалтад ордог. Сүүлийн 10 жил орсоор ирсэн. Гэтэл гадаад зээл өнөөдөр эргэн төлөлт нь дөнгөж 4 хувьтай. Энэ асуудлыг гаргаж ирээд миний ойлгож байгаагаар Прокурорын ерөнхий газар бас нэлээн өргөн хэмжээний мөрдөх үйл ажиллагаа явуулж, 1600 гаруй хүнээс мэдүүлэг авсан гэсэн мэдээллийг прокурорын веб сайтаас авсан байгаа. Тэгэхээр ингэж байж 14 орчим тэрбум төгрөг л эргэн төлөгдсөн байгаа юм л даа. Тэгэхээр өнөөдөр хүртэл дахиад 340 орчим тэрбум төгрөг эргэн төлөгдөх татвар төлөгчдийн мөнгө зээл хэлбэрээр олгогдоод хуулийн хугацаандаа эргэн төлөгдөх ёстой. Тэгэхээр эргэн төлөлт хийгдэх юм бол дахиад 2 мянга гаруй суралцагчид гадаадад сурах маш том боломж л доо. Зүгээр төсөөлөөд үзэх юм бол 2 мянган хүүхдийг гадаадад суралцуулаад ирэхэд Монгол Улсын ирээдүй хэрхэн өөрчлөгдөж болох вэ, бидний өнөөдөр тулгамдаж байгаа асуудлуудын шийдэл нь тэр суралцаад ирэх хүүхдүүд шүү дээ. Тэгэхээр энэ дээр Прокурорын ерөнхий газар, АТГ, ЦЕГ хамтраад ажлын хэсэг гараад, 1600 гаруй хүнээс гэрчийн мэдүүлэг авсан ийм өргөн хэмжээний мөрдөх үйл ажиллагаа явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд үйл ажиллагаа дээр бас та бид бүхэнд апдэйт өгөөч. Хаана явж байгаа вэ. Бас тэр татвар төлөгчдийн мөнгийг нь зээлийн эргэн төлөлт хийгдэнэ гэж бид нар хүлээж болох уу.

Д.Амарбаясгалан: Өнөөдөр прокурорыг томилох асуудал ярьж байгаа. Бид прокурорын байгууллагын тайланг сонсоогүй. Тийм учраас Батнайрамдал гишүүний асуултад хариулах боломжгүй. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр 1992 оны Үндсэн хуулиас хойш 30 гаруй жилийн хугацаанд бид эрх зүйт нийгмийг төлөвшүүлэх, хуулийн засаглалыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, парламентын засаглалыг бүрдүүлэх гэсэн цогц зорилгуудын төлөө явж байгаа. Энэ хүрээнд парламентын шинэчлэл Үндсэн хуулийн нэмэлтээр харьцангуй бас гишүүдийн тоо нэмэгдэж, ард түмнийг төлөөлөх парламентын чадавх нэмэгдэж, улмаар бас гүйцэтгэх засаглалд хяналт тавих боломж бол онолын хувьд нэмэгдсэн байгаа юм. Ингээд яах вэ, парламентын чадавхыг идэвхжүүлэх гол зарчим бол Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, олон улсын тавцан дээр Монгол Улс ардчиллаа авч үлдэх гэсэн том эрмэлзлийн төлөө хийгдсэн зүйл гэж үзэж байгаа юм.

Нөгөө талд нь шүүх эрх мэдлийн шинэчлэлийн асуудал байгаа юм. Би асуултыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Гомбожавын Занданшатар даргаас асуух гэж байгаа юм. Энэ хүрээнд прокурорын шинэчлэлийн асуудал маш учир дутагдалтай байгаа. Улс төрийн намууд сонгуулиар энэ шинэчлэлийг хийнэ гэж бүгдээрээ амладаг. 2024-2028 он хүртэлх хөтөлбөрт энэ шинэчлэл орсон байгаа. Тэгэхээр прокурорын шинэчлэл дэх хүний эрхийг хамгаалах асуудлыг концепцын хувьд ер нь юу гэж харж байна вэ.

Яах вэ өнөөдөр бид нар тодорхой томилгоотой холбоотой асуудлууд дээр ингээд шийдэгдээд явах нь ойлгомжтой. Гэхдээ ард түмэн асар их бухимдалтай байна. Шударга ёсны хүсэмжлэл маш их байна. Шударга ёсыг хуулийг гууль боллоо. Дабль стандарт буюу давхар байдалтай хандаад байна. Эрх мэдэлтэй нөлөө бүхий хүмүүст асуудал өөрөөр шийдэгдээд, бор зүрхээрээ явж байгаа жирийн иргэдэд

хууль хатуу байна гэсэн шүүмжлэл маш их байгаад байгаа. Тэгэхээр прокурорын шинэчлэлтэй холбогдуулаад хүний эрхийн асуудлыг ер нь яаж авч үзэж байна вэ. Тэгэхээр нэр дэвшигчийн нэрийг оруулж ирж байгаа Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга энэ дээр бас тодорхой хариулж өгөөч ээ.

2 дугаарт бүлэг дээр нэр дэвшигчийн танилцуулгын үеэр би нэг асуулт асуусан. Итгэл үнэмшлийн тухай асуулт. Хүсэл зоригийн тухай асуулт. Өөрөөр хэлбэл улс төрийн зориг гэдэг шиг хуульчийн зориг, өргөсөн тангарагтаа үнэнч, итгэл үнэмшилтэйгээр ажиллах таны итгэл үнэмшил ямар байна вэ. Мэдээж бас таны нэрийг ингээд Ерөнхийлөгчийн зүгээс Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр оруулж ирж байгаа. Нөгөө талаасаа яг та өнгөрсөн түүх гэхээс илүүтэйгээр ирээдүй рүү чиглэсэн, магадгүй томилогдлоо гэхэд дараагийн 6 жилд ямар зарчмыг баримталж прокурорын шинэчлэлтэй холбоотой бодлогын асуудлууд дээр яаж ажиллах вэ гэсэн итгэл үнэмшлээ та протоколд үлдээж тодорхой хэлээч гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулъя. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Занданшатар: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Сэрчингийн Сүхбаатарын Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Ер нь засаглалын шинэчлэл бол 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газар тогтвортой ажиллах эрх зүйн үндэс бүрдэж, 1,4 жилийн настай байсан Засгийн газар тогтвортой ажиллах болж, Улсын Их Хурал төлөөллийн чадавх нэмэгдэж, ард түмнийг төлөөлөх чадавх, олон намын төлөөлөл, залуучууд, эмэгтэйчүүдийн төлөөллийн чадавх нэмэгдэж, энэ хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын шинэчлэл бол сайн хэрэгжээд явж байна. Үндсэн хуулийн 1 гол эрх мэдэл болох шүүхийн шинэчлэл, тэр дотроо шүүх шинэчлэлийн шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүнд багтдаг прокурорын шинэчлэлийн асуудал бол мэдээж энэ засаглалын шинэчлэлтэйгээ цогц иж бүрнээр явагдах ёстой гэж үзэж, шүүхийн шинэчлэлийн Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн асуудлуудыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тодорхой зааж өгсөн. Тэрний дагуу Шүүхийн тухай хуулийг баталж процессжуулсан. Энэ жишгээр прокурорын шинэчлэл бас цаашдаа шүүх шинэчлэлийнхээ бүрэлдэхүүн хэсэг болж өргөжиж, үргэлжилж явах ёстой гэж үздэг.

Тухайлбал, шүүгч нар Ерөнхий шүүгч байсан шүүгч нар албан тушаалтнуудтай уулзахдаа протокол хөтөлдөг байх, Үндсэн хуульд заасан шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс аливаа албан тушаалтны эрх мэдэлтэн, Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхий сайд, дарга, Ерөнхийлөгч нар нөлөөлж болохгүй гэсэн тэр заалтыг хэрэгжүүлэх үүднээс шүүхийн хуульд тодорхой процессуудыг оруулж өгсөн. Протокол заавал хөтөлдөг, нөлөөлж болохгүй гэх мэтчилэн олон процессыг бас баталж, тэгээд цаашилбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хуулийн цогцоороо системийн өөрчлөлт ингэж хийх асуудал хэрэгжих ёстой. Энэ бол хууль тогтоогчдын бүрэн эрхийн асуудал. Энэ шинэчлэлийн ажлыг хууль тогтоогчид үргэлжлүүлж, прокурорын мөрдөнгийн асуудлыг өчигдөр Хууль зүйн байнгын хороо дээр бас нэлээн хөндөж ярьж байсан. Энэ асуудлууд бол хууль тогтоогчоос санаачлаад үргэлжлүүлээд хэрэгжүүлж байх ёстой шинэчлэл хэмээх тасралтгүй процессын нэг хэсэг байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Ерөнхий прокурор ...

Г.Занданшатар: Эцэст нь бас нэг зүйл нэмж хэлэхэд бол өчигдөр Ерөнхий прокурор ч хэлсэн. Прокурор бол хүний эрхээр мэргэшсэн, тусгай эрх мэдлийн байгууллагуудад хяналт тавих эрх бүхий субъектийн хувьд хүний эрхийг дээдэлж ажилладаг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий прокурор Жаргалсайхан прокурор хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Өчигдөр бүлгийн хурал дээр бас Эрдэнэболд гишүүнд хариулсан. Итгэл үнэмшил гэдэг тухайн байгууллагын итгэл үнэмшил, хувь хүний итгэл үнэмшил гэж байдаг. Хувь хүний итгэл үнэмшил дүүрэн байгаа гэдгээ би гишүүнд хэлсэн.

2 дугаарт Ерөнхий прокурорын хувьд прокурорын байгууллагыг толгойлж байгаагийн хувьд энд ажиллаж байгаа хүмүүс итгэл үнэмшил ямар байх вэ гэдэг Ерөнхий прокуророос их шалтгаалдаг юм. Тийм учраас итгэл үнэмшлийг төрүүлэхүйц бие даасан, хараат бус байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг хийсэн. Энэ нь манай байгууллагад ажиллаж байгаа прокурор, ажилтнуудын итгэл .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Нэмэлт минут.

Б.Жаргалсайхан: Баттай байгаа гэж би ингэж боддог юм. Прокурорын байгууллага 2022 онд 2023-2026 онд баримтлах стратеги төлөвлөгөөгөө боловсруулсан. Энэ төлөвлөгөөнд бие даасан хараат бус байдлыг сайжруулах, прокурорын хяналтыг боловсронгуй болгох, цахимжуулах гэсэн ийм чиглэлүүдийг оруулсан юм. Энэ хөтөлбөрийн дагуу бид цаашдаа олон зүйлийг хийх ийм шаардлага үүсэж байгаа. Энэ хөтөлбөрийн дагуу бид тодорхой ажлуудыг хийж дүгнээд үзэхэд сүүлийн 3 жил дотор хөтөлбөрийнхөө хүрээнд биелүүлсэн хувь нь 73,3 хувьтай байгаа. Энэ ажлаа улам цаашид бас ажиллуулна. Өнөөгийн өсөн нэмэгдэж байгаа цахимтай холбоотой асуудлын хөгжлөөс .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Энхбаяр: Монгол Улсын ерөнхий прокурор Жаргалсайхан таныг дэмжиж байгаа. Монгол төрийн шударга, хар хайрцгийн бодлогыг бас тээж яваа ийм зарчимч төрийн түшээ гэж үнэлж явдаг. Таныг Ерөнхий прокуророор ажиллаж байх хугацаанд Монгол Улсын төрийн тэргүүний институц болон Ерөнхий прокурор мөн парламентын хүрээнд 1 ажлыг бас хийчих юм сан гэсэн бодол тээж явдаг. Энийгээ ч гэсэн олон удаа бас илэрхийлж, урьд нь ярьж явсан. Сая бас манай гишүүд Эрдэнэболд гишүүн сая хөндөж байна. Занданшатар дарга бас сая байр суурь илэрхийллээ. Монгол Улсын төрийн тэргүүний институц, прокурорын байгууллагын тогтолцоо, түүнд ажиллах хүмүүсийн шалгуур, хариуцлага тооцох асуудлууд зэрэг хүрээнд 2021 онд хийгдсэн шүүхийн шинэтгэлийн зарчимтай төстэй байдлаар шинэтгэл хийх ийм улс төрийн хүсэл эрмэлзэлтэй байгаад туйлын талархалтай хандаж байна. Бид ганцхан ер нь аливаа нэг шинэтгэлийг ярихаар 2 хүчин зүйлээс зэрэг хамаардаг юм байна. Би бол яг хувилж мэдэхгүй. Тэгэхдээ 50, 50 хувь л юм шиг байна. 50 хувь нь хуулиас хамаардаг юм байна. 50 хувь нь хүнээс хамаардаг юм байна. Сайн тогтолцоо дээр муу хүн ирвэл тэр тогтолцоог нураадаг юм байна. Сайн хүн ямар ч сайн зүйлийг хийгээд, муу хуулийн схем дээр бас ажиллах

бололцоо их муу байдаг юм байна. Тийм учраас энэ 2 маань бүрдэж байж, сая бидний хүссэн үр дүнд хүрдэг юм байна гэж ингэж харагдаж байгаа.

Шүүхийн шинэтгэлийг ярьж байх үед бид нэг зүйлийг хэлж байсан. Энэ бол шударга ёсны тогтолцооны 10 хувийг л бид шинэчлэх гэж байгаа юм. Хууль, эрх зүйн хүрээнд нь гэж. Яагаад ингэж ярьж байсан бэ гэхээр үндсэндээ шүүх маань өөрийнхөө итгэл үнэмшил, сайн дураар хэргийг шийддэггүй байгууллага. Шүүх дээр тэр хэрэг учралыг аваачиж байгаа этгээд ерөөсөө л прокурор байгаа. Прокурорын цуглуулсан нотлох баримт, хавтаст хэргийн хүрээнд л шүүх шийддэг. Тэгээд нотлогдвол ялладаг, нотлогдохгүй цагаатгадаг ийм л зарчимтай.

Тийм учраас прокурор дээр ирж байгаа энэ хариуцлага нэн өндөр болж байна. Бид өнгөрсөн парламентын хамгийн сүүлийн хавар 2024 оны 6 сард ялангуяа авлига, албан тушаалын хэргүүдийг шүүх хуралдаануудыг нээлттэй ил тод байх хуулийг баталсан. Энэ хүрээнд Монгол Улсын дээд шүүх, Ерөнхий прокурор бас манлайлаад шүүх хурлуудыг цахимаар шууд дамжуулдаг боллоо. Энэ бол би их том үр дүн гэж үзэж байгаа. Ард түмэн нийтээрээ урьд нь ингээд тодорхой ингээд хэрэг хэвлэлээр хаядаг. Зориуд хүнийг гутаах гээд. Тэгээд олон нийтийн дунд бүр гэмт хэрэгтэн гэж ойлголт өгч байгаад, дараа нь тэрийгээ хонгилоор чирдэг. Тэгэнгүүт одоо бид нар ингээд нээлттэй болгосны үр дүнд юу харж байна вэ гэхээр үнэхээр тэр хүн гэм буруутай байсан юм уу, гэм буруугүй байсан юм уу, яг ямар нотлох баримтын хүрээнд шүүх асуудлыг, тэр хүний гэм бурууг ярьж байна вэ гэдгийг бүгдээрээ хамтдаа яг ижил мэдээлэл, долгион дээр авч үзэх боломжтой болж байгаа юм. Энэ маань өөрөө хамгийн ардчиллын шилэн байдлын тунгалаг сайн тал байгаа юм. Тийм учраас прокурорын мөрдөн шалгах ажиллагааны дотоодод мөн дотоод ардчиллыг бэхжүүлэх, хариуцлагыг сайжруулах хүрээнд хамтарч ажиллах чиглэл дээр Занданшатар дарга маань ямар бодол саналтай байна вэ гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Занданшатар: 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ер нь шүүхийн бас тодорхой шинэчлэлүүд орж, Шүүхийн шинэчлэлийн тухай хууль, багц хуулиуд батлагдаж бас хэрэгжиж явж байгаа. Шүүхийн шинэчлэл. Мэдээж үр дүн нь бол тодорхой хугацааны дараа гарч, хуулийн хэрэгжилтийг Улсын Их Хурал хянаж цэгнээд, аль нь болж байгаа, аль нь болохгүй байгаагаа хянаж дүгнэж үзээд улам боловсронгуй болгоод явах байх. Энд тодорхой том ахиц дэвшлүүд гарсан. Өнөөдөр илт мэдрэгдэж байгаа олон үр дүнгүүд бий. Тэгээд 50 хувь хүнээс, 50 хувь хуулиас хамаарч байна гэж байна. Ер нь шүүхийн шинэчлэлийн ажил бол 10 хувьтай явж байгаа гэж бас өчигдөр Байнгын хороо дээр яригдаж байсан. Тэгэхээр энэ шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүн болсон прокурорын шинэчлэлийн асуудал бас миний хэлсэнчлэн тэр прокурорын мөрдсөнөөс авхуулаад, хүний эрхийг хамгаалах гол институцийн хувьд прокурорын хуулийн шинэчлэлийг бол хууль тогтоох байгууллага Улсын Их Хурлын гишүүд манлайлж хэрэгжүүлэх байх. Үүнтэй бас Ерөнхийлөгчийн Тамгын газар хамтран ажиллаж, энэ шинэчлэлийг хэрэгжүүлэх, мөн шүүхийн хуулийнхаа хэрэгжилтийг ч гэсэн эргэж хянаж үзэж, аль нь болж байна, аль нь болохгүй байна, улам боловсронгуй болгох талаар шүүх эрх мэдлийг шударга ёсыг тогтооход хууль дээдлэх зарчмыг тууштай өргөжүүлэхэд шүүх эрх

мэдлийн шинэчлэл зайлшгүй чухал. Ийм учраас Баттөмөрийн Энхбаяр гишүүний гарч байгаа санаачилгуудтай санал нэг байна.

Ер нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ шинэчлэлүүдийн үр дүнд илүү их авлигатай тэмцээд, илүү олон хэрэг илрүүлээд, илүү олон хэрэг шүүх рүү шилжээд л байгаа учраас авлига нэмэгдсэн юм шиг харж байгаа болохоос биш далд байгаа юмнуудыг л бүгдийг нь ил болгосон энэ шинэчлэлийн үр дүнд тодорхой үр дүнд гарсан. Тухайлбал Ерөнхий прокурор өчигдөр танилцуулснаар 4,8 их наяд төгрөгийн хохирлыг барагдуулж, шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо хэдэн 10 дахин нэмэгдэж, ер нь шударга ёс шүүхийн байгууллагын шинэчлэлийн ажлуудын тодорхой үр дүн гарч байгаа. Бодит хэмжүүрээр бас хэмжиж болох байх. Цаашдаа улам сайжруулах сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт шинэчлэлт бол нэн ялангуяа Үндсэн хуулийн гол байгууллага институцийн хувьд хэрэгжих ёстой гэсэн саналуудтай санал нэг байна.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Тэмүүжин: 3 зүйлийг яримаар байна. 1 дүгээрт түрүүн Пүрэвдорж хэллээ. Хуулийн байгууллагын толгой дээр хуулийг үл хүндэтгэдэг, шуналын дэв очихоор юу болдог гэдгийг бид маш сайн мах цусаараа мэдэрсэн. Тийм учраас сайн хүн олж тавихаас гадна тогтолцооны зоригтой шинэтгэлүүд үгүйлэгдэж байгаа. Ардчилсан эрх зүйт улс орнуудад байдаг шиг Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор 2 1 хүн байхад 6 жил томилогдоно уу, нас нь хэд байх энэ тэр бол нэг их асуудал биш. Тэр улсуудад Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор 2 1 хүн байхад санаа зовохгүй байгаа. Тэр улсуудад Хууль зүйн сайд, дотоод хэргийн сайд 2 1 хүн байхад харин айж сэргээж байгаа. Яагаад гэвэл хэрвээ Хууль зүйн сайд, дотоод хэргийн сайд 2 1 хүн байхаар тэр нь цагдаагийн сайд болж хувираад, улс нь цагдаажсан төртэй л болж хувирдаг юм байна лээ. Тэгэхээр ийм том тогтолцооны шинэтгэлийг зоригтой хийх хүлээлт байгаа гэдгийг би энд хэлэхийг хүссэн юм.

2-т нь Ерөнхий прокурор томилогдох гэж байна. Прокурорын байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дээр нэг ийм үг байдаг юм. Хуулийг нэг мөр хэрэгжүүлэх гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль олон нүүргүй нэг байхын тулд байгууллага оршин байгаа тухай ярьж байгаа юм. Тийм учраас би хэд хэдэн хуулийг зүгээр сануулмаар байна. Бүр протоколд үлдээх гэж байгаа юм.

Прокурорын тухай хуулийн 60.3 дээр прокурорын тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас гэж бичсэн байгаа. Төрийн албаны тухай хуульд 41.2 дээр хуульд өөрөөр заагаагүй бол дээд хязгаар 65 нас гэж бичсэн байгаа. Төрийн албаны хууль хуульд өөрөөр заагаагүй гэдэг үгтэй. Хуульд өөрөөр заасан нь Прокурорын тухай хууль дээр байгаа. Хуулийн энэ зөрчлийг арилгахгүйгээр Улсын Их Хурал шийдвэр гаргавал 2 өөр шийдвэр гаргана. Улсын Их Хурал жоохон хожуу, хойшоо сууж ажиллаж байгаа байх.

Үндсэн хуулийн цэцээс 2025 оны 2 сарын 14-нд 2 дугаар тогтоолоороо Дээд шүүхийн шүүгч, шүүгч нартай холбоотой, тэтгэврийн настай холбоотой маргаан шийдвэрлэсэн. 55 нас гэдэг маргааныг. Хэрвээ Улсын Их Хурал 60-аас дээш настай хүнийг хуулийн байгууллага дээр томилох гэж байгаа хуулийн зөрчлийг арилгах ёстой шүү. Арилгахгүй бол ард нь Үндсэн хуулийн цэц рүү үсэрчих вий гэж болгоомжилж байгаа. Ажил авч байгаа хүн нь ч, ажил явуулж байгаа хүмүүс нь ч

Үндсэн хуулийн маргаан руу очвол энэ бол эрсдэлтэй. Тийм учраас протокол дээр би маш тодорхой сануулж байна.

Шүүхийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар байгуулагдаж байгаа ажлын хэсэг Хууль зүйн байнгын хороо дээр хурдтай ажиллаж, энэ зөрчлөө арилгахгүй бол энэ өөрөө төвөгтэй байдалд аваачна шүү гэдгийг дахин сануулж хэлж байгаа юм.

3-д нь Энхбаяр гишүүний хэлсэнчлэн үнэхээр прокурорын манлайллаар 1 ажлыг хийх цаг болсон. Прокурорууд яллах үйл ажиллагаагаа шүүх дээр явуулах ёстой. Гэтэл мөрдөх байгууллага чинь шүүх дээр ажилладаг биш, хэвлэл дээр ажилладаг байгууллагууд болоод хувирчихлаа. Сүүлдээ Хууль зүйн сайд нь хүртэл прокуророос зөвшөөрөл авсан эсэх нь мэдэгдэхгүй хэргийг хэвлэлээр ярьдаг болж байна. Энийг зогсоохын тулд тэр прокурор гэдэг хүн процессын эзэн хувьдаа шүүх рүү яллах үйл ажиллагаа явуулж, энэ хэргийг толгойгоор хариуцаж орж байгаагийнхаа хувьдаа ямар ч албан тушаалтан прокурорын гадуур хэрэг ярьж байгаа үйл явдлыг тас цохих ёстой шүү. Хэвлэл дээр биш шүүх дээр шударга ёс тогтдог, хууль амилдаг нотлох баримт үнэ цэнтэй..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Х.Тэмүүжин: Дахин хэлье. Хэвлэл дээр пи ар шиг биш, улс төрчид шиг биш, шүүх дээр хууль амилдаг, шударга ёс тогтдог, нотлох баримт үнэ цэнтэй байдаг энэ хуулийн засаглалыг хүний эрхийн хамгаалалтыг прокурор манлайлж ажиллах цаг болсон шүү. Мэргэжилдээ үнэнч байх гэдэг бол маш чухал. Би түрүүн үгийнхээ эхэнд хэлсэн. Хууль дээдэлдэггүй, мэргэжлээ үл тоомсорлодог шуналын дэв хуулийн байгууллагын толгой дээр очихоор ямар аймшиг болдгийг би Жаргалсайхан прокурорт мэргэжилдээ үнэнч байдаг, хуулийг эрхэмлэдэг гэдэг байр сууринд нь итгэж байна. Хуулийг нэг мөр Монгол Улсын хэмжээнд үйлчлүүлэхийн тулд хууль тогтоогчид бас ажлаа хийх ёстой.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Та бүхний өглөөний амгаланг эрье. Нэр дэвшигч Жаргалсайханыг би мэргэжлийн хүний хувьд дэмжиж байгаа. Ер нь аль ч салбарыг ер нь мэргэжлийн бас туршлагатай, зарчимтай, ноён нуруутай ийм хүмүүс авч явбал үр дүнтэй байдаг. Анх 2019 онд томилогдоход бас би өөртэй чинь уулзахад яг л ийм л зүйлийг хэлж байсан. Мэргэжлийн хүн гэдгээр нь дэмжиж байгаа гэж. Мэргэжлийн бус хүн очих бол осолтой юм билээ. Ийм тохиолдлууд прокурор дээр гарч байсан. Сүүлд нь яасан бизнесийнхнийг дээрэмдсэн. Жапан таун энэ тэр гээд л элдэв юм сонсогдож эхэлсэн шүү дээ. Тийм учраас би өөртэй чинь холбогдолтой бас өнгөрсөн хугацаанд янз бүрийн иймэрхүү асуудал гараагүй учраас мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан гэж бодож байгаа учраас дэмжиж байгаа юм.

2 зүйлийг би хэлье гэж бодож байна. 1 дүгээрт улс орныхоо үндсэн эрх ашгаас урваад байгаа хүмүүст жоохон хатуу байгаарай. Оюутолгойн муухай жишгийг бид нар дахиж давтаж болохгүй. Би зүгээр нэг зүйлийг Оюутолгой дээр бас зүгээр тодруулъя гэж бодож байна. Гэмт хэргийн Оюутолгойтой холбогдолтой асуудлыг шалгах явцад Болд гэдэг хүний тэр нөгөө Рио Тинтогийн Болд шүү дээ. Болд гэдэг хүний данснаас Монголын 6 улс төрчид мөнгө шилжүүлсэн байдаг юм. Энэ тэгээд яагаад авлигын хэрэг болсонгүй вэ гэдэг дээр би гайхаад яваад байдаг юм. Хэрвээ бид нар авлигыг тогтоож чадсан бол Оюутолгойн гэрээг өөрчилж чадах байсан.

Хөрөнгө оруулалтын гэрээг. Гэтэл эд нар маань хууль бусаар завшсан гээд ингээд явчихсан юм шиг байгаа юм. Тэгээд дээр надад нэг тодруулга өгөөч гэж. Тэр 6 нэр бүхий хүмүүсийг яаж үзсэн юм бэ гэж.

2-т гүтгэлгийг ерөөсөө зогсоох хэрэгтэй. Бусдыг гүтгэхийг. Би бүүр өөрийнхөө амьдрал дээр тохиолдож байгаа жишээ татаад хэлье гэж бодож байгаа юм. Өнөөдөр бол ингээд хаа хамаагүй хүнийг гүтгэж байна. Яах ч үгүй байна. Прокурор, цагдаа дээр очоод хэрэгсэхгүй болчхож байна. Энэ болохгүй. Яагаад болохгүй гэж. Би ингэж бодож байна шүү дээ. Энэ залуу хүмүүс тэгж бодох байх гэж. Хулгай хийсэн, хийгээгүй ялгаагүй юм байна гэж эцэстээ бодогдож байна шүү дээ. Хулгай хийхгүй явлаа гэхэд харлуулсаар байгаад л хулгайч болгож байна шүү дээ. Тэгээд хүн эцэстээ юу гэж бодох юм. Хулгай хийхгүй байх, хулгай хийх 2 ялгаагүй юм байна гэж бодогдож байна шүү дээ. Энэ чинь аюултай шүү дээ. Бүгдээрээ тийм болчихвол энэ улс орон чинь яах юм бэ. Тийм учраас бас адилхан харлуулаад байгаа явдлыг та нар зогсоолгохын тулд, ялангуяа та нар прокуроруудын хувьд энэ хүн гүтгэж байгаа асуудлыг зогсоо. Монголд нэг ч лидер төрөхгүй шүү. Монголчууд итгээд авч явах тийм улс төрч төрөхгүй. Бүгдийг гүтгэж чадаж байна шүү дээ. Юу ч гэж гүтгэж чадаж байна. Тэгээд өгчхөж байна. Очихоо очоод шүүх дээр очоод зарим нь юу гэж байна вэ. Баяраас авхуулаад нүдний хагалгаанд орсон юм харахгүй байна гээд ингээд шүүх дээр очихгүй байна. Тэр Цэцгээ гэж хүүхэн нь зугтаад алга болчхож байна. Намайг баахан сүүний үйлдвэр идлээ гэж ярьсан шүү дээ. Улс орон даяар. Тэгээд баримтаа бариад оч гэхээр очихгүй байна шүү дээ. Зугтчихаж байна. Тэгэхээр ийм байж ерөөсөө таарахгүй. Ийм л байх юм бол Монголын улс төр хэзээ ч цэвэр болохгүй. Хүн тэгж бодно шүү дээ. Хулгай хийх, хулгай хийхгүй байх 2 адилхан юм гэж бодох байхгүй юу. Энэ буруу жишгийг ерөөсөө тогтоож болохгүй.

Тийм учраас та нар хүн гүтгэж байгаа асуудал дээр энэ цагдаа хүчний байгууллагаар шалгуулж байгаа асуудал дээр бас жоохон хатуухан байр суурьтай байж өгөөч гэж би бүр хүсэж байна шүү. Тэгэхгүй болохгүй. Үүний муу үр дагавар тэр шүү. Хулгай хийх, хулгай хийхгүй байх 2 ижилхэн. Ийм буруу .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүн үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж үг хэлье.

О.Цогтгэрэл: Прокурорын байгууллага гэдэг байгууллага Монгол Улсын бас хуулийн хэрэгжилт, тэр тусмаа шүүхээр шүүх хүртэл асуудал үргэлжлээд гэм буруугийн асуудал шийдэгдэх хүртэл бүхий л тэр мөрдөн байцаалтын гэгддэг бүхий л үйл ажиллагаанд анхнаас нь хяналт тавьдаг ийм бас онцгой эрхтэй, оролцогч онцгой эрхтэй ийм байгууллага.

Тэгэхээр Ерөнхий прокурорт нэр дэвшигч одоогоор 6 жил ажилласан Жаргалсайхан прокуророос бас тодорхой тоо баримттай асуулт би асуух гээд байна л даа. Тэр нь хэд хэдэн тоонууд байна.

1 дүгээрт нь Монгол Улсад нийтдээ хэчнээн гомдол маргааны санал ирдэг вэ. 1 жилийн дотор, 1 жилийн хугацаанд гээд ингээд харьцуулаад харвал.

2 дугаарт нь эндээс хэчнээн нь хэрэг бүртгэл болж явдаг вэ.

3 дугаарт нь хэчнээн иргэн эндээс яллагдагчаар гэм буруутай байж магадгүй гэж үзэгдэж, яллагдагчаар татагддаг вэ. Бүр нэлээн та бүр онцгойлон хариулж өгөх

тоо нь энэ яллагдагчаар татагдсан иргэдээс хэчнээн нь шүүхээр орж гэм буруутай гэж үзэгддэг вэ. Тэр шүүхийн байгууллага дараа дараагийн үе шатдаа давж заалдаад яадаг ийдэг нь прокурорын байгууллагаас гэхээсээ шүүхийн процесс байх. Тэгэхээр тэр шүүх хүртэлх процессыг та энийг хувь хэмжээгээр нь 1 дүгээрт нь, 2 дугаарт нь хувь хэмжээнүүд өөрөө олон улсын байгууллагууд тэр тусмаа ардчилал, хүний эрхийг дээдэлдэг улс орнуудад тоонууд ер нь ямар байдаг юм. Би эндээс зүгээр таныг бас тодотгож хэлж өгөөсэй гэж хэлэх гээд байгаа нь нийт тэр яллагдагчаар татагдсан иргэд, тэр тусмаа яллах дүгнэлт үйлдүүлсэн иргэдээс хэчнээн нь шүүхээр гэм буруутай гэж үзэгддэг. Үүний цаана чинь 2 тооны агуулга харагдах гээд байгаа юм. Хэрвээ яллагдагчаар татагдаад хэдэн 10 жил хэдэн жилээрээ баахан наана цаана явж явж шүүхээр гэм буруугүй гэж үзэгдвэл энэ өөрөө прокурор ажлаа муу хийсэн асуудалтай холбогдох уу, холбогдохгүй юу.

Аль эсвэл үүний цаана тодорхой хэмжээний хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдсан, хүний эрх зөрчигдсөн асуудал статистикийн цаана агуулагдах эсэх тухай л гол нь тодруулж асуух гээд байгаа юм. Мэдээж энийг бүгдийг нь яллаад явуулаад бай гэдэг агуулга үүний цаана байхгүй. Тэгэхдээ энэ статистикуудын цаана 1, 2 тохиолдлыг бид нар нийгмээрээ зөндөө л барьж аваад ярьдаг. Нэгдсэн улсын хэмжээний статистик олон улсын дунджаас харахад өөрөө Монгол Улс үүний хаах нь яваа вэ гэдэг. Мэдээж бас яагаад ингэж асууж байна вэ гэхээр Ой си ди олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан дүгнэлт авлигын эсрэг Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт дээр тодорхой хэмжээнд хуулийн байгууллагуудын олон олон оноо, олон олон зүйлүүд ингээд л хойш татаж байгаа олон зүйлүүд үүний цаана байдаг. Тодорхой индекс 4, 5 үзүүлэлтүүд хамгийн бага оноотой 4, 5 үзүүлэлтүүд харагдаж байна лээ. Илчлэгчийг хамгийн бага хамгаалдаг тогтолцоо үүний цаана Монгол Улсад байна. Шүгэл үлээгч гэж хэлдэг. Прокурорын байгууллагын хараат бус байдал хэт төвлөрсөн байна. Тэр нийтийн албан тушаалтнуудын ашиг сонирхолд оролцох байдал гээд олон олон зүйлүүд байна лээ. Тэгэхээр энэ бүгдийн цаана бас би саяын тэр нэгдсэн том статистикийн асуудлыг ярих ёстой байх гэж бодож байгаа юм. Тэгээд та саяын тоонууд дээр тэр тусмаа тэр яллагдагч яллах дүгнэлт авсан иргэдээс шүүх дээр гарч байгаа шийдвэрийн талаар бүүр онцгойлон та 1 тоо хэлж өгөөч.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Гэмт хэргийн нөхцөл байдал бол сүүлийн 5 жилээр аваад үзэхэд өсөж байгаа. Тогтмол. Энэ зөрчил дээр ч ялгаа байхгүй. Би зүгээр товчхон жишээ хэлэхэд л зөрчил 1 сая орчим байсан 2019 онд. Өнөөдөр 3 сая 300 байна.

Эрүүгийн хэрэг дээр би зөвхөн 2024 оноор нь тооцож хэлье. 126 мянган гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл ирсэн. Эндээс 74 мянга нь хэрэг бүртгэлтийн хэрэг, 28 мянга нь мөрдөн байцаалтын хэрэг. Эндээс 15.969 хэрэг шүүхэд шилжсэн. Шүүхээр 15.123 хэрэг шийдэгдсэн. Үлдсэн хэсэг нь хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна гэсэн үг. Энэ дотор түрүүн бас Энхбаяр гишүүн ч бас ярьж байсан. Прокурор ерөөсөө ганцхан нотлох баримтыг цуглуулдаг, яллах чиглэлийн хүн биш. Би ганцхан 2024 оны тоогоор хэлэхэд 103 хүн цагаатгасан. Энэ бол прокурорын үйл ажиллагаатай холбоотой асуудал биш. Энийг нөгөө талаас нь харах юм бол прокурор бас хүнийг цагаатгах нотлох баримтыг, мөн гэм буруутай нотлох баримтыг цуглуулж, шүүхэд шилжүүлж, шүүх тэр цагаатгах нотлох баримт дээр нь үзэж хэргийг цагаатгасан байна л гэж ингэж үзэж байгаа юм. Тийм учраас дан ганц

прокурорын байгууллага, прокурор хүнийг яллах талаа барьдаггүй. Яллах, цагаатгах нотлох баримтыг адил тэгш цуглуулсан хэргийг л шүүх рүү шилжүүлдэг.

Та индексгүй холбоотой асуудлууд ярилаа. Тийм ээ, прокурортой холбоотой, хуулийн байгууллагатай холбоотой индексгүй асуудлууд бий. Манай Монгол Улсын үндсэн индексгүй холбоотой асуудал Ази Номхон далайн бүсэд харьяалагддаг. Дундаж үнэлгээ нь 44 байдаг. 2024 оны үнэлгээгээр 33 оноо авсан. 2023 онд ОУБ 7 эх сурвалжаас 2024 онд 8 эх сурвалжаас авсан. Энэ дотор 1 л зүйлийг хэлж байгаа юм. Хууль, эрх зүйн орчноо олон хэм хэмжээ тогтоосон актаа хуульчлаач ээ л гэдэг ийм шаардлагыг тавьж байгаа юм. Тийм учраас прокурорын байгууллага олон улсын индексд үнэлэгдэхгүй байгаа, буурч байгаа энэ шалтгаан нөхцөл дээр хуулийг боловсронгуй болгох хэм хэмжээг багасгаж, хуульчлах .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу. Жаргалсайхан прокурорын микрофоныг өгье.

Б.Жаргалсайхан: Даваасүрэн гишүүний хариулт гэж ойлголоо. Даваасүрэн гишүүнтэй 2022 онд билүү, би яг энэ танхимын голд сууж байх үед та миний өмнөөс Бат-Эрдэнэ гишүүнтэй хамт хараад сууж байсан. Та 3 асуудал надад ярьж байсан. Миний санаж байгаагаар Сүхбаатар дүүрэг дээр 2 асуудал байсан. 1 асуудал нь Улсын ерөнхий прокурорын газарт гомдол гаргасан байсан. Би танд 1 зүйлийг л хэлсэн. Мөрдөх байгууллага шалгаж тогтоосон, нотлох баримт цуглуулсан тэр зүйл дээр шалгаж байгаа мөрдөгч, хянаж байгаа прокурор 2 л дүгнэлт гаргадаг. Тэр дүгнэлтээр л асуудлыг шийдсэн гэж би ингэж ойлгодог. Одоо дахиад энэ асуудал ингээд ярьж байх үед би дахин бас одоо яг миний ард Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга сууж байна. Энэ гомдлуудыг нийлүүлж үзье.

Тэгэхдээ би тантай нэг зүйл дээр санал нэг байгаа юм. Маш олон гүтгэлэг маш олон хүнийг харлуулсан ийм үйл явдлууд болж байна. Энэ хурлын танхимд сууж байх үед надад 1 зүйл байна. Тэр зүйл юу гэвэл Австралид троллын хууль гэж 2021 онд батлагдсан. Энэ хуулиар маш олон асуудлыг шийдсэн. Бид бас энэ асуудал руу орохгүй болохгүй. Ер нь бол хэвлэлийн эрх чөлөө, хувь хүний эрх чөлөө гэдэг асуудал бол хэлсэн үгээ ухамсарладаг байж байж эрх чөлөө тэнцвэрээ олдог.

Тийм учраас таны ярьсан зүйл дээр би дахиж бүх гомдлуудыг үзэж, эргэж хариу өгье. Тэрэнтэй холбоотой зүйлүүдийг эргэж харж байж л хэлнэ. Одоогоор бол шууд хэлэх боломж алга байна. Ингээд 2 асуудлыг танд эргэж мэдэгдье.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Ганхуяг: Жаргалсайхан прокурорыг дэмжиж байна. Бас яалт ч үгүй бид нар бүгдээрээ л сонгуульд дэвшихдээ шударга ёсыг тогтооно, авлигатай тэмцэнэ гээд бүгдээрээ амлалт өгсөн. Тэгээд Ерөнхийлөгч нь бас нүдээ олсон хүнээ санал болгосон юм байна гэж би харж байгаа. Гагцхүү энэ дээр 2, 3 асуулт ч юу байх вэ дээ санал л юм даа. Сүүлийн үед ээж маань загнаад байгаа юм. Үгүй ээ, та нар чинь шударга ёсыг тогтооно гээд л энэ хувийн хэвшил чинь татвар гээд л нугаслуулаад л байдаг. Тэгээд л ингээд л зурагтаар харахаар нэг нөхөр татвараас зугтаачихсан ч юм шиг, тэгээд шалгаж болдоггүй юм уу гээд нэг асуулт асуугаад байгаа юм.

Ингээд Төгрөг нуурын асуудал ингээд л сая нэлээн хүчтэй яригдаж байна. Засгийн газрын байр суурь юм болов уу гэж би хараад байгаа юм. Мэдээллийг сонсохоор татвараас зайлсхийсэн байх болзошгүй ийм мэдээлэл сонсогдоод байгаа юм. 3, 4 оффшороор дамжуулаад, мөнгө угаасан байж болшгүй харагдаж байгаа. Бид нар чинь төрийн өндөр албан тушаалтан дээр оффшортой холбоотой нэлээн хүнд заалт байгаа шүү дээ. Тэгээд дээр та бол Улсын ерөнхий прокурор бусад орнуудаас мэдээлэл авах бүрэн боломжтой. Тэгээд би энэ хүнийг зүгээр асуудлыг нь гаргаад ингээд ярь гээд байгаа юм биш. Тэгэхдээ яг үнэн зөвийг нь тогтоогоод өгөөч ээ л гэдэг асуудал хэлэх гэсэн юм. Үнэн зөвийг нь. Үнэхээрийн энэ хэвлэл дээр явж байгаа нь үнэн юм уу, эсвэл үгүй юм уу. Бас бүгдээрээ нэг тийш нь болгохгүй л бол жишээ нь ингээд л өдөр болгон өөр мэдээлэл гарна. Өдөр болгон өөр мэдээлэл гарна. Тэгээд дээр бас таныг нэг анхааралтай ажиглаад мэдээллийг шалгаад, шалгах ёстой бол шалгаад өгөөч ээ л гэдэг хүсэлтийг хүсье. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт юу гэхээр бид нар чинь бүгдээрээ шударга ёсыг тогтооно. Та бол одоо шударга ёсны манаан дээр гэх үү байгаа хүн. Өнөөдөр бид нар авлигын индекс ярьж байна. Улс төрийн талаас нь бид нар аль болох төрийн оролцоог багасгах, төрийн өмчит компаниудын оролцоог багасгах, татварын таатай бодлого явуулах, тэр авлигын хөрс суурь дээр нь бид нар танд тусалж ажиллана. Хөрс суурь дээр нь. 1 ёсондоо авлига авах тэр сонирхлыг нь бууруулах тал дээр, авлига төрүүлэхгүй байх тал дээр нэг ёсондоо бид нар хууль, эрх зүйн тал дээр нь ажиллая. Та харин яг өмнөх 6 жил ажилласан шигээ хэн нэгний нөлөөнд автахгүйгээр яг энэ шударга ёсныхоо тэмцэлд тууштай тэмцээрэй л гэж танаас хүсье.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Олон улсын байгууллагууд тэр тусмаа прокурорын байгууллага өөрийн ижил байгууллагуудтай холбоотой ажилладаг. Энэ ажлынхаа хүрээнд тодорхой мэдээллүүдийг бас авдаг. Харилцаа улам өргөжиж байна. Өргөжсөн ажлын 1 үр дүн нь юу вэ гэвэл онд Прокурорын холбооны олон улсын прокурорын холбооноос Зүүн Европ, Төв Азийн 10 дугаар хурлыг Монгол Улс зохион байгуулах гэж байгаа юм. Энэ 6 дугаар сард. Энд бол яг прокурорын хяналтын үр нөлөө, цахим гэсэн ийм сэдвээр зохион байгуулагдах юм. Энэ дээр яг таны ярьсан хамтын ажиллагаа, мэдээлэл авах зүйлүүд бас яригдана. Энэ зүйлээр бид өөрсдийн үйл ажиллагаагаа өргөжүүлж байгаа юм. Бидний хамгийн ойрхон холбогддог, бас холбоотой ажилладаг прокурорын газар БНХАУ-ын Прокурорын газар. Энэ чиглэлээр бид олон прокуроруудаа тэнд сургаж байна. Цахим гэмт хэрэг, тэгээд энэ оффшор, БНХАУ-ын прокурорын газар бол энэ оффшортой холбоотой чиглэлээр нэлээн мэргэшсэн. Тэр дотроо бас үнэт өвтэй холбоотой зүйлүүд дээр нэлээн мэргэшсэн. Тэгээд энэ чиглэл рүү бид нар хамтын ажиллагаагаа өргөжүүлж байгаа. Энэ чиглэлээр бид нар бас нэлээн тодорхой ажлуудыг хийнэ. Энэ 8 дугаар сард БНХАУ-ын Ерөнхий прокуророос айлчилъя гэж байгаа юм. Тэгээд чиглэлээрээ бид бас тодорхой ажлуудыг мөн Вьетнам Улсын ерөнхий прокурор айлчилна гэж байгаа. Энэ чиглэлээрээ бас тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөсөн байгаа. Тийм учраас таны ярьсан энэ зүйлүүд дээр нэлээн ахицтай зүйлүүд гарна. Олон улсын харьцааны чиглэлтэй та асуусан учраас би сая айлчлалтай холбоотой, Бага хуралтай холбоотой асуудлыг ярилаа.

Д.Амарбаясгалан: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууя.

Л.Энх-Амгалан: Монгол Улсын ерөнхий прокуророор дахин томилогдохоор орж ирж байгаа Жаргалсайхан прокурорт би амжилт хүсье гэж бодож байна. Надад асуух асуулт алга. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх Ерөнхийлөгчийн хүн засагладаггүй, хууль засагладаг төрийг бий болгоно. Баялагтаа эзэн Монгол гэсэн хөтөлбөр, мөн Монгол Улсын Ерөнхий сайдын эхлүүлсэн 5ш үйл ажиллагаа бол тодорхой үр дүнд хүрсэн гэж харж байгаа юм. Энэ дээр АТГ-ын дарга, Прокурорын ерөнхий газрын удирдлагуудын гүйцэтгэсэн үүрэг бол нэлээн их байсан. Жин дарах байсан гэж би хэлэхийг хүсэж байгаа юм. Би яагаад ингэж хэлэхийг хүсэж байна вэ гэхээр тоо худлаа ярьдаггүй. Миний өмнө АТГ-ын болон прокуророос зарласан тоонууд байна. 2019 оныг 2023 онтой харьцуулахад мөрдөн шалгах ажлын хүрээнд шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээ 2 дахин өссөн. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн хэмжээ 2,8 дахин өссөн. 2019 онд шүүхээр шийдвэрлэх хэрэг 68 байсан бол 2023 онд 192 болсон. Шүүхэд шилжүүлсэн хэрэг 2019 онд 156 байсан бол өнөөдөр даруй 325 болсон. Энэ бол мөрдөн шалгах ажлын хүрээнд маш их том дэвшил гарсан байна гэдгийг бол манай ард иргэд маань ойлгож мэдрэх болов уу гэж бодож байна.

Хохирлын нөхөн төлүүлэлд. 2007-2020 он 13 жилийн дотор 13 жилийн хугацаанд 95,5 тэрбум төгрөгийн хохирол төлүүлдэг байсан бол 2021 онд 96,2 тэрбум, 2022 онд 2,3 их наяд, 2023 онд 238 тэрбумтай тэнцэх хэмжээний авлига, албан тушаалын гэмт хэргээс үүссэн Монголын төрд учирсан хохирлыг төлүүлсэн байна. Энэ бол би том амжилт гэж ойлгож байгаа. Тэгэхээр манай ард иргэд маань шударга ёсны хүсэмжлэл их байгаа шүү дээ. Ард иргэдийн цөөхөн хэсэг нь хуулийн дээр амьдардаг, олонх хэсэг нь хуулийн доор амьдардаг нэг ийм нийгэм баймааргүй байна.

Шударга ёсны өлсгөлөн бол ходоодны өлсгөлөнгөөс их илүү их харгис өлсгөлөн байдаг юм гэсэн. Тэгэхээр ард иргэдийн шударга ёсны хүсэмжлэлийг л хэлээд байгаа юм. Тэгэхээр цаашдаа таны хийсэн тэмцлийнхээ үр дүнг улам үргэлжлүүлэх ийм боломж таны өмнө бас нээгдэж байна гэж би харж байна. Мэдээж эрх зүйн хувьд бид нар бас тодорхой шинэчлэлүүдийг хийх нь зайлшгүй.

2-т би Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болоод тантай бас уулзаж, өнөөдөр Нийгмийн даатгалын сан дээр үүсчихсэн байж байгаа өр авлагуудын асуудлаар тантай санал солилцсон. Танд би талархал илэрхийлье. Бас тодорхой шийдлүүд та надад гаргаж өгсөн. Үүний үр дүнд өнгөрсөн 3 сарын хугацаанд 22,3 тэрбум төгрөгийн бас өр төлбөр барагдсан байна. Энэ бол үр дүн. Тийм учраас өнгөрсөн 7 хоногт томилогдсон Дашдаваа дарга, Ерөнхий прокурор тантай ингэж хамтарч, өнөөдрийн үүссэн байгаа үлдсэн байгаа Чингис хаан, Капитал банк дээр үүссэн энэ өр төлбөрийг барагдуулахад хамтарч ажиллаж, иргэдийн даатгуулагчдын өмнө хохирсон байгаа одоогийн байдлаар үлдэгдэл дээр 156 орчим тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулах зайлшгүй ийм шаардлага бид нарт байна. Ийм үүргийг бид нар хүлээх ёстой гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ дээр мэдээж хууль хяналтын байгууллагууд тэр тусмаа прокурорын байгууллагуудын гүйцэтгэх үүрэг маш их. Би яагаад энийг хэлж байна вэ гэхээр АТГ-аас зарласан энэ банкнуудтай холбоотой үнэ цэнтэй үл хөдлөх хөрөнгүүд шүүхийн явцад эзэд нь солигдсон. Зарим нь нуугдмал хөрөнгө болсон. Энэ мэдээллүүдийг би бас танд хүргэж, энэ чиглэлээр бас та тодорхой хүмүүст үүрэг даалгавар өгч, манай 2 байгууллага бас нэлээн сүүлийн үед хамтарч ажиллаж байгаад би бас талархаж байна. Тийм учраас ирэх жилүүдэд Авлигатай тэмцэх газар, Прокурорын байгууллагуудтайгаа хамтарч Чингис хаан, Капитал банк дээр

үүссэн энэ өр төлбөрийг барагдуулахад та манлайлан ажиллана гэдэгт бас би итгэж байна. Ингээд танд амжилт хүсье гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Гонгорын Дамдинням гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе. Жаргалсайхан прокурорыг хувь гишүүнийхээ хувиар дэмжиж байгаагаа илэрхийлье. Мэргэжлийн хүн яах аргагүй прокурорт олон жил ажилласан, насаараа гэж хэлж болох ийм хүн дахин дэвшиж орж ирж байгаад бол таашаалтай хандаж байгаагаа илэрхийлье. Тэгээд хэд хэдэн асуулт байна.

1 дүгээрт прокурорын хараат бус байдлын талаар өнгөрсөн хугацаанд та ямар ажил хийсэн бэ. Тэрийг ирээдүйд яаж нэмэгдүүлэх вэ гэдэг тал дээр асуулт асуумаар байна. Өчигдөр жишээгээр МАН-ын бүлэг, АН-ын бүлгээр ороод мэдээллээ өгчихсөн байх. Би Үндэсний эвслээс сонгогдсон. Бүлэггүй гишүүний төлөөлөл учраас энэ талаар мэдээлэл авах гэсэн юм. Ялангуяа орон нутаг, 21 аймаг, 9 дүүрэгт бол прокурорын байгууллагын техник, тоног төхөөрөмж нь ямар байдаг юм. Хангамж нь ямар байдаг юм. Цалин хөлс нь ямар байдаг юм. Хөдөө орон нутгаас ирж байгаа мэдээллээс харах юм бол аймгийн цагдаа, шүүх, дээрээс нь нутгийн удирдлагын байгууллагатай нэг кармандаа орчихсон байх магадлалтай байдаг гэдэг иргэдийн итгэл, ойлголт сул байдаг гэдэг ийм мэдээлэл байдаг. Та дээр байр сууриа илэрхийлнэ үү.

2 дугаарт Ардын нам, АН 2024 оны Улсын Их Хурлын сонгуулиар нэг нь нэгнийгээ хулгайч нам, нэг нь нэгнийгээ алуурчин нам гээд л баахан хэвлэлээр шуугьсан. Тэгээд уг нь бол хувь хүнийхээ зүгээс би прокурорын байгууллага парламент руу орж дэмжлэг авдаг нь хэр зөв байдаг юм бол. Бусад гаднын туршлага ямар байдаг юм бол. Ерөнхийлөгчийн институц оруулж ирнэ гээд хуультай. Парламентаар батламжилна гээд хуультай байгаа нь яах аргагүй манай өнөөгийн нөхцөл байдал. Гэхдээ бусад оронд ялангуяа хараат бус шийдвэр гаргах хуулиар хүлээсэн үүргээ бие дааж хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлдэг юм болоо гэдэг дээр тодорхой хариулт өгнө үү.

Сошиалаар асуулт яваад эхлэхээр зэрэг хэрэг үүсдэг ийм ойлголт иргэдийн дунд бас байна. Олон жил ингээд л хуримтлагдсан асуудлууд явж байгаад л яг олон нийтийн сүлжээгээр нэг хүн ялангуяа улс төрч хүмүүс гаргаж тавьсны дараагаар ямар нэгэн хэрэг үүсдэг энэ тохиолдлууд хэр олон байдаг юм бол. Энэ дээр та яг өөрийн хувийн байр сууриа бас тодорхой бид нар чинь ард түмний төлөөлөл учраас бас асууж байгаа хүмүүс байдаг. Энэ дээр бас товч бөгөөд ойлгомжтойгоор хариулт өгнө үү гэж хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эхний асуултад Занданшатар дарга хариулъя. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Занданшатар: Энэ маш чухал асуулт асуулаа. 1 дүгээрт өмнө манайд мөрдөгдөж байсан практикаар Дээд шүүхийн тайлбараар байх. Зөвшилцөх гэдгийг зөвхөн санал авах гэж үзээд, Улсын ерөнхий прокурорыг томилохдоо Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд танилцаад, дэмжсэн, дэмжээгүй хамаагүй санал бичгээр ирсэн бол шууд томилдог практиктай байсан. Манайхтай ижил төстэй Үндсэн хуультай Финлянд мэтийн улсуудад Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурор ер нь ийм

нийтлэг холимог засаглалтай улсуудад бас Ерөнхийлөгч улс төрийн намаас түдгэлздэг институт албан тушаалтныхаа хувьд улс төрөөс хараат бус томилгоо хийх агуулгаар ийм томилдог практик жишиг бас түгээмэл бий. Ер нь парламентын хяналтыг бий болгох үүднээс парламентаас прокурорыг 1 удаа буцааж болох, дараа нь өөр хүн оруулж ирнэ гэсэн агуулгатай заалт 2017 оны прокурорын тухай хуулиар нэмэгдэж ороод, ингээд ийм санал хураалттай болсон ийм жишиг манайд одоогоор мөрдөгдөж явж байна. Ер нь бусад улсуудын Ерөнхий прокурор бол төрийн нэрийн өмнөөс одоогийн Прокурорын тухай хуулийн 20-д заасан төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлдөг төрийн хууль цаазын гол зөвлөх субъектийн хувьд харьцангуй бие даасан үйл ажиллагааг хангахын тулд улс төрөөс хараат бус байх зарчмуудыг мөрдлөг болгож ерөнхийдөө ийм хэрэг төвөг яриад байдаггүй. Ер нь нэг ийм жигд тогтвортой байдлыг хангасан томилгоонуудыг хийдэг жишиг нийтлэг улсууд мөрдөгддөг. Тэгэхдээ одоо мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн хүрээндээ л бид жишгийг баримталж явж байна.

Дахин хэлэхэд Прокурорын хуулийг улам боловсронгуй болгох, хууль, эрх зүйн шинэчлэл хийх нь хууль тогтоогчдын бүрэн эрхийн асуудал.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон өгье.

Б.Жаргалсайхан: Гишүүний асуултад хариулъя. Би хариулахдаа 2 дахь асуултаас бас тодорхой олон улсын жишигтэй холбоотой асуудал ярьсан учраас энэ дээр бас нэмэлт тайлбар хэлье гэж байгаа юм. Дэлхийн 193 орон байна. Энэ 193 орноос 89 нь Ерөнхийлөгчөөс, 33 нь парламентаас, 12 нь Засгийн газраас, 18 нь тодорхойгүй, үлдсэн хэсэг нь шүүх гэсэн ийм зарчмаар ер нь томилогдож яваа юм. Яг манай Монгол Улсын хэмжээнд одоо яг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар бол олон улсын жишигт парламенттай зөвшилцдөг нь яг энэ 93 улсын 50,8 хувь нь байгаа юм. Ийм жишгээр дэлхийн улс орнууд бас явж байна..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Нэгдэх асуудал бол прокурорын байгууллагын бие даасан, хараат бус байдлын тухай ярьсан. Бие даасан, хараат бус байдлын хамгийн гол зүйлүүд бол улс төр, хувийн ашгаас ангид байх, олон нийтийн нөлөөллөөс ангид байх, нийгэм эдийн засгийн болон хууль зүйн баталгаагаар хангагдсан ийм л байж байж бие даасан, хараат бус байдал яригддаг. Прокурорын байгууллагын хувьд парламент, Засгийн газар бүхий л талаар Ерөнхийлөгчийн институт, прокурорын бие даасан, хараат бус байдал дээр нэлээн арга хэмжээ авч өгсөн.

Одоо бол боломжийн цалинтай, боломжийн байртай, боломжийн техник хэрэгсэлтэй болсон. Энэ тал дээр ямар нэгэн асуудалгүй болсон. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гардаг..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд улиран ажиллах гэж байгааг бол дэмжиж байгаа. Зарчмын хувьд. Энэ хугацаанд мэдээж алдаатай оноотой юм байсан. Гэхдээ алдаанаасаа оноо нь илүү. Шударга, ёс илүү байсан, хууль дээдлэх ёс илүү байсан гэж дүгнэж байгаа. Тэгээд би өмнө нь бүлэг дээр бас танаас асууж байсан. Мэдээж хүний эрх, эрх чөлөөг 1 дүгээрт тавиарай. Бид бол хууль ёсоо дээдэлдэг ч гэсэн хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийг ярих юм бол

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх чөлөөний асуудал бас яригдана. Тэгэхээр тэр хүмүүсийн мөрдөн байцаалтын явцад, прокурорын явцад, шүүх явцад бүгдэд нь, тэр хүмүүсийн эрх, эрх чөлөөг сайн хангаж ажиллаарай гэж хүсье.

Тэгээд 2 дугаарт бид нар хууль тогтоох дээд байгууллагын хувьд ер нь өнөөдөр прокурорын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа юу гэдэг 1 асуулт асууя. Яагаад гэвэл Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн заалт дээр маш тодорхой тусгасан байдаг. 25-аас дээш ажиллагсадтай бол 25 хүн тутамд 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилд авна гэсэн заалт байдаг. Хэрвээ ажиллуулаагүй тохиолдолд тэр хэмжээгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр хураамж төлөх ёстой. Тэгэхээр дээр та яг тодорхой тоо хэлээд өгөөч. Би хууль тогтоох дээд байгууллага гэдэг утгаар нь хуулиа түрүүлж биелүүлдэг байгаасай гэдэг үүднээс асууж байгаа юм. Хэрвээ энэ тоо хүрдэггүй бол энэ тоог заавал хүргэж ажиллаарай гэж шаардаж байна. Тэгээд та тэр тоон дээр нэг мэдээ хэлээд өгөхгүй юу.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон өгье. Жаргалсайхан прокурор хариулт өгье.

Б.Жаргалсайхан: Гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр прокурорын байгууллагад 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Та хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, дээр нь бас ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой тийм зүйлүүдийг бас давхар ярилаа. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа дээр мөрдөх байгууллагууд дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хэрэг материалын тоог танд би гаргаж өгнө. Надад байж байгаа бодит 1 тоо юу гэвэл өнөөдөр Монгол Улсад ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 266 иргэн байна. Энэ иргэд дээр прокурорын байгууллага өөрийнхөө хяналтынхаа чиг үүргийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дөхөм болохуйц өөрт нь шаардлагатай бүхий л зүйлийг бид бас шаардлага тавин ажиллаж байгаа. Шийдвэр гүйцэтгэх байгууллага ч чиглэлээр ажиллаж байна. Сүүлийн үед бие даасан, хараат бус байдал, ажиллах нөхцөл бололцоо гэдэг зүйлүүдийг ярьсан. Прокурорын байгууллага ажиллах нөхцөл бололцоогоо хангахын зэрэгцээгээр прокурорын байгууллагын үндсэн ажлын байрууд дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээж авах, орж гарах ийм нөхцөл бололцоог бүгд биелүүлсэн байгаа гэдгийг би бас танд хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхий прокуророор улируулан томилж ажиллах талаар Их Хуралтай зөвшилцөхөөр Жаргалсайхан прокурорыг оруулж ирж байна. Манай олон гишүүд, хуульч гишүүд асуулт асууж, санал хэллээ. Аль болохоор би давхцалыг арилгая.

Жаргалсайхан прокурорыг дэмжиж байгаа. Дэмжихийн учир юунд байна гэхээр зэрэг прокурорын орон нутгийн байгууллагаас ажлын гараагаа эхэлж, 37 жил байгууллагадаа ажиллаж, Ерөнхий прокурор хүртэл өсөн дэвшиж ажилласан байна. Тийм учраас прокурорын байгууллага, түүний чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг нь ер нь том дүр зургаар нь бүрэн харж чадах тийм хэмжээнд мэргэжлийн ур чадвар, ёс зүй төлөвшсөн хүн юм байна.

2 дугаарт хэн нэгний нөлөөнд автаад байхааргүй хараат бусаар ажиллах тийм хуульч хүний хат, үнэт зүйл суусан хүн юм байна. Тийм учраас тийм үе насан дээрээ ч байгаа хүн юм байна. Тийм учраас хүнийг улираан томилох саналыг дэмжих ёстой гэсэн ийм тов тодорхой байр суурьтай байна гэж.

2 дугаарт 1 зүйл байна. Эрүү, зөрчлийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага. Тийм учраас чиглэлийн эрх зүйн орчны урьдчилан сэргийлэх гэдэг юм уу ухамсар төлөвшлийнх нь асуудал хүмүүст хэрхэн суухаар тийм эрх зүйн орчин байна вэ. Бид нар энийг боловсронгуй болгох чиглэл дээр бид ер нь цаашид юунд анхаарах ёстой болоо гэж. Би ингэж бодоод байдаг. Аливаа хууль тогтоомж гэдэг бол нийгмийн харилцаа зохицуулахаасаа гадна бас урьдчилан сэргийлэх гэдэг юм уу, төлөвшлийн гэдэг юм уу ийм үр нөлөө нь бас явах ёстой. Энэ талаасаа ер нь ямар байгаа бол гэж. Шүүн таслах ажиллагааны хүмүүжлийн үр нөлөө гэж дээр их ярьцгаадаг байсан бид нар төрийн нэрийн өмнөөс чиглэлийн үйл ажиллагаанд оролцож байгаа үндсэн чиг үүрэгтэй байгууллага танай байгууллага. Тийм учраас шүүн таслах ажиллагааны үйл явц, түүний нөлөөллийн талаар ер нь таны байр суурь, бодол ямар байна вэ. Нэг ийм зүйл дээр тодорхой хариулт мэдээлэл аваадахъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон өгье. Жаргалсайхан прокурор хариулт өгнө үү.

Б.Жаргалсайхан: Гишүүний асуултад хариулъя. Хуультай холбоотой зүйл дээр хууль, эрх зүйн орчин хамгийн чухал. Энэ зүйл дотор тэр тусмаа хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллаж байгаа прокурорын хувьд хууль нэг утгаар ойлгогддог, салаа утгагүй ийм л хууль байх ёстой юм.

2 дахь нь Монгол Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан даргын олон яриаг сонсож байсан. Хэм хэмжээ тогтоосон энэ актууд хүний эрхийг зөрчдөг хамгийн гол актууд. ОУБ-ын индексээр ч, шаардлагаар ч, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудыг хуульчил гэдэг ийм шаардлага тавьдаг. Тийм учраас хэм хэмжээ тогтоосон актуудыг хуульчлах зайлшгүй ийм шаардлага байгаа юм.

Дараагийн нэг гол зүйл юу гэхээр хуульд хамгийн тодорхой биш байдаг нэг заалт юу гэвэл бүх хуульд бусад гэдэг үг ордог. Энэ бусад гэдэг үг хүний эрхийг зөрчдөг хамгийн олон уутыг багтаасан ийм заалт байдаг юм. Тийм учраас хуульд тодорхой байх ёстой зүйлүүд дотор ийм зүйлүүд бас прокурор өөрийн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахад байдаг юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр прокурор өөрийн тодорхой үүргүүдээ хүлээдэг. Нэгж прокурорын газарт нэгдсэн ерөнхий прокурорын газартаа бодлого тодорхойлж ингэж ажилладаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл гэж манайд ажилладаг. Дээр нь Хууль зүйн яаман дээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд Монгол Улсын прокурорын орлогч прокурор орж ажилладаг. Прокурор энэ урьдчилан сэргийлэх ажил дээр гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг арилгуулахаар мэдэгдэл бичиж ажилладаг. Таны асуултад хариулж дууслаа.

Д.Амарбаясгалан: Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Мөнхбаатар: Жаргалсайхан Ерөнхий прокурорыг Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд улируулан томилуулахаар Улсын Их Хуралд оруулж ирж байна. Өчигдөр Улсын Их Хурлын бүтцийн байгууллага болох

Монгол Ардын намын бүлэг, Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж дэмжсэн. Өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар ингээд хэлэлцэж байна. Ер нь Монгол Улсын ерөнхий прокурорын хувьд бол хариуцсан ажлаа өнгөрсөн 6 жил хэрхэн гүйцэтгэсэн ажлынх нь үр дүн, ажлын туршлага, мөн төрийн ажлынх нь гүйцэтгэл, хувь хүнийх нь ноён нурууг харгалзан үзээд Монгол Улсын Ерөнхийлөгч улируулан томилох нь зүйтэй гэж үзэж, энэхүү саналыг оруулж ирж байгаа. Энэ агуулгаар нь дэмжиж байгаа юм. 2019 онд томилогдсон 6 жил ажиллалаа. Энэ хугацаанд төрийн хүний хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, шударга ажилласан гэж харж байгаа. 2017 онд прокурорын тухай хууль шинэчлэн найруулагдаж батлагдсан. Энэ хуулиар бол прокурор дотроосоо Улсын ерөнхий прокурорыг томилдог ийм шинэ зохицуулалттай болсон юм. 2002 онд батлагдсан энэ хуулиар 10 жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын иргэнийг Ерөнхий прокуророор томилох ийм зохицуулалттай байсан. Ийм учраас тухайн үед 1 намын дарга хүртэл Улсын ерөнхий прокуророор томилогдох ийм эрх зүйн боломж байсан. Тэр ч агуулгаар томилогдоод ажиллаж байсан сая Пүрэвдорж гишүүн, Тэмүүжин гишүүд ярьж байгаа юм. Ингээд мэргэжлийн хүн буюу прокурор хүн Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор томилогдох ийм боломжтой болоод анх томилогдсон хүн бол Жаргалсайхан Ерөнхий прокурор. Одоо ингээд улиран томилогдох гэж байна. Ингээд мэргэжлийн хүн өөрөө тухайн байгууллагаа удирдаж ажиллах ийм боломж бүрдсэн.

2019 онд ажилласнаа ажлаа хүлээж авснаас хойш бас амаргүй цаг үеийг туулж бас олон ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Ажиллах хугацаанд дунд нь бас прокурорын хуульд өөрчлөлт оруулах оролдлого хүртэл гарч байсан. Намайг Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байхад прокуророор гэдэг үгийг Монгол Улсын солих гэсэн ийм оролдлого гарч, Хууль зүйн байнгын хороо дээр хууль дагуулаад хуучин тогтолцоогоо санагалзаж, улс төрчийг томилох ийм оролдлогыг бас хийж дагалдуулж орж ирж байсан. Энэ хуулийг тухайн үед Хууль зүйн байнгын хороо дээр унаж байсан, унагааж байсан санагдаж байна.

Ингээд олон улс төрийн болоод олон хүчин зүйлүүдийг бас давж ажиллаад ингээд улиран томилогдохоор өнөөдөр орж ирж байна. Ингээд Жаргалсайхан прокурорын хувьд ажлын туршлага, өөрийн зарчим, өөрийн хувь хүнийхээ ноён нуруугаараа мэдээж энэ байгууллагыг хангалттай толгойлоод явж байгаа. Цаашид дахиад 6 жил ажиллахдаа бас олон зүйл дээр бас манлайлан ажиллах шаардлага байгаа. Би дээр бас 2, 3 зүйлийг хэлье гэж бодож байгаа юм.

Энд ер нь энэ Эрүүгийн эрх зүйн хувьд 2 зүйл байгаад байгаа юм. Зөрчил, гэмт хэрэг хоёрынхоо зааг ялгаа нэлээн бүдгэрчхээд байгаа юм. Энийг ер нь тодорхой болгох шаардлагатай байгаа юм. Зөрчил чинь өөрөө бас яг гэмт хэргийн шинжийг агуулсан ийм зөрчлүүд бас байгаад байгаа юм. Энийгээ их тодорхой болгохгүй нь бол холилдоод яваад байгааг илүү их тодорхой болгох шаардлага байгаа юм. Энэ дээр манай прокурорын байгууллага их тодорхой ажилламаар байна.

Зөрчил чинь өөрөө явсаар байгаад гэмт хэрэг болох ийм том шалтгаан болдог. Зөрчил давтагдаад яваад байдаг гэмт хэргийн үндэс болдог. Энийг тодорхой болгох шаардлага байна гэдгийг бас танд бас хэлэх гэсэн юм. Энийг үл тоомсорлож болох зүйл шүү. Энэ дээр бас ахиц гаргаарай гэж хэлж байна.

Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахаас гадна гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлах ажил дээр бас манай олон .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Л.Мөнхбаатар: Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах ажил дээр мэдээж хүрээлэн байгаа энэ чиглэлээр тодорхой улсын төсөв Их Хурлаас бас анхаараад олон чиглэлээр ахиц гаргаж ажлаа бас нэлээн өндөр түвшинд гаргах шаардлага байгаа. Энэ дээр бол олон чиглэлээр хамтран ажиллах шаардлага байгаа. Шинэ төрлийн гэмт хэргүүд буюу цахим луйвар, хар тамхитай холбоотой асуудлууд, хүний наймаа гээд чиглэлээрээ онцгойлон анхаарах зайлшгүй шаардлага байна. Энэ чиглэлээрээ бас манай прокурорын байгууллага онцгойлон анхаарах шаардлага байна. Хар тамхины асуудал нэлээн хүндрэлтэй байдалд хүрсэн шүү. 2030 он гэхэд хэрэглээ 40 хувьд хүрнэ гэсэн судалгаа гарчихсан байж байгаа. Энэ чиглэлээр Хууль зүйн яам, Хууль зүйн байнгын хороотой хамтарч томоохон үндэсний хэмжээний ийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа гэдгийг бас прокурорын байгууллагын нөхдүүддээ бас хэлье гэж бодож байна. Энэ чиглэлээр том хөтөлбөрүүдээ гаргаад, цогц байдлаар асуудлуудаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхбаатар гишүүн үг хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж үг хэлье.

Д.Ганбат: Ер нь амаргүй байгаа. Өөр ч амаргүй болох байх. Амаргүй, амаргүй гээд л тэгсээр байгаад л амаргүй болгож байна л даа нэ ард түмний амьдралыг. Хамгийн амаргүй байгаа нь Монголын ард түмний нуруун дээр байгаа. Тэгээд улсын төсөв нэмэгдчихсэн. Аж ахуйн нэгжүүд үүд хаалгаа хааж байгаа. Энэ авлига хороолол сүндэрлэж байгаа энэ нөхцөл байдалтай харахад таны ажил маш хүнд хэцүү байх болно. Танаас хүлээлт маш их байгаа. Энийгээ прокурорын байгууллага амьдрал дээр харуулах байх гэж найдаж байна.

Уг нь Монгол Ардын нам ялсан юм байгаа юм. Ер нь ард иргэдийн хамгийн дургүйцээд байгаа юм бол энэ чинь хуулийг биелүүлдэг, хуулийн дор амьдардаг ард түмэн бол хуулиас гадуур дархлагдсан ийм хулгайчууд байгаа байхгүй юу. Энд л ард түмэн баян ядуу байгаагаасаа илүү энд их дургүйцээд байгаа юм. Шударга ёсыг хүсэмжлээд байгаа юм. Тэгээд Ардын нам ч гэсэн нам ч юм уу, юу ч юм бүлэглэлүүдийн хоорондох л Ардчилсан нам гэж яриад ч яах вэ ийм л болчихоод байгаа юм. Би яагаад энийг яриад байна вэ гэхээр үндсийг нь яриад байгаа байхгүй юу. Өнөөгийн нөхцөл байдлын. Уг нь Ардын намд алт шиг залуучууд байна. Авдрыг нь ухвал Энхбаяр, Аубакир, Бат-Амгалан, Батжаргал гишүүн, Батлут, Ганхуяг гишүүн, Дамдинням гишүүн гээд байгаа байхгүй юу. Тэр хойноос бас Ариунзаяа байгаа юм байна шүү. Бас Ундрамыг нэмчхэж болно. Ийм хүмүүст итгэл өгсөн байхгүй юу. Парламентын засаглал гэдэг чинь энэ байхгүй юу. Гэтэл тэрийгээ хэрэгсэхгүй жагсаалтаар орж ирсэн хүмүүс ингээд л ажиллаж байна гээд л, одоо нэг жил ажиллаж байна л даа. Үр дүн нь ядуурал хэвээрээ л байна. Амьдрал ахуй өдрөөс өдөрт муудаж байна. Энэ олон мега төсөл гээд л яриад байдаг. Энэ долларын ханшийг хар л даа. Сүүлийн 20 хоногийн дотор 100 төгрөгөөр нэмэгдэж байна шүү дээ. Байдал ийм л байна.

Тэгээд Ерөнхийлөгчийн институтээс асуух нэг асуулт, Ерөнхий прокуророос асуух нэг асуулт байна. Асуултыг би давхардуулахгүй. Бүлэг дээр ч асуусан, Хууль

зүйн байнгын хороо дээр ч асуусан. Үндсэн хуулийн 56-д Ерөнхий прокурорыг, орлогч прокурор гэж байна уу, туслах прокурор гэж байна уу. Ийм хүмүүсийг Ерөнхийлөгчийн институтээс 6 жилийн хугацаагаар зөвшилцөх гэж оруулж ирнэ гэж байж байгаа байхгүй юу. Одоо хугацаа нь дуусаж байгаа туслах прокурорууд байгаа юу. Орлогч прокурорууд. Тэрийг та хэлээрэй хэзээ оруулж ирэх юм. Улсын Их Хуралтай зөвшилцөнө гэж хууль дээр байгаа байхгүй юу.

Гишүүд ярьж байна лээ. Хууль зүйн байнгын хороо дээр. Улсын Их Хурлын танхимаас шударга ёс эхлэх ёстой гээд таны өмнөх прокурорууд бас ярьдаг байсан гээд. Ер нь тийм л дээ энэ танхимаас л эхлэх ёстой. Бас өмнө Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн 76 гишүүн байхад тал нь гэмт хэрэгтнүүд шүү та нар гэж байсан. Тэгээд л ЖДҮ, Ногоон Автобус, тэрний далд эзэд нь бүгдээрээ л энд сууж байгаа. Одоо Хөгжлийн банк гэх мэтчилний. Энэ танхим дотор яллагдагчаар татагдаж байсан, татсан би нэрийг нь хэлээд хэрэггүй гэж байгаа юм. Хэчнээн хүн байна вэ. Бид нар бас ямар нэгэн байдлаар явсаар байгаад нөгөө гэмт хэрэгтний үүр уурхай энд цугларчихаар хууль хяналтын .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Занданшатар дарга. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Занданшатар: Монгол Улсын Ерөнхийлөгч хүн засагладаггүй, хууль засагладаг ийм хуулийн засаглал, эрх зүйт төрийг бүрдүүлнэ гэж хөтөлбөр, зорилт дэвшүүлж, тэр чигээрээ ч тууштай хуулийн байгууллагын аливаа үйл ажиллагаанд оролцдоггүй. Хэрэг маргаанд оролцдоггүй. Улс төрөөс ангид байх улс төрийн баталгааг хангах тэр Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж ажиллаж байгаа. Ийм ч учраас ёс зүйтэй, мэргэжлийн ур чадвартай, мэргэжлийн ёс зүйтэй ажиллаж байгаа Ерөнхий прокурорыг улируулан томилж байгаа. Хуулиараа Ерөнхий прокурор өөрөө санал болгож, орлогчоо томилуулахаар прокурорын хуульд заасан байгаа. Энэ дагуу Ерөнхий прокурор санал дэвшүүлэх байх. Ер нь систем нурчихсан үед тодорхой шийдвэртэй арга хэмжээ, гүйцэтгэл авч болно гэсэн Жон Локийн эрх зүйн философи зарчмын хүрээнд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан.

Юуны хувьд бол ер нь хэн шалгах, шалгагдахгүйг прокурор нотлох баримт, үйл баримт дээр үндэслээд шийдвэрлээд явж байгаа учраас тэр талаар прокурор өөрөө хариулах байх. 6 жилийн хугацаагаар тогтвортой ажиллуулахаар томилж байгаа. Байнгын хороон дээр Дашдондогийн Ганбат гишүүн асуусан. Тодорхой хариулсан. Ер нь нам харьяалал харгалзахгүйгээр л өнгөрсөн 6 жилийн хугацаанд төрийн өндөр дээд албан тушаалтнууд шалгагдаж шүүх дээр шийдвэрлэгдээд явж байгааг та бүхэн бэлхнээ мэдэж байгаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайхан прокурор хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Яллагчаар татагдсан хүмүүс байгаа. Гэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 7.2 дугаар зүйлд шүүгч, прокурор, мөрдөгч хүний гэм бурууг шийдээгүй байхад буруутай гэж нийтэд зарлахыг хориглодог. Тийм учраас танд тодорхой хүн, тодорхой тоог хэлэх боломжгүй.

Д.Амарбаясгалан: Тодорхой хариулчихсан шүү дээ. Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Яах вэ, би нэр ус асуугаагүй. Ер нь тоог нь ч асуугаагүй. Тоог нь хэлчихсэн сайн л байсан юм. Тэр бол ямар нэгэн байдлаар тэр хэрэг мөрдөн байцаалт, прокурорын халдашгүй байдалд халдаж байгаа зүйл биш. Ер нь гэхдээ ард түмэн мэдэж байгаа л даа. Нөгөө талаар цаашид бид бүхэн төрөлт юм хум дээрээ анхаармаар байна. Цаашдаа Үндсэн хуулийн өөрчлөлт энэ тэр юм байгаа юу, байхгүй юу гэдгийг бас Ерөнхийлөгчийн институтээс энэ тал дээр ямар санаа бодолтой байгааг нэг тодруулчихъя. Нэгэнт бид нар хууль, эрх зүйн асуудлыг ярьж байгаа учраас ямар санаа бодолтой байдаг юм гэсэн ийм асуудал байна. Мэдээж хэрэг минут хүрэхгүй учраас болилоо. Өшөө яривал зөндөө л.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Занданшатар: Прокурорын тухай хуулийн 7.2-т “прокурор шийдвэр гаргах үйл ажиллагааг явуулахад нь хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, хууль бусаар шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.” гээд заасан байдаг. Тийм учраас прокуроруудтай холбоотой хэрэг маргаантай асуудлыг өнөөдөр хуулийн хүрээнд ярих боломжгүй байх.

Мөн тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал энэ асуудалтай шууд холбоогүй учраас тодорхой хариулах боломжгүй. Тэгэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс аливаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт санаачлах тийм асуудал огт яригдаагүй бөгөөд тийм санаа зорилго байхгүй гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Бямбацогт: Нэр дэвшигч Жаргалсайхан прокурорыг дэмжиж байгаа. Яах аргагүй салбартаа сургууль төгссөн цагаасаа хойш анхан шатаас нь, орон нутгаас нь эхлээд шат шатын ажил албан тушаалыг хашсан. Бас л прокурорын байгууллага, Монгол Улсын шүүх засаглал улс төртэй холилдоод, хутгалдаад, бас ороо бусгаа явах цаг үед унаж, босож өгсөж, уруудаж прокурорын байгууллагадаа үнэнчээр ажиллаж ямар нэг хууль зөрчсөн ашиг сонирхлын зөрчил гаргасан, ёс зүйгүй элдэв асуудалтай холбогдож байгаагүй. 2019 онд бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Шүүх засаглал хараат бус бие даасан байх энэ өөрчлөлтийг бодит байдлаар бас амьдрал дээр хэрэгжихэд прокурорын байгууллагад 2019 онд томилогдоод, өнгөрсөн 5, 6 жилийн хугацаанд бас яг ажиллаж болох юм байна гэдгийг бас харуулж чадсан ийм нэр дэвшигч гэж харж байгаа. Тийм болохоор Монгол Улсын Ерөнхийлөгч бас энэ талуудыг нь харгалзан үзэж, 2 дахь удаагаа улируулан томилохоор санал оруулж ирж байгаа байх. Ийм л бэлтгэгдсэн боловсон хүчин, бэлтгэгдсэн төрийн албан хаагч, төрийн ажлын туршлагатай хүмүүсийг бид бас мэдлэг чадвар, туршлага, бүгдийг нь Монголын төр ашигладаг байгаасай. Ийм л байх ёстой гэж бодож байгаа юм.

Анх томилогдох үедээ бас туршлага дутаж байсан, алдаа оноо гаргаж байсан, яарч сандарч байсан, бас юу гэдэг юм ачиж санах, янз бүрийн асуудлууд байсан байх, байсан байж үгүйсгэхгүй. Одоо ингээд 2 дахиа томилогдоод явах гэж байна, ажиллах гэж байна. Тэгээд энэ хугацаандаа үндсэндээ бас өнгөрсөн хугацаанд алдсан алдаа байдаг бас алдаагаа засаарай, амжилт ололт байдаг түүнийгээ бас улам бас өнгөлж, зүлгэж, улам зоригжиж, түүнээс эрч хүч авч ажлаа улам эрчимжүүлээрэй гэж хүсэж байгаа юм.

Сайн машин, сайн жолооч 2 байж байж тэр иргэддээ зорчигчдоо санасан зорьсон газар нь бас эрсдэлгүй хүргэнэ. Түүнтэй адилхан сайн хууль, эрх зүйн орчин, түүнийг хэрэгжүүлэх сайн туршлагатай албан хаагч байж байж Монгол улсын төр цэвэршинэ. Монголын нийгэмд шударга ёс төлөвшиж бий болно. Энэ ч үүднээсээ бид нар 2017 онд Прокурорын тухай хуульд бас шинэчилж найруулж Улсын Их Хуралд өргөн барьж, батлуулж байсан. Урьд нь тэр хонгил угсардаг, малын эмч хүн, улс төрч хүн прокурор болдог энэ бүгдийг бид нар 2017 онд Прокурорын тухай хуулиар өөрчилж залруулсан. Прокурорын албан хаагчдын бас нийгмийн асуудлыг шийдэх цалин хангамж, ажил амьдралын баталгаа асуудлыг бид нар бас тэр хуулиар шийдсэн. Харьцангуй одоо прокурорууд маань төрийн ажлыг хоёргүй сэтгэлээр шударгаар хийх бололцоо боломж бүрдсэн байгаа. Одоо ингээд туршлагатай удирдагч нь удирдаад явахаар илүү прокуроруудаас нийгэмд шударга ёсыг тогтоох бололцоо боломж бас илүү ажиллах урам зориг, эрч хүч нэмэгдэнэ гэж харж байгаа.

Энэ хүрээнд сая бас Тэмүүжин гишүүний хөндөж ярьсан тэр насны асуудал яригдаж байгаа. Насны асуудал төрийн албаны хуулиар төрийн жинхэнэ албан хаагч насны дээд хязгаар 65 нас байна. Үүнийг бид нар бас өөрчлөөд Шүүхийн тухай хууль, Прокурорын тухай хуульд бас 60 нас, 55 нас оруулчихсан. Энэ Үндсэн хууль зөрчиж байна. Хүнийг нас хүйсээр нь, ажил албан тушаал нь ялгаварлаж байна гээд Үндсэн хуулийн цэц дүгнэлтээ гаргачихсан. Түүнийг нь Улсын Их Хурал хүлээгээд авчихсан байж байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой Хууль зүйн байнгын хороо яаралтай холбогдох хуулиудад өөрчлөлт хийх ёстой. Энэ өөрчлөлтүүдийн хүрээнд үндсэндээ хуулийн зөрчил арилна. Гэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгч бол Төрийн албаны хууль, төрийн жинхэнэ албан хаагчийн насны энэ хүрээнд өргөн барьсан. Энэ хүрээнд асуудал явах ёстой ийм агуулгаар Хууль зүйн байнгын хороо бас энэ хууль хоорондын зөрчил, энийг яаралтай арилгах ёстой шүү. Энэ дээр бүгдээрээ анхаарч ажиллах ёстой гэж үзэж байна.

Тэгээд Жаргалсайхан прокурорт ажлын амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Баасанжаргал: Би Жаргалсайхан прокуророос маш тодорхой 6 асуулт асууя. Та тэгэхдээ хариултаа маш тодорхой хэлээрэй. Дараа нь нөгөө салбарын бодлогод маш чухал хэрэгтэй байгаа шүү гэж.

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа ажиллагаа бол хүний эрхэд хамгийн нийцсэн байх ёстой, хамгийн бас онцгой анхаарах ёстой ажиллагаа байдаг. Таны бодлоор энэ 110 дугаар сургуулийн хүүхдүүдийн эрх хангагдаж байгаа юу. Цаашид яг ял эдлүүлэх хяналтыг үр нөлөөтэй болгох тал дээр ямар ажил, ямар ахиц дэвшил гаргана, ямар ажил төлөвлөж байгаа вэ. Онцгойлоод хүүхдийн хорих, эмэгтэйчүүдийн хорих дээр бас та санаачилга саналаа гаргаж хэлээч гэж байгаа юм.

2 дугаарт Прокурорын сахилгын хороо, мэргэжлийн зөвлөл, тэгээд прокурорын дотоод томилгооны асуудал байдаг. Энэ өөрөө цэвэр прокурорын байгууллага өөрсдөө шийдэж хийдэг. Тэгээд Ерөнхий прокурорын зүгээс үндсэндээ дүрэм журмыг нь баталж явдаг ийм асуудал. Тэгэхээр энийг цаашид хэрхэн тогтолцоог өөрчлөх тийм бодол байгаа юу. Хуульчдын холбоо ч гэдэг юм уу өөр мэргэжлийн

бусад байгууллагуудын оролцоотойгоор олон нийтэд нээлттэй болох ч юм уу ийм томилгооны асуудал дээр нээлттэй болох асуудал байгаа юу.

3 дугаарт прокурорын зөвшөөрөл болон шүүхийн хяналт, тэнцвэрийн асуудал байгаа. Маш олон мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой асуудал дээр бид нар прокурорын зөвшөөрөл авдаг. Энэ ер нь яваандаа шүүхийн хяналт руу шилжих ёстой гэж харж байгаа. Энэ дээр чухам таны байр суурь ямар байдаг вэ. Тэгэхээр энд хяналт, тэнцвэр одоогийн байдлаар хангагдсан гэж үзэж байгаа юу гэдэг ийм асуулт.

4 дүгээрт Улсын ерөнхий прокурорын өөрийнх нь баталсан маш олон дүрэм журам, хэм хэмжээний актууд байгаа. Ихэвчлэн Хууль зүйн яаманд бүртгэлгүй байдаг. Бид нар бол маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр энэ журмуудаа та хэзээ бүгдийг нь нээлттэй болгох вэ. Цаашид эдгээр дүрэм журмын тоог ялангуяа Ерөнхий прокурорын хувьд баталж байгаа энэ журам дүрмийн тоог цөөлөх дээр ямар төлөвлөгөө байгаа вэ гэдэг.

5 дугаарт ялын бодлого сүүлийн үед маш их чангарч байгаа. Тэгээд нь өөрөө хэр үр нөлөөтэй байдаг юм бол. Дээрээс нь сүүлийн үед хөөн хэлэлцэх хугацааг ер нь юм л хөөн хэлэлцэх хугацаагүй болно гэдэг ийм зүйл манай улс төрчдийн зүгээс маш их ярьж байгаа. Тэгээд асуудал кэйс гарахаар ялын бодлогыг л чангална гэдэг байдлаар нэг ийм ам хаах маягтай байна. Тэгэхээр дээр Улсын ерөнхий прокурорын зүгээс судалгааны хувьд яг энэ асуудал дээр ямар байр суурьтай юм. Судалгаанууд нь хийгдсэн судалгааг нь хүргүүлж өгөөч гэдэг ийм саналтай байгаа.

Тэгээд хамгийн сүүлд угаарын хийн хордлогод өртөж нас барж байгаа маш олон иргэдийн асуудал байгаа. Саяхан сонсгол болоод дууссан. Тэгээд яг угаарын хийн хордлогод өртөөд нас барж байгаа иргэдтэй холбоотой асуудал дээр шалтгаан нөхцөлийн талаар тодруулж би Улсын ерөнхий прокурор луу албан бичиг явуулсан боловч бараг 2 сар болж байна. Ерөөсөө хариу нь ирээгүй байгаа. Тэгээд ер нь яг угаарын хийн хордлогод өртөж нас барж байгаа иргэдийн асуудал нөхцөл байдалтай холбоотой шалтгаан нөхцөлийн талаар танай байгууллага дээр судалгаа хийгдэж байсан уу. Хийгдэхээр төлөвлөж байгаа юу гэдэг ийм асуулт асууя. Тэгэхээр энэ бол яг цэвэр маш тодорхой асуултууд учраас тодорхой хариулаарай гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Жаргалсайхан прокурор хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Гишүүний асуултад хариулъя. Та сая 111 гээд их л тодорхой тоо байрыг хэлж байна. Уг нь тэр тоог ер нь огт хэлдэггүй юм. Тэр байрлалын тоог. Бид нар шинээр баригдсан байр л гэж хэлдэг. Өнөөдөр 29 хүүхэд ял эдэлж байна. Энэ дээр прокурор өөрийнхөө ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьдаг чиг үүргээ хэрэгжүүлж, ажиллаж байгаа. Тэнд дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй, тэнд тодорхой хэмжээний боловсрол олгох энэ чиглэлийнхээ бүхий л ажиллагаануудыг хийж байгаа.

Прокурорын томилгоотой холбоотой асуудал дээр нэгдсэн төвлөрөлтэй удирдлагатай байдаг. Дээр нь Ерөнхий прокурор тухайн хүнээ томилдог гэдэг ийм зүйлийг сүүлийн үед ч их ярьж байгаа. Хүмүүст тийм ч ойлголттой байгаа. Прокурорын байгууллагын хуульд 5 зарчим байдаг юм. Тэр 5 зарчимд нэгдсэн

төвлөрсөн удирдлагатай, ил тод байх, бие даасан, хараат бус байх гээд олон зарчмууд бий. 5 зарчим. Энэ 5 зарчим ганцхан төвлөрсөн удирдлагатай гэдгээрээ биш, хоорондоо уялдаа холбоотойгоор хэрэгждэг. Би тэр дотор бие даасан хараат бусаар шийдвэр гаргадгийг нь хэлж байгаа юм. Энэ хуулиар баталгаажсан зарчим. Прокурорын томилгоотой холбоотой асуудлыг би шийдэж байгаа.

Тухайлбал прокурорын туслах ажилтныг Ерөнхий прокуророос үл хамааралтайгаар шийдэж эхэлсэн. 2022 оноос өнөөдрийг хүртэл хугацаанд нийтэд хуульчийн сонгон шалгаруулалт шиг зарладаг болсон. 1043 хүн бүртгүүлж шалгалтад оролцсон байна. 249 хүн тэнцсэн байна. 216 хүн ажилд орсон байна. Одоо ажлын байр гарахаар үлдсэн хүмүүс томилогдоно. Энэ зүйлийг бид тодорхой болгосны дараагаар прокуроруудыг томилдог энэ журам руу орж байгаа юм. Одоо 6 сарын 1-ээс эхлээд нэр бүхий 8 байгууллага шалгалт авна. Тэнд шалгарч гарч ирсэн прокурор болох хүнийг л Ерөнхий прокурор томилно. Онооны дэс дарааллаар. Тэнд би 10-т орсон хүнийг 1 томилсон хүний урдуур орж томилох ямар ч эрх зүйн үндэслэл байхгүй болгосон. Яваандаа энэ асуудал прокурорын байгууллагын прокурорын хууль дотор орно гэж би ингэж бодож байгаа юм.

3 дахь асуудал нь юу байсан юм. Угаар .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Б.Жаргалсайхан: Угаарын хийтэй холбоотой асуудал бол 6 жилтэй холбоотой болсон учраас нэлээн цаг хугацаа шаардаж байгаа юм. Тэгэхээр энэ цаг хугацаатай холбоотой асуудал дээр бас танд мэдээлэл өгөөгүй учраас уучлал хүсье. Яагаад уучлал хүсэж байна гэвэл тодорхой ажиллагаа орж байгаагаа танд мэдэгдээгүй учраас та одоо болтол ирүүлээгүй байна гэдэг ийм л ойлголттой байгаа юм. Ингэхээр энэ бол бид нарын буруу. Энэ ганцхан прокурорын байгууллагаас гардаг тоо биш. Эрх бүхий байгууллагуудаас бас давхар гардаг тоо. Тийм учраас энэ цаасан баримт дээр тулгуурласан тоо баримтууд гараад одоо дуусаж байгаа. Удахгүй тан дээр энэ мэдээлэл ирнэ.

Дараагийнх нь. Сахилга, ёс зүйтэй холбоотой асуудлууд байна. Прокурор дээрээ мэргэжлийн зөвлөл, ёс зүйн зөвлөл гэсэн ийм 2 зүйл бий. Мэргэжлийн зөвлөл дээр харьцангуй бага байдаг юм. Би сүүлийн 3 жилээр үзэхээр 2022 онд 2, 2023 онд 3, 2024 онд 2 хүн мэргэжлийн зөвлөлөөр авсан тодорхой дүгнэлтүүд гарсан. Ёс зүйтэй холбоотой асуудлууд харин байна. 2022 онд 106, 2023 онд 122, 2024 онд 116 хүн ёс зүй зөрчсөн гэсэн дүгнэлт гарч, арга хэмжээ авагдсан. 2025 оны 1 сарын байдлаар 28 хүн арга хэмжээ авагдсан. Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтээр ганцхан Ерөнхий прокурор арга хэмжээ авдаг биш. Энэ цаашаа гомдол гаргахдаа шүүхээр шийдэгддэг ийм асуудал. 8 прокурорын ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрөхгүй гэж шүүхэд гомдол гаргасан. Одоо 1 гомдол хүлээгдэж байна. 1 гомдлыг Ёс зүйн зөвлөлд буцаасан. Бусад нь Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт үндэстэй байна гэж шүүх шийдсэн. Харьцангуй энэ бол Ерөнхий прокуророос хамааралгүй шийдэгддэг ийм асуудал.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүнд тодруулж 1 минут өгье.

Х.Баасанжаргал: За байз би хүүхдийн хорихтой холбоотой асуудал дээр яагаад ингээд эмзэглээд, асуугаад байгаа вэ гэвэл энэ сургуулийн тоо, дугаар аль

хэдийн олон нийтэд нээлттэй болчихсон. Та сошиал янз бүрийн юмнуудыг шүүгээд хараарай.

2 дугаарт бид нар ялаа 50 хувь эдэлж байж боловсрол эзэмшинэ гэдэг хуультай. Энэ өөрөө хүний эрхэд нийцэж байгаа юм уу гэж байгаа юм. Тэгэхээр энэ мэтчилэн ялангуяа хүүхдийн хорих, эмэгтэйчүүдийн хорих дээр хүний эрхийн асуудал үнэхээр хүнд нөхцөл байдалтай байгаа. Одоо тэр сургуулийн тэр хорих байрны шинэ барилга баригдана гээд 2 жил дамнаж байгаа. Бид нар очиж үзэхэд одоо болтол барилгын ажил нь эхлээгүй л байдалтай байгаа гээд ингээд ямар байранд амьдарч байгаа, аль хэдийн актлагдчихсан, нурж байгаа зөөврийн сууцанд байгаа гэдгийг та бас анхаараад, цаашид ялангуяа ял эдлүүлэх ажиллагаанд тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудал дээр анхаараад өгөөрэй гэж хүсэж байна.

Тэр хамгийн сүүлийн тэр угаарын хийн хордлоготой холбоотой асуудал мэдээж шалтгаан нөхцөлийн талаар илүү би тодруулж асуусан байгаа шүү гээд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, асуулт асуухаар нэр өгчхөөд танхимаас гарч явж байгаа. Тийм учраас гарсан гишүүдийг жагсаалтаас ер нь цаашдаа хасдаг болно. Тэгээд өнөөдөр бас нэрээ өгчхөөд гараад явчихсан гишүүдийг хассан байгаа гэдгийг бас үүгээр уламжилъя. Одоо Сонгобайн Замира гишүүн асуулт асууна.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Ерөнхийлөгчийн оруулж ирж байгаа Ерөнхий прокурорын тал дээр бол ер нь дэмжиж байгаа. Яагаад гэвэл маш их туршлагатай хүн. 30 хэдэн жил прокурорын салбарт ажилласан байна. Тэгэхдээ 1 асуулт, хэдэн санал байна.

Одоо даян дэлхийд дайн дажин ихсээд, байгалийн гамшиг ихсээд байгаа. Тэгээд манай Монгол Улсын эдийн засаг нь ч тийм сайнгүй байна. Өнгөрсөн жилүүдэд манайхаас нэлээд өмч хөрөнгө, мөнгө төгрөг ингээд гадаад руу гарчихсан байгаа. Яг энэ тал дээр ямар үйл ажиллагаа явуулж, юу зохион байгуулж, ямар үр дүнд хүрч байгаа вэ гэсэн ийм нэг асуулт байна.

Дараагийн хэлэх юм бол заавал сая 1 сайн юм хэлчихлээ Ерөнхий прокурор. Бид нар заавал хүнийг шалгаж, ял өгөх биш цагаатгах тал дээр бас ажилладаг юм гээд. Тийм учраас шоронг гэмт хэрэгтнээр дүүргэх биш аль болох зөвшилцлийн маягаар юмаа зохион байгуулж, манай Их Хурлын даргын хэлснээр бид нар 20 дугаар зууны хуулиар явж байгаа юм байна. Хууль шинэчлэх шаардлагатай юм бол хуулиа шинэчилж, нягтран хамтарч ажилламаар байна даа. Тийм учраас энэ тал дээр ямар санал, санаачилга байна. Хууль санаачлах ямар өөр ийм бодитой юм хиймээр байна гэсэн санаа оноо прокурорын байгууллагад байна уу. Ийм 2 асуулт байна.

Дараа нь хэлэх санал бол прокурорын байгууллага маш хүнд байдалд ажиллана гэдгийг би сайн мэднэ. Хагас сайн, бүтэн сайн, амралт, баяр, ёслол гээд амарч чадахгүй, гэр орноо ч харж хандаж чадахгүй тийм байдалтай маш хүнд ажиллана. Тэгээд ар гэр нь ч маш их гомдолтой байдаг энэ тал дээр прокурорууд ажлын ачааллыг бууруулах, хөдөлмөрийн хэвийн таатай нөхцөлд ажиллах, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион

байгуулж, тэдний ажлын ачааллыг хөнгөвчлөх бодит үр дүнг гаргаасай гэж гэж би танаас хувьдаа хүсэж байна. Танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Гишүүний асуултад хариулъя. Прокурорын байгууллага шинэчлэгдэн батлагдчихаж байгаа хуулийн төслүүдэд саналууд өгдөг. Өгч байгаа саналаа практик талдаа маш үнэ цэнтэй саналуудыг өгдөг гэж бид өөрсдийгөө бас дүгнэдэг юм. Энэ хугацаанд 59 хуулийн төсөлд 398 санал гаргаж өгсөн. 17,5 хувь нь төсөлд тусгагдсан, 40 гаруй хувь нь одоогоор тодорхойгүй, 18 хувь нь тусгагдаагүй ийм байдалтай л явж байгаа. Тийм учраас манай байгууллагын гаргасан хуулийн төслүүд дээр бас практик талаасаа ямар байдаг юм бэ гэдэг энэ төслүүдийг эрхэм гишүүн таныг бас анхаарч өгч байгаач гэж ингэж хүсэж байна.

Гадаадад гарсан оффшор бүстэй холбоотой олон асуудлыг АТГ тодорхой ажлуудыг зохиосон. Энэ чиглэлээр ч нэлээн үр дүнтэй ажилласан. Одоо надад байж байгаа бодит тоон мэдээллээр 3 сая долларыг оруулж ирсэн. Тэр доллароор тодорхой хүүхдийн цэцэрлэгт зарцуулсан ийм зүйлүүд бий. Одоо надад ирж байгаа сүүлийн мэдээ Францаас манай улсаас гараад явсан үлэг гүрвэлийн ясыг оруулж ирэх ийм асуудал бас давхар дахин яригдаж байгаа. Тэгээд ийм чиглэлүүдээр бас бид нэлээн ажиллаж байгаа гэдгийг танд хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууя.

Р.Эрдэнэбүрэн: Баярлалаа. Мэдээж бас бүх зүйл болохгүй, бүтэхгүй байгаа биш, зарим зүйл бас сайжрах тал руугаа, сайн зүг рүүгээ явж байгаа зүйлүүд зөндөө олон байгаа гэж бодож байгаа. Тэрний нэг бол ялангуяа сүүлийн жилүүдэд хууль хүчний байгууллагын удирдлагуудын сайн, муу зүйлтэй нэр холбогдох явдал харьцангуй багассан. Өмнө нь бид нар мэдэж байгаа. Маш олон хууль хүчний байгууллага удирдаж байсан хүмүүс хэл амтай, янз бүрийн хүн амьтны бизнес дээрэмддэг, хөндлөнгөөс оролцдог эд нар гээд зөндөө их яриа гардаг байсан. Тэгээд энэ хэрээр хуулийн байгууллагад итгэх итгэл үнэмшил унадаг байсан. Тэгээд харьцангуй сүүлийн үед энэ чиглэлээр их гайгүй байгаа. Нэр хүндтэй байгаа гэж ингэж бодож байгаа. Монголчууд чинь цөөхөн. Хэний эргэн тойрон ямар хүмүүс юу болж байна гэдгийг бүгд хараад сууж байдаг, ярьж байдаг. Тэгэхээр нэр цэвэр байгаа, шударга байх явдал бол эргээд энд ажиллаж байгаа хүмүүсийнхээ, дунд шатынхаа бүх хүмүүст нөлөөлөөд хуулийн байгууллага зөв шударга байх чиглэлд маш том түлхэц болно гэж ингэж үзэж байгаа. Тэгээд дүр зургийг цааш үргэлжлүүлбэ, сайжруулъя гэж бодож сая сүүлийн үед АТГ-ын дарга, Ерөнхий прокурорын томилгоог үргэлжлүүлж ажиллуулахаар ингэж орж ирж байна гэж бодож байгаа. Тийм учраас дэмжиж байгаа юм.

Тэгээд нэр дэвшигч маань тоон үзүүлэлтүүд тайлбарлаж байгаа. Шүүх хүртэлх явж байгаа хэрэг бүртгэлтэй 170 мянга орчим хэрэг бүртгэгдээд ингээд цаашаа явсаар байгаад 16 мянга орчим нь шүүх дээр очиж байгаа гэж ингэж тайлбарлаж байгаа. Тэгээд энэ үзүүлэлтийг бусад бид нартай ойролцоо улсуудтай харьцуулж үзэж байдаг уу. Ойролцоо эрх чөлөөний индекстэй улсуудтай харьцуулж үзэж байдаг уу. Үзүүлэлтүүдээ илүү сайжруулахад концепцын хувьд, системийн хувьд хууль, эрх зүйн хувьд ийм зүйлийг хийвэл илүү сайжрах нь дээ гэж бодож явж байдаг зүйл юу байдаг юм бол. Олон жил, 30 хэдэн жил прокурорын байгууллагад

ажилласан хүний хувьд энэ чиглэлээр ямар бодолтой явдаг юм бол гэж ингэж асуумаар юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Гишүүний асуултад хариулъя. Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэргийн өсөлттэй холбоотой судалгаа шинжилгээг прокурорын дэргэдэх сургалт судалгааны хүрээлэн тогтмол хийж явдаг. Тэгэхдээ олон улсын жишигтэй харьцуулж үзэх бас нэлээн ярвигтай асуудлууд байдаг юм. Улс болгонтой манайх харьцуулах тийм боломжгүй нөхцөл байдлууд ч бий. Тэр нь юу вэ гэвэл манайх зөрчил гээд бүртгэгчихсэн зүйл зарим улсууд дээр гэмт хэрэг гээд явчихдаг.

Тийм учраас яг тэрийг ялгаж салгаж, бид нар өөрсдөө дүгнэх нь хамгийн хүндрэлтэй байдаг. Түрүүн бас Мөнхбаатар дарга бас хэлж байсан. Эрүү, зөрчлийн ялгаа гээд. Яг тэрэнтэй адилхан жишээ нь Францад манай зөрчлийг бол жижиг гэмт хэрэг гээд л явчихдаг. Тийм учраас олон улсын жишигтэй харьцуулахад бас ийм хүндрэлтэй зүйл байдаг. Тийм учраас тэр нь бас бид нар яг харьцуулж үзэх тийм боломжгүй ч нөхцөл байдлууд үүсдэг учраас бид бас харьцуулах тийм боломжгүй судалгаа хийгээгүй тийм зүйлүүд бий. Гэхдээ манай сургалт судалгааны хүрээлэн тодорхой төрлийн хэргүүд дээр олон улсын жишиг, бусад орны туршлагыг судлан үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: 3 гишүүний дараа санал хураалт явагдана. Гишүүдэд зар хүргэе. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Өнгөрсөн 7 хоногт АТГ-ын даргыг улираан томилсон. Өнөөдөр Улсын ерөнхий прокурорыг мөн улираан томилох асуудал орж ирж байна. Тус бүр 6 жилийн бүрэн эрхтэй томилогддог албан тушаал. Хуулийн дагуу АТГ-ын даргыг Ерөнхий сайд санал болгосон. Улсын ерөнхий прокурорыг Ерөнхийлөгч санал болгож байна. Тэгээд дор бүрнээ маш олон жил удирдах албан тушаалд ажилласан 2 эрхмийг хоёуланг нь улирааа гээд оруулаад ирж байна гэхээр манай хуулийн салбар маш сайн ажиллаж байгаа юм байна. Ямар ч асуудал байхгүй юм байна гэсэн дохиог өгөхөөр байна л даа. Гэтэл өнгөрсөн хугацаанд авлига огт буурахгүй байгаа, томоохон хэргүүд огт шийдэгдэхгүй байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүн таслах болон ял эдлүүлэх үйл ажиллагаанд хүний эрхийн зөрчил маш ихээр гарсаар байна. Улс төрийн хэрэг тохих замаар өрсөлдөгчдөө намнадаг, сонгууль дөхсөн үед гэнэт том том мэдэгдэл хийдэг, баривчилгаа явуулдаг уламжлал тогтсон байна гэж хэлж болохоор байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дүгнэлтэд Монгол Улсад эрүүдэн шүүх явдал байсаар байгааг удаа дараалан цохон тэмдэглэсэн байдаг. Тэгээд энд нэг асуудлыг хөндөхийг бас хүсэж байна. Хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах хугацааг хэт уртаар тогтоосон нь орчин цагийн хэлмэгдүүлэлт үүсэх, мөрдөх, яллах, байгууллагын дур зоргоор аашлах нөхцөлийг бий болгож байна гэж үзэж байгаа. Хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээр тогтоосон хэргийн тухайд хэрэг бүртгэх хугацаа 5 жил, мөрдөн байцаах хугацаа 10 жил, шүүхээр шийдэгдэх хугацаа 2 жил гээд тухайн гэмт хэргийг шийдвэрлэх хуулийн хугацаа даруй 20 гаруй жил болчихож байгаа юм. Энэ бол хүний шударгаар шүүлгэх эрхэд ноцтой халдсан эрүүгийн журмаар хүнийг залхаан цээрлүүлэх, дуугүй байлгах ийм хэм хэмжээ болчихоод байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоож яллагдагчаар татсан атлаа мөрдөн байцаалт нэрээр дахин 10 жил шалгана гэдэг хүнийг залхаан цээрлүүлж

байгаа, эрүүдэн шүүж байгаа хэрэг мөн биз дээ. Олон жил шалгагдаж байгаа энэ хугацаанд хилийн хориг гэх мэт тодорхой таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эрх нь зөрчигдөж байгаа маш олон хүн байгаа. Тэгэхээр бүх зүйл сайхан байна гэж 1 нэгнээ хөөргөөд, гоё ганган үгээр иргэдээ бас хуурч боломгүй байна. Тэгэхээр зөвхөн хувь хүнтэй тодорхой албан тушаалтантай холбоотой асуудал биш юм.

Тиймээс аль асуудлыг байгууллагын удирдлагын түвшинд шийдэх юм, аль асуудлыг хууль, эрх зүйн шинэ шинэчлэлийн хүрээнд шийдэх юм. Ямар ч байсан энэ парламент бүрэн эрхийнхээ хугацаанд хуулийн засаглалыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөний зөрчлүүдийг арилгах тал дээр маш тийм зоригтой, дорвитой, шинэчлэл хийх ийм эр зоригтой байгаа байх ёстой ийм итгэл үнэмшилтэй байх ёстой гэж харж байгаа. Тэгэхээр чиглэлд ийм дорвитой шинэчлэл хийхийн төлөө ингэж хамтарч ажиллах итгэл үнэмшил танд байна уу гэж асуух байна. Баярлалаа

Д.Амарбаясгалан: Жаргалсайхан прокурор хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Итгэл үнэмшил байна. Прокурорын байгууллага хуулийг хэрэгжүүлж ажилладаг. Монгол Улсын Их Хурлаас батлагдсан бүх хуулийг прокурорын байгууллага хэрэгжүүлж ажиллана. Хэрэгжүүлэхийн төлөө Прокурорын байгууллагын прокурорууд бүгд итгэл төгс, итгэл дүүрэн байгаа гэдгийг бас дахин хэлье.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууж, үг хэлье.

Н.Номтойбаяр: Эхлээд гишүүддээ хандаад нэг үг хэлчихмээр байна. Тэгээд Ерөнхий прокурорыг томилох асуудал дээр надаас өмнө бараг 32, 33 гишүүд үг хэллээ. Тэгээд яах вэ, ажилласан байдалд нь бодит дүгнэлт өгч үг хэлж байгаа гишүүд бас байна. Үүний хажуугаар ганц нэг гишүүд бараг л Ах аа, намайг бодоорой, одоо ингээд дэмжиж байгаа шүү гээд өөрсдийгөө ч онигоонд оруулаад, нэр дэвшигчээ ч эвгүй байдалд оруулаад нэг иймэрхүү өнгө аяс бас ажиглагдаад байна шүү гишүүд ээ.

Энэ асуудал дээр би дуугүй байх эрхгүй хүн. Яагаад гэхээр үнэхээр хууль хүчний байгууллагууд, АТГ, тэрний үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хүлээсэн прокурор, ингээд шүүх асар гомдолтой явдаг хүн. Дээрээс нь энэ шат дамжлагаар явж хэлмэгдэж хохирсон маш олон хүмүүсийн үйл хэргүүдийг мэддэг хүний хувьд их харамсдаг. Тэгээд энүүгээр хувь хүний нэг өнцөг гэхээсээ илүүтэй энэ нэг завхарсан тогтолцоонд нь яаж өөрчлөлт оруулах вэ, яаж хууль, шүүхийг хараат бус бие даасан болгох вэ, үүний эрх зүйн орчныг яаж чадамгай бий болгох вэ гэдэг дээр над дээр нөгөө улс төрийн үйл хэргийн хувьд шинээр нэмэгдсэн үйл ажиллагаа гэж хувьдаа ухамсарлаж бас ажиллаж явдаг.

Тэгээд өнөөдөр Жаргалсайхан Ерөнхий прокурорыг улираах вэ, эсэх асуудал одоо ингээд шийдэгдэх гэж байна. Би бол хувьдаа 2 зүйл дээр, 2 туйлын зааг дээр л эргэлзээд байгаа юм. Өнгөрсөн 6 жилийн хугацаанд ажилласан байдлыг нь дүгнээд үзэхээр хуулийн өмнө ноён нуруутай байсан ч юм шиг, үгүй бол нэг ноёны өмнө хууль өөрөө сөхөрсөн ч юм шиг иймэрхүү л байдалтай байсан. Би тодорхой ярих юм бол прокурорын байгууллагын таны орлогчоор ажиллаж байсан Алиманцэцэг, нийслэлийн Ерөнхий прокурор Ш.Нямдорж, түүний дор ажиллаж байсан С.Мөнхгэрэл, Пүрэвдагва гээд, тэгээд л энэ өмгөөлөгч нөгөө лифтний

оцгонодог гээд тодотголтой Баасанцогт, Халтмаагийн Баттулгын ажлын алба Үндэсний аюулгүй байдлын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан нөгөө чацга хочит Гансүх энэ бүгдийн нэг бүлэглэл сүлжээ таныг Ерөнхий прокурор байх доор үнэхээр дураараа эрхэлж байсан.

Тэгээд би танаас нэг зүйл асуумаар байна. 2021 оны 1 сарын 21-ний өдөр өнөөдрийн Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх тухайн үед Ерөнхий сайд байхдаа энэ сандал дээр сууж байхдаа нэг зүйлийг хэлсэн байдаг юм. Улсын Их Хурлын энэ чуулган дээр. АТГ болон бусад хуулийн байгууллага, үүн дотор мэдээж прокурор шүүх орж таарна. Нэг хүнээс хараат бус байхын төлөө зүтгэнэ. Хэн нэгэн хүнийг дуудаж ял оноодог, гэмгүй хүмүүсийг ял оноож гэсгээдэг, улс төрийн зорилгоор өөрийнхөө өрсөлдөгчийг намнадаг, хуулийн байгууллагын дарга нарыг томилохдоо түрүүлж өргөдлийг нь авдаг, улс төрчдийг айдсаар айлгадаг Ерөнхийлөгчтэй байж болохгүй гээд. Мэдээж та энэ үгийг маш тод санаж байгаа байх. Энэ үг ер нь танд ямар хамааралтай вэ. Энэ үгийг өнөөдөр Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх хэлж байхад Занданшатар дарга та бас яг хажууд нь Их Хурлыг удирдаад сууж байсан Их Хурлын дарга байсан. Энэ үг биеллээ цаашдаа олох уу. Тэгээд ялангуяа энэ үг тухайн үед Ерөнхий прокурор байсан, ажиллаж байсан Жаргалсайхан танд яаж буусан бэ. Энэ дээр та нэг тайлбар өгөөч. Тэгээд хурлын дарга нэмэлт бас асуух асуулт байгаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Би хэлсэн үгний нь төлөө тайлбар өгдөг хүн биш ээ. Тэр үгийг би тайлбарладаг хүн биш. Таны өмнө тийм үгийг би тайлбарлаад байх албан тушаалтан биш.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга хариулт өгөх үү. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Занданшатар: Хүн хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээдэг. Тэрийг хэлсэн хүн нь хэлнэ. Тэгэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгч хүн засагладаггүй, хууль засагладаг эрх зүйт төрийг бүрдүүлэх энэ зарчмыг баримталж, одоо ч гэсэн мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар өндөртэй ажиллаж олон асуудлуудыг улс төрөөс ангидаар шийдвэрлэхийг эрмэлзэж явж байгаа энэ хуулийн засаглалыг тогтвортой мөрдүүлэхийн төлөө, хуулийн засаглалыг бэхжүүлэхийн төлөө ажиллаж байгаа. Мэдээж олон жил бугширсан системийн авлигын шинж чанартай болчихсон засаглал нэг өдөр өргөс нь авчихсан юм шиг зүгээр болчихгүй нь ойлгомжтой. Гэхдээ тоо баримтууд өнөөдөр 16,8 их наядын хохирлыг шүүхэд нэхэмжилж, 14,8 их наядын төрийн хохирлыг барагдуулж, тодорхой хэмжээгээр хэрэг маргааныг шийдвэрлэж явж байгаа гэсэн ийм дүгнэлтүүдийг прокурорын тайланд дурдаж хэлэлцэгдсэнийг та бүхэн сонссон байх. Ийм учраас .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Номтойбаяр гишүүн тодруулж асууя.

Н.Номтойбаяр: Ерөнхийлөгчийн хэлсэн тухайн үеийн үг их чухал үг л дээ. Тэгээд би танаас энэ үгэн дээр нэг тайлбар гэхээсээ илүүтэй тухайн үед хэлж байсан үг маань ер нь ямар хамааралтай байсан юм бэ. Ер нь бүгд л мэдэж байгаа шүү дээ. Тэр үеийн Хууль зүйн сайд Нямбаатар хүртэл Төрийн ордны зүүн жигүүрийн 3 давхарт хууль, шүүхийн байгууллагууд очиж үүрэг даалгавар авч, хүмүүсийг яллаад байна гэдэг үгийг хариуцлагатайгаар бас хэлж л байсан. Тэгээд би гол нь эндээс юу

сонсох гээд байна вэ гэхээр үнэхээр хууль, шүүхийн байгууллагад нөлөөлөл байдгийн тод жишээ мөн үү гэвэл мөн. Гэхдээ нөлөөллийг цаашдаа бид эрх зүйн орчинд нь яаж бүрдүүлэх вэ гэдэг хамгийн чухал асуудал. Одоо гишүүдийн нийт хөндөж байгаа асуудлуудын 90 орчим хувь нь ердөөсөө хууль, шүүхийн байгууллага хэн нэгэн эрх мэдэлтний нөлөөд яаж автуулахгүй байх эрх зүйн орчныг хэрхэн бүрдүүлэх вэ л гэж санаа зовниод байна шүү дээ. Өчигдөр би ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд Ерөнхий прокурорыг томилох тухай зөвшилцөх санал гээд энэ зөвшилцөнө гэдэг нь одоо бид нар Ерөнхий прокурорыг томилох санал өгөхгүй юм байна гэж би ойлгоод байгаа юм. Тэгээд зөвшилцөхийг хэлэлцэнэ гэхээр олонх бол мэдээж зөвшилцлөө гэж үзээд, цөөнх зөвшилцөөгүй гэж үзэх аргагүй шүү дээ. Энийгээ тийм болохоор яах ёстой юм. Зөвшилцсөн бол тэгээд Их Хурлын гишүүдийн саналаас үл хамаараад томилогдоод явчих бүрэн боломжтой. Ерөнхийлөгчийн асуудал байх. Энийг яаж ойлгоод байгаа юм бэ гэдэг байгаа.

2-т нь ардчилсан ба ардчилсан бус хулгайч, луйварчин янз бүрийн нэр хоч өгөгдөж байна. Эрх мэдэлтнүүд идэж уусан луйвардсан янз бүрийн зүйл яригдаж байна. Цагдаа бол хүний эрхийг хангадаг, прокурор зүй зохистой, эрх зүйн эрхийг хангадаг аль аль талын, шүүх бол шударга ёсыг тогтоодог ийм байх юм бол энд бид нар бие биеийгээ ийм нэр хочоор хэн нэгэн хүн нь дуудаад байх албагүй болно. Сайд нар хэрэг ярьдаг болж байна.

Тэгэхээр яг өнөөдөр парламентын танхим байна уу гудамж талбайд байна уу, энэ зүйлүүд яригдаад байна гэдэг чинь Монголд шударга ёс алдагдчихсан учраас л энэ зүйлүүд яригдаад байна гэж ойлгоод байгаа юм. Энэ шударга ёсыг прокурор, шүүх нь үнэхээр тогтоож чаддаг бол шударга бус, хулгайч, луйварчин янз бүрээр нь хэн нэгнийг дуудах албагүй болно шүү дээ. Нийгмээрээ, нийтээрээ, улс төрчид нь, төрийн эрх барих байгууллагад байгаа бүх хүмүүс л ингэж ярьж байна. Тэгэхээр энэ өөрөө юуг хэлээд байна гэхээр шударга ёсыг тогтоох ёстой прокурор, шүүх, цагдаагийн байгууллага нь энэ ажлаа гүйцэд, хангалттай хэмжээнд хийж чадахгүй байна л гэдгийг олон нийт өөр өнгөөр, өөр үгээр улс төрчид өөр үг, өөр өнгөөр илэрхийлээд байна гэж ойлгоод байгаа юм. Тийм болохоор прокурор, шүүхийн байгууллага ер нь хууль ёсыг тогтоох ёстой иргэний эрхийг хангах ёстой энэ байгууллагууд шударга ёсны тэмцлээ хийж чадаж байна уу, үгүй юү гэдэг дээр цаашид хийж чадах уу, үгүй юү гэдэг дээр бас үг дуугармаар байгаа юм.

Нэгэнт Улсын Их Хурал энэ танхимд Ерөнхий прокурорын асуудлыг хэлэлцэхээс гадна энд үг хэлж байна гэдэг бол цаашид олон нийтэд, иргэдэд томилогдох гэж байгаа этгээд бол амлалт үүрэг, байр суурь, үнэ цэн, зарчмаа тодорхойлж хэлж байгаа гэж ойлгож байгаа. Тэр утгаар нь ойлгож бас ирэх 6 жилд шударга ёсыг нэхэхгүй болтол нь хэн ч шударга ёс алга байна гэж нэхэхгүй болтол нь ажиллаж чадна гэдгээ илэрхийлээд хэлчихвэл зүйтэй болов уу гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Батбаатар гишүүн үг хэллээ. Асуултад Жаргалсайхан прокурор хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Б.Жаргалсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Тийм ээ, бид нар олон нийтийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагаасаа жаахан хол хөндий

явсан. Зөвхөн хууль хэрэгжүүлэх гэдгээрээ мөрдөх байгууллага эрх бүхий байгууллагуудтай холбогддог. Хүний эрхийн гэсэн олон нийтийн байгууллагаасаа жаахан хол хөндий явсан. Тэрний нэг гор авлигын индекс олон улсын судалгааны байгууллагууд дээр гарч байгаа асуудлууд дээр нэг зүйл гардаг юм. Тэр нь юу гэвэл улсдаа бид нар өөр өөрсдийнхөө үнэн бодит нөхцөл байдлыг ойлголцоогүйн улмаас тухайлбал Франц, Швейцарын Женевт болсон олон улсын хурлууд дээр олон нийтийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтайгаа өөр өөр ойлголттой тэнд уулзалдаж байгаа юм. Тэгэхдээ энд бүгдээрээ уулзалдаж, нэг зүйлээ тодорхой болгоё гэж би буруу үгээр хэлж байж магадгүй. Хуйвалдъя гэж байгаа биш, ойлголцлын зөрөөгөө гаргаж байх ёстой юм байна лээ. Тийм зүйлийг бид хийгээгүй явсан. Тийм учраас бид хуулийн байгууллагын хүрээнд олон нийтийн байгууллагынхаа дуу хоолойг нэлээн сонсох, иргэний нийгмийн байгууллагуудаа нэлээн сонсох, хүний эрхийн байгууллагуудаа нэлээн сонсох тийм зайлшгүй шаардлага байна лээ.

Та намайг ажиллаж чадах уу гэж байна. Би өргөсөн тангарагтаа үнэнчээр ажиллана. Ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд маань бас нөгөө асуулт асууж, үг хэлэх болохоор кноп дарчхаад танхимаас гарч яваад байгаа олноороо. Иргэд, сонгогчид бас энийг их шүүмжилж байгаа. Тэгэхээр кнопоо дарчхаад гараад явсан гишүүдийг 5-аас илүү минут болсон тохиолдолд нэрсийн жагсаалтаас нэрийг нь хасдаг болъё гэсэн ийм зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байгаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан маш тодорхой. Үдээс өмнөх хуралдаан дэгийн хуулийн дагуу хэлэлцэх асуудлаа яг хугацаандаа хэлэлцэж дуусдаг байх ёстой. Үдээс хойших хуралдаан бас яг тэр зарчмаар буюу хуулийг хэлэлцэх хугацаандаа хэлэлцээд дуусдаг байх ёстой. Тэгээд яг энэ цаг дээр Улсын Их Хурлын гишүүд маань тогтвортой сууж ажиллана. Цаг тодорхой болсон учраас бусад цагууд дээр ажлаа төлөвлөдөг байх тэр боломжийг нь бүрдүүлж өгнө гэсэн ийм байдлаар ажиллаж байгаа. Их хурлын Тамгын газрын зүгээс Засгийн газрын болон төрийн байгууллагуудад Улсын Их Хурлын чуулганы хуралдаан хуралдаж байгаа тэр цаг дээр давхардуулж арга хэмжээ, хурал зөвлөгөөн зохион байгуулахыг бас хязгаарлах ёстой. Хэрвээ давхардуулж зохион байгуулсан арга хэмжээ дээр Улсын Их Хурлын гишүүд оролцох шаардлага үүссэн тохиолдолд Улсын Их Хурлын даргын зүгээс чөлөө олгохгүй байх зарчмыг баримтална гэдгийг бас маш тодорхой хэлчихье.

Тэгээд яах вэ, урьдчилан сануулаагүй байсан учраас өнөөдөр нэрээ өгчхөөд жагсаалтаас хасагдсан байгаа 3 гишүүнд 1, 1 минутаар үг хэлэх боломжийг энэ удаа олгоё гэж бодож байна. Цэндийн Баатархүү гишүүнд 1 минут өгье.

Ц.Баатархүү: Монгол Улсын хуулийн засаглалыг сайжруулахтай холбогдсон маш чухал томилгооны асуудал хэлэлцэгдэж байна. Монгол Улсын ерөнхий прокурор гэдэг бол авлига, албан тушаал, эдийн засгийн гэмт хэрэг, олон жил яригдсан нүүрсний хулгай, 60 тэрбум, нийгмийн даатгалын хулгай, боловсролын зээлийн сангийн асуудлаар иргэд, олон түмэн шударга ёс хаана байгаа юм бэ. Энэ хэргүүд яагаад илэрдэггүй юм бэ, шийдэгддэггүй юм бэ гэдэг ийм байр суурийг илэрхийлж байдаг.

Тэгэхээр Ерөнхий прокурор бол шүүхийн хараат бус байдалд хэтэрхий их нөлөөлөхгүйгээр шударга ёсыг тогтоож, хуулийн засаглалыг сайжруулахад анхаарч ажиллах ёстой гэж бодож байна.

2 дугаарт нь 1 зүйл байгаа. Хэвлэл мэдээллээр явж байгаа энэ бүх хэргүүд хэдэн 10 жилийн өмнө боссон хэргүүд илэрч гарч ирж байна. Яагаад тухайн цаг үед нь хууль хяналтын байгууллага, шүүхийн байгууллага мөрдөн байцаах алба энэ гэмт хэргүүдийг илрүүлээгүй байсан юм бэ гэдэг асуудал логикийн хувьд гарч ирж байгаа. Өнөөдөр нийгэм даяараа хэрэг хэлэлцэж байгаа энэ бүх зүйл чинь дандаа өмнөх жилүүдийн асуудлыг ярилцаж байна, хэлэлцэж байна. Тэгэхээр тухайн цаг үед хууль, шүүхийн байгууллага сайн ажилласан уу, үгүй юу гэдэг ийм үл итгэх байдлыг улам бий болгож байгаа учраас цаашид прокурорын байгууллага бол прокурорын зөвшөөрөлгүйгээр хэн нэгэн хүн тухайн хэрэг дээр гарч дандаа улс төрийн мэдэгдэл хийдэг энэ байдал дээр бас цаашид анхаарч ажиллах ёстой гэдэг ийм байр суурийг илэрхийлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүнд 1 минут өгье.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Жаргалсайхан прокурорыг бол дэмжиж байгаа. Миний хувьд огт танихгүй, 1 ч үг сольж үзээгүй ийм хүн. Гэхдээ чиг үүргийнх нь хувьд бас мэдэлгүй яах вэ. Прокурорын байгууллагын үйл ажиллагааг хараад байхад өнгөрсөн цаг хугацаанд нийгмийн анхаарал татсан томоохон хэргүүд дээр бас нэлээн тийм нэг хууль талаа барьсан, улс төрөөс хол, ангид байж чадаж байна гэж би дүгнэдэг. Тэгэхээр дүгнэлтийг бол хэвлэл мэдээллийг өөр шугамаар авсан Их Хурлын танхимд яригдаж байгаа олон зүйлүүдээс бас үзэж байгаа юм. Хэдхэн хоногийн өмнө Авлигатай тэмцэх газрын дарга бас улиран томилогдсон. Тэр үеэрээ авлигын индексийг сайжруулахад, авлигын шалтгаан нөхцөлийг бууруулахад хууль, эрх зүйн бас томоохон шинэчлэлүүд хэрэгтэй байна. Зөвхөн тухайн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалахгүйгээр Их Хурлаас гарах хууль маань гарч байж нөгөө бидний .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гонгорын Дамдинням гишүүнд 1 минут өгье.

Г.Дамдинням: Жаргалсайхан прокуророос 1 л хүсэлт байна даа. Хамгийн сүүлийн жишээ хэлэхэд сүүлийн үеийн эдийн засгийн гэмт хэргүүд улс дамнасан, эзнээ нуусан мөнгөө нуух гэж оролдсон ийм л ажлууд их явдаг болчихсон байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учралын өчигдөр дээр олон нийтэд гаргаж тавьсан Төгрөг нуурын ордтой холбоотой манай танхимд суудаг нэг том дарга байгаа шүү дээ. Хуралдаа суудаггүй. Тэр хүнтэй холбоотой мэдээллийг харахад л олон улсын оффшор данснуудыг дамжуулаад аваад явчихсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр прокурорын байгууллагууд мөнгө угаасан юм шиг, татвараас зугтсан юм шиг Монгол Улсын хуулиас зугтсан юм шиг энэ асуудлуудыг судалж шинжилдэг мэргэжилтнүүдээ сайн бэлдэж аваарай. Араас нь бас хөрөнгө хүч гаргаарай. Энийг бас тодорхой болгож эргэж мэдэгдээрэй л гэж хүсье дээ. Тэгээд амжилт хүсье танд.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн бас Байнгын хорооны санал, дүгнэлтэд өөрийн хэлсэн асуудалтай холбоотойгоор тодотгол тайлбар хийх зайлшгүй шаардлага байна гэсэн хүсэлт тавьсан учраас 1 минутаар тэр Байнгын

хорооны дүгнэлттэй холбогдуулан залруулга хийх юм байна гэж ойлгосон. 1 минут өгье.

П.Сайнзориг: Баярлалаа дарга аа. Би бас Байнгын хорооны санал, дүгнэлтээр миний хэлээгүй зүйл энд тусалсан байна л даа. Энийг бас протоколд залруулж оруулчихъя гэж бодож байгаа.

Прокурорын ёс зүйн хуулийг боловсруулна гэж ерөөсөө яриагүй. Прокурортой холбоотой ёс зүйн асуудлуудыг шийдэх асуудал хаалттай байгаа. Зөвхөн прокурорууд өөр өөрсдийнхөө асуудлыг шийдэж байгааг ил тод, хөндлөнгийн байр сууриас хандах ёстой шүү. Бусад шүүгч нар, өмгөөлөгч нар шиг гэж хандах ёстой. Үүний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоорой гэдэг зүйл хэлснийг бие даасан хууль гаргах юм шиг, одоо ёс зүйн асуудлаа шийддэггүй юм шиг ийм байдлаар ингээд Байнгын хорооны протоколд орсныг залруулж байгаа.

Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр оруулж ир гэсэн саналыг дэмжиж байгаа. Энэ цахим мөрийтэй тоглоом дээр бас прокурорын удирдлагууд маань бас анхаарч, яг одоо one expert-ийг дагасан хууль бус спорт вэтийг халхавчилж, цахим казинод тоглож, энэ дээрээс бас хууль бус үйлдлүүд гараад байгаа дээр бас онцгой анхаараарай. Би бусад зүйлээ Байнгын хороон дээр хэлсэн учраас .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Улсын ерөнхий прокуророор Банзрагчийн Жаргалсайханыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Нийт 81 гишүүн дэмжсэн байна. 83,5 хувиар Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжлээ Улсын Их Хурал.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Хассуурийн Ганхуяг, Саруулсайханы Цэнгүүн, Цэрэнпилийн Даваасүрэн нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлнэ.

Жаргалсайхан Прокурорт ажлын өндөр амжилтыг хүсье. Монгол Улсын Их Хурлын гишүүд бас АТГ-ын дарга мөн Ерөнхий прокурорын томилгоо дээр бас онцгойлон анхаарч хүний эрхийн зөрчилтэй холбоотой шударга ёсны хүсэмжлэлтэй холбоотой олон асуудлаар бас асуудал хөндөж ярьж байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр санаачилгатай ажиллахыг танд хүсэж байна. Улсын Их Хурлын зүгээс прокурорын байгууллага, шүүхийн байгууллага, Авлигатай тэмцэх хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг санхүүгийн болон улс төрийн хараат бус байдлаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж өгөхийн төлөө бүрэн дэмжиж ажиллана гэдгийг танд илэрхийлье. Ажлын амжилт хүсье.

Ингээд хэлэлцэх асуудал үдээс өмнөх чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөр дууссан тул чуулганыг завсарлуулъя. 15 цагт үдээс хойших хуралдаан үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА.

Д.Амарбаясгалан: 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлье. Гишүүд танхимдаа орж ирье.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахаар байгаа.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцсан байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Чинбатын Ундрэм гишүүн алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чухал хууль орж ирж байгаа. Дэмжиж байгаа. Зарчмын хувьд дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Чухал хуулийн төсөл байгаа. Ер нь энэ зээлтэй холбоотой асуудал бас их хүнд байна энэ зээлийн хүү. Бид нар орон нутагт бас сая нэлээн ажиллаж байгаад ирлээ. Зээлийн хүүтэй холбоотой, зээл олголттой холбоотой асуудлууд нэлээн хүндрэлтэй байна. Ний нуугүй хэлэхэд жишээлбэл сая бид нар Булган аймагт ажилласан. Ахмадуудыг насны ялгаварлал гаргаж зээл өгнө, өгөхгүй гэдэг банкны дотоод журам гаргаад явж байгаа жишээнүүд маш их байна нэг талдаа. Та энэ Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зээлийн хүү буурна гэж мэдэгдсэн. Уг нь энэ чинь инфляцтай холбогдоод бодлогын хүүтэй хамааруулаад харахаар зээлийн хүү буух боломжгүй гэдгийг арилжааны банкууд мэдэгдээд байгаа. Гэтэл таны хувьд зээлийн зэрэглэл тогтоосноор зээлийн хүү буурах ийм бодит нөхцөл байдал бүрдэнэ гэж ингэж тайлбарлаад байгаа. Өнгөрсөн 3 дугаар сард Монголбанк бодлогын хүүгээ 2 хувиар нэмээд, 12 хувь болчихсон. Өнөөдөр валютын ханш ямар түвшинд оччихсон байна гээд харахаар ер нь бас их хэцүү, хүндрэлтэй. Нөгөө талдаа аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийгээд явж байхад орон нутагт салбараа байгуулах, үйл ажиллагаагаа өргөтгөх боломжтой. Гэхдээ зээлийн хүүгээс улбаатайгаар ямар ч эдийн засгийн өсөлт хийх боломж бол бид нарт алга гэдгийг мэдэгдэж байгаа.

Тэгэхээр би ямар асуулт асуух гээд байгаа вэ гэхээрээ яг энэ зээлийн хүү ямар шатлалаар, ямар алхмаар буурах боломжтой юм бэ гэдгийг 1 дүгээрт асуух гэж байгаа юм.

2 дугаарт зээлтэй холбоотой асуудал дээр тухайн барьцаалбартай холбоотой асуудлууд ингээд шүүхийн маргаан дэгдээд явахаар ингээд дунджаар 7 жил болж байх шиг байна. 7 жилийн хугацаанд тухайн үл хөдлөх хөрөнгийн үнэлэмж буурах, үнэ цэн буурах гээд маш олон асуудлууд 7 жилийн хугацаанд өрнөж байна. Бид нар цаашдаа зээлтэй холбоотой харилцааг хэрхэн зохицуулах юм. Зээлийн хүүг хэдийгээр буулгах гэж байгаа боловч нөгөө талдаа бид нар ямар бодлогын арга хэмжээг авч явах вэ гэдгээ хармаар байгаа. Өнөөдөр ДНБ-ий 12 хувийг гадаадын

хөрөнгө оруулалт эзэлж байгаа. Энэ 12 хувийнх нь дөнгөж бараг ихэнх буюу 10 хувийг нь зөвхөн дангаараа уул уурхайн салбар эзэлж байгаа. Энэ 10 хувь гээд тооцохоор нийтдээ 80 хувь нь дангаараа Оюутолгой байж байх жишээтэй. 2025 онд Оюутолгойн хөрөнгө оруулалтууд зогсоод, цаашдаа үйл ажиллагаа арай гадагшаа олборлолт илүү дутуу юмнуудаа явуулна гээд ойлгоод байгаа юм. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалт зогсож байгаа нэг талдаа 80 хувийг нь хангаж байгаа Оюутолгойн хөрөнгө оруулалтууд зогсоод эхлэхээр бид нар цаашдаа валютын нөөцөөс авхуулаад эдийн засгийн урсгал чинь ямар түвшинд очих юм бэ гэдгийг бас бодолцохгүй бол болохгүй болчихоод байгаа юм. Тэгээд зээлийн хүүтэй холбоотой асуудал, зээлтэй холбоотой асуудал, барьцаалбартай холбоотой асуудал гээд харахаар хэрэглэгчийн эрхийн зөрчилтэй холбоотой олон асуудлууд энэ дээр хөндөгдөж байгаа.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийг бас миний бие ахлаад явж байгаа. Маш олон хэлэлцүүлгүүдийг бид нар салбар салбарт хийж байна. Банк санхүүгийн салбарт хийсэн хэлэлцүүлгээс харахад хуучин би буруу санаагүй бол 2017 онд өргөн баригдахаар бэлтгэгдэж байсан Актив удирдлагын компанийн тухай хуулийн асуудал хөндөгдөж байгаа. Энэ хуулийг бид нар буцааж өргөн бариад, хохирч байгаа хохиролтой холбоотой асуудлуудыг бид нар бас шийдэх боломж байна уу гэсэн ийм 2 асуултыг асуух гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуулийн төсөл санаачлагч Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүн маш чухал асуулт асуулт л даа. 2 зүйлийг хөндсөн. 1 дүгээрт зээлийн хүү, 2-т нь Актив удирдлагын компани.

Зээлийн хүү буурах боломжтой юу гэж асуусан. Боломжтой олон улсын жишгээр харахад бол 28 орны жишгээр харахад 2004-2019 оны хооронд яг манайх шиг кредит скорын систем рүү шилжсэн улс орнуудын судалгааг харахад бол зээлийн хүү нь 3,2-3,4 хувиар буурсан. Бүр 1989 онд АНУ зээлийн кредитийн зээлжигдсэн зэрэглэлийн систем рүү буурсан. Тэгэхэд бас 2 хувиар буурсан байна лээ. Вьетнам улс хамгийн сүүлд 2000 оны эхээр шилжсэн. Тэгэхэд 18 хувийн зээлийн дундаж хүүтэй байсан. Яг Монгол Улстай адилхан өнөөдрийн. Энэ ь буураад 12-14 хувь руу шилжсэн. Тэгэхээр яагаад зээлийн хүү буурах вэ, буураад байна вэ гэвэл бид нар яг зээлийн хүүгийн бүтцийн дүн шинжилгээ гэж харахад нийт банкны зээлийн хүүг 100 хувь гэж харъя. Тэгвэл 63 хувь нь бол эх үүсвэрийн зардал гэж байгаа юм. Эх үүсвэр. Энэ нөгөө хадгаламжийн хүү 15 хувь нь бол эрсдэлийн зардал, 12 хувь нь үйл ажиллагааны банкных нь дотоод зардал. Тэгэхээр бид нар хаанаа яг хэмнэлт хийж болох вэ гэж яаж буулгах вэ гэвэл нөгөө би нэг түрүүн хэлсэн 15 хувь эрсдэлийн зардал болон 22 хувийн нөгөө үйл ажиллагааны зардал. Эрсдэлийн зардал нь ямар шалтгаанаар буурах вэ гэвэл нөгөө хүн болгон яг онооны системтэй болчихоор эрсдэл нь тодорхой болчихно. Одоо ямар системээр яваад байна вэ гэвэл банкнууд бүх иргэд, аж ахуйн нэгжүүдээ эрсдэлийг нь тодорхойлж чадахгүй болохоор өндөр хүү тавиад, тэгээд нөгөө 10 хувь нь ч юм уу, 5 хувь нь хэрвээ зээлээ эргэж төлөхгүй бол нөгөө бусад сайн зээлдэгч нарынхаа өндөр хүүгээр нь өгчихнө. Нэг ёсны шархаа нөхчихнө гээд яваад байгаа юм.

Тэгэхээр яг тодорхойлдог болчихоор энэ чинь өөрөө зээлийн эрсдэл болон нөгөө нэг яриад байгаа 15 хувийг тодорхой хэмжээнд бууруулна. Урсгал зардлыг ч

бид нар бууруулж болно. Яагаад гэвэл одоо банкнуудын дотоод үйл ажиллагаанд маш олон эдийн засагч нар ажилладаг. Нөгөө зээлээ судална гэж 10-14 ажлын хоног зардаг. Тэгвэл онооны системтэй болчихоор чинь шууд нөгөө иргэнээ заавал судлахгүйгээр өдөрт нь зээлийг нь олгох бололцоо нь үүсэж байгаа юм. Олон улсын кэйс дээр ч гэсэн яг тогтолцоо харагдсан. Өмнө нь Латин улс орнуудад бол судалгаа хийхэд 7 хоног зээлийн шийдвэр нь гардаг байсан бол Кредит Скоринг миний яриад байгаа зээлжих онооны систем рүү орсноор тэр нь бо өдөртөө гардаг болсон байгаа юм. Тэгэхээр зээлийн эдийн засагч нарын хүн цагийнх нь хөлс нь багасаад, үүгээрээ дамжуулаад бас нөгөө 22 .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Кредит скортой холбоотой асуудал, тэр бусад улс орнуудын жишээг хэлж л байна л даа. Тэр улс орнуудын инфляц ямар түвшинд тухайн үед очиж байж, зээлийн хүү жишээлбэл буурч байсан гэдгийг харж байсан уу гэдгийг би асуумаар байгаа юм. Дээрээс нь таны бас нэг хэлсэн ийм кредит скортой болсноор зээлийн хар жагсаалт гэж бид нар ярьдаг. Хамгийн гол нь иргэдийн эрхийг 6 жилээр хаадаг, боомилдог энэ хар жагсаалт байхгүй болно гэдгийг та бас мэдэгдэж байсан. Тэгээд энэ яг бодит уу. Тэгээд дээрээс нь нэмэлтээр нөгөө Актив удирдлагын компанитай холбоотой асуудлыг нэмж асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн. Батшугар гишүүн нэмж хариулах уу. Батшугар гишүүн нэмэлт хариулт өгье.

Э.Батшугар: Сүүлийн асуултаас нь эхэлж хариулъя. Активын удирдлагын компани хэрвээ шинээр үүсээд бий болбол энэ тогтолцоо нь Монголд үүсвэл яалт ч үгүй бас нөгөө миний яриад байгаа эрсдэлийн 15 хувь болон нөгөө 22 хувийн зардал нь буураад, тэгээд зээлийн хүү үүнийгээ дагаж буурна. Монгол Улсын кэйсийг харахад бол 2-4 хувиар шууд буурах бололцоотой болчихоод байгаа юм.

Инфляцыг харсан уу тухайн улс орнуудын гэж байна. Харсан. Тэрийг нь бол судалгаа бас давхар хийсэн. Өнөөдрийн Монголын тогтолцоо дээр ч гэсэн нөгөө миний яриад байгаа нийт хадгаламжийн зардал хүү нь 63 хувь байгаа юм. Тэр нь автоматаар инфляцыг өөрөө оруулчихсан байгаа. Яагаад гэвэл аливаа банк инфляцаас дээш хүү өгч байж хадгаламж татна. Актив .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Зээлийн түүх дата мэдээллийг бас дараагийн зээлийн шийдвэр гаргалтад ашиглах нь бас буруу биш байх. Зүгээр үүнтэй холбоотой хуулийн төсөл дээр байгаа заалтыг л тодруулах гээд байна л даа.

Зээлжих чадварын зэрэглэлийн оноог Монголбанкнаас баталсан аргачлалын дагуу тогтооно гэсэн байна л даа. Энэ аргачлалын дагуу. Тэгэхээр үүний цаана Монголбанкнаас нэгдсэн 1 аргачлал гаргаад, магадгүй үнэлгээг чинь миний ойлгож байгаагаар тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд гүйцэтгэх байх гэж бодож байна. Тэгэхээр бүгдэд нь 1 аргачлал өгчих юм байна. Тэгэхээр яг үүний чинь цаана тэр тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын чинь өрсөлдөөн олон олон зүйлүүд нь өөр өөрсдийн онцлог ялгаа, тэр давуу тал зүйлүүд нь хаана яаж гарч ирэх юм бол. Харин тэр засаглал, ил тод байдал, стандарт зэрэг зүйлийг нь аргачлалаараа өгөөд өөр өөрийн тэр онцлог, ялгаа бүхий шийдлийг нь харин гаргах боломжийг нь гаргаж

өгөхгүй бол, жишээ нь яг энд ойлгогдож байгаагаар олон улсын, дэлхийн том аудитын байгууллагууд, стандартын мүүдис бүгдээрээ нэг аргачлалаар үнэлгээ аудит хийдэг гэсэн үг үү. Тэгэхээр яг энэ хууль дээрээ яг ямар үзэл санаагаар сууж байгаа юм бэ. Монголбанкнаас нэгдсэн 1 аргачлалаар бүгдийг адилхан тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад өгнө гэвэл энэ чинь өөрөө тийм зохистой биш харагдаад байна. Энэ дээр нэг хариулт өгөөч.

2 дугаарт нь хууль дагалдуулж 1 тогтоолын төсөл гарах юм байна. Энэ тогтоол дээр гарч байгаагаар хууль батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн байгууллагуудын дэргэдэх сан нь төртэй холбоотой банкнаас авсан зээл, санхүүжилт авсан иргэн, аж ахуйн нэгжийг дараах нөхцөлд хамруулахгүйгээр оноо тогтоох гэсэн нэг ийм өгүүлбэр байгаад байгаа юм. Би буруу ойлгоод байна уу. Яг энэ төртэй холбоотой сан, бусад дэмжлэгүүд авсан бол энэ мэдээллийн санд энэ кредит скор онооны системд орно гэж байгаа юм уу, орохгүй гэж байгаа юм уу. Энэ 2 дээр хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Батшугар гишүүн.

Э.Батшугар: Монголбанк болон төв банк ер нь зарчмаа тохироод, журмаа гаргаад, яг энэ системээр ингэж явна гэсэн юм байхгүй. Эсрэгээрээ зүгээр олон улсын жишгийн дагуу явна. Дээрээс нь нэмээд зээлийн мэдээллийн хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй компаниудынхаа кибер аюулгүй байдал болон бусад шаардлагуудаа хангасан компаниуд өгөөд тэрэнд нь хяналт тавина. Мөн авч байгаа мэдээллээ үнэн зөв хийж байна уу, нөгөө компани нь дотооддоо ямар нэгэн байдлаар ашиг сонирхол зөрчилтэй байна уу, нөгөө иргэн, аж ахуйн нэгжээ яг онооныхоо дагуу шударгаар оноог нь гаргаж байна уу гээд хяналтаа тавих юм. Энэ зарчмаар бүх л улс орнууд явдаг юм байна лээ. Жишээлбэл, АНУ бол consumer financial protection bureau хяналтаа тавьж явдаг. Канад улс бол financial consumer agency сервисээ бас хяналтыг нь тавьж явдаг. Япон улс financial service agency гэж явдаг. Тэгэхээр төрийн байгууллага нь бол ямар ч байсан бизнесээ дэмжинэ. Тухайн хувийн хэвшил нь бол яг л энэ зарчмаар хоорондоо өрсөлдөнө. Өнөөдөр Монгол улсад 2 тусгай зөвшөөрөлтэй компани байгаа. Энэ 2 компаниа хоорондоо бас нэг ёсондоо үйлчилгээгээрээ өрсөлдөнө. Монголбанк Зээлийн мэдээллийн сангийнх одоо байгаа 4,6 сая их өгөгдлөө тухайн компаниуд өгнө. Харин тэрийгээ зөв зарцуулж байна уу, шударга зарцуулж байна уу, мөн ямар нэгэн байдлаар ашиг сонирхол зөрчил байхгүй байна уу, мэдээллийн аюулгүй байдлаа 100 хувь хангаж чадаж байна уу гэдэгт л хяналт тавина.

Тогтоолтой холбоотой 2 зүйл байгаа. Эхнийх нь бол давагдашгүй хүчин зүйлээс болоод зээл нь төлөгдөөгүй, тодорхой хугацаа өнгөрчхөөд эргээд төлчихсөн бол. Тэгвэл зээлийн мэдээллийн санд 6 хувь хүртэл гэхээс илүү уян хатан хандана. Яагаад гэвэл тухайн иргэн, аж ахуйн нэгжээс болоод тухайн иргэн, аж ахуйн нэгжийн орлого нь хаагдсан биш давшгүй хүчин зүйл болсон.

Харин эсрэгээр Хөгжлийн банк байна уу, Засгийн газрын тусгай сан байна уу, аль эсвэл боловсролтой зээлийн сан байна уу энэ мөнгөтэй харьцуулбал илүү сахилга баттай байх ёстой. Илүү хариуцлагатай байх ёстой. Яагаад гэвэл энэ мөнгө чинь өөрөө татвар төлөгчдийн мөнгө. Тухайн банкны мөнгө биш гэж явж байгаа. Хөгжлийн банк мөн адилхан. Хөгжлийн банкны мөнгө бол эцсийн үр дүндээ Улсын л мөнгө. Юу харагдсан бэ гэхээр та бас санаж байгаа байх. Хөгжлийн банкны сонсголоор маш олон зээлээ буруу зарцуулчихсан, аль эсвэл эргэн төлөхгүй байгаа

1,5 их наяд төгрөг байгаа. Энэ аж ахуйн нэгжийн зарим нь бол надтай хамаарахгүйгээр Засгийн газар улс миний юмыг худалдаж авахгүй байна гэсэн тийм шалтаг гаргаад байсан. Эцсийн үр дүндээ Монгол Улс л хохирч байгаа.

Д.Амарбаясгалан: Болсон уу. Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Зээлийн мэдээллийн тухай хуулийн зорилго нь бол өөрөө зээлдэгчийг бас санхүүгийн хариуцлагыг нь нэмэгдүүлэх, санхүүгийн эрсдэлээс бас бууруулах, дээрээс нь зээлдүүлэгчийн зардлыг бууруулах ийм ач холбогдолтой хууль гэж бол харж байгаа. Гэхдээ сүүлийн үед зээлийн мэдээллийн тогтолцоог яг нөгөө хуульд зааснаас бусад санхүү банкны яг оролцогчдоос бусад зориулалтаар хууль бас ингээд ашиглагдаж явж байгааг нэлээдгүй бас олон кэйс асуудлуудаар илэрхийлэгдэж байгаа. Жишээлбэл СӨХ-ны төлбөрөө цаг хугацаандаа төлөөгүй бол, гар утсаа бас яг хугацаандаа төлж чадаагүй, эсвэл ямар нэгэн хэрэглээ үйлчилгээтэй холбоотой асуудлаас болоод нөгөө эргээд мэдээлэл, түүх нь өөрөө муу түүхээр бүртгэгддэг ийм асуудал бол удаа дараа хөндөгдөж яригдаж байгаа.

Тэгэхээр энэ мэдээллийн тогтолцоог ингэж хавтгайруулах нь бол буруу гэж харж байгаа учраас ер нь Монгол банкны зүгээс энэ хуулийг сайжруулж оруулж ирж байгаатай холбоотойгоор асуудлыг ер нь хэрхэн шийдвэрлэж байгаа вэ. Энэ хуулиар энэ асуудал сайжрах уу. Энэ орчин сайжрах уу. Дээрээс нь бас Монголбанк болон Зээлийн мэдээллийн алба яг энэ дээр бас ямар байр суурьтай байгаа вэ гэж эхний асуултаа асууя.

2-т нь болохоор өнгөрсөн хугацаанд ямар нэгэн түүхэн ойтой холбогдуулаад Монголбанк зээлийн муу мэдээллийг бас арилгадаг нэг ийм тогтолцоо байгаад ирсэн. Мэдээллийг нь харагдуулахгүй болгодог арга хэмжээнүүдийг авч ирсэн. Тэгэхээр энэ нь өөрөө зээлдэгчийн санхүүгийн өөрийнх нь сахилга бат талаасаа ч гэсэн ийм эерэг, сөрөг байдлаар бол нөлөөлдөг гэж харж байгаа. Тэгэхээр энэ тал дээр янз бүрийн судалгаа мэдээлэл байна уу. Цаашид мэдээллийг оноогоор үнэлдэг болохоор энэ асуудлуудыг хэрхэх талаар ямар хууль тогтоомжоор зохицуулах боломжтой вэ гэдэг 2 дугаар асуулт.

3-д нь ингээд янз бүрийн аппликэйшн санхүүгийн банк бусын зээлийн асуудлууд аппликэйшнууд гардаг болчихсон. Иргэд банк санхүүгийн байгууллагаас зээл авахдаа зээлийн мэдээллээ шалгуулаад, тэгээд 1 газраа шалгуулаад зээл авчхаад, шууд тэр өдрөө тэр мэдээллээ ашиглаад дараагийн аппликэйшнаар ч юм уу, дараагийн банк бусаас зээлээ авах боломжтой болчихдог ийм цоорхойг бас зээлдэгч ашиглаад яваад байгаа. Тэгэхээр энэ мэдээллийг ашиглах, зээл авах чанаргүйдлийн асуудал бас хөндөгдөж эхэлж байгаа. Тэгээд энэ төрлийн эрсдэлээс зээлдүүлэгчийг хамгаалах талаар бас Монголбанк ямар арга хэмжээ авч байгаа вэ гэсэн 3 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Эхний асуултад яг хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр 10.3 гэж орж байгаа. Тэгэхээр энэ заалт нь бол энэ хуулийн 10.1 болон 10.2-т зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашиглахыг хориглоно гээд. Тэгэхээр зээлийн

мэдээллийг зөвхөн зээлдэгчийн чадварыг үнэлэхийн хувьд ашиглана. Бусад зүйлдээ ашиглахыг хориглож байгаа юм.

Хар жагсаалт гэдэг зүйл байхгүй болно. Монголбанкны 100 жилийн ой аль эсвэл 90 жилийн ойгоор гэж нэг ёсны байгууллагын ойгоор хар жагсаалтыг цэвэрлэдэг, аль эсвэл санхүүгийн тогтолцоог нь алга болгодог зүйл бас санхүүгийн системд бас маш хор нөлөөтэй. Дахиж ийм зүйл үүсэхгүйн тулд онооны систем рүү ороод, онооны систем бодит горимоор явдаг. Зээлээ хэрвээ төлөөд байгаа бол нөгөөдөх нь оноо нь өгсөөд явна. Зээл нь төлөхгүй доголдоод байгаа бол оноо нь буурна. Эргээд төлөхөөр буцаад өсөөд явдаг ийм динамик бодит горимд орох тийм тогтолцоог зорьж байгаа юм. Үүнийг дагаад чанаргүй зээлийн хувь ч гэсэн олон улсын жишгийг харахад бол буурсан байдаг юм. Өнөөдөр Монголбанкны нийт чанаргүй зээлийн хувь нь бол 5.7 хувь байгаа. Энэ бол ковидын дараа нэлээн сайжирсан үзүүлэлт гарч байгаа юм.

Цаашлаад хэр зэрэг сайжирч чадах вэ болох вэ, хэрвээ энэ мэдээллийн систем рүү орчихвол кредит скорингод орчихвол 1,9 хувиар буурах бололцоотой гэж харж байгаа юм. Энд юундаа суурилж байна вэ гэвэл Латин Америкийн улс орнуудад яг кредит скорын зээл тэгж байна. Чадварыг нь үнэлдэг систем рүү орсноор, онооны систем рүү орсноор нийт зээлийн багц нь өөрөө 1,9 хувиар буурсан. Чанаргүй зээлийн багц нь. Энэ юутай холбоотой вэ гэвэл нөгөө зээлдэгч нь өөрөө сахилга баттай болж эхэлж байгаа юм. Тэгэхээр чинь өөрөө нийт системийнхээ эрсдэлийг бууруулаад, үүгээрээ дагуу дагуулж зээлийн нийт хүүг ч гэсэн бууруулах тийм суурь тогтолцоог нь бүрдүүлчхэж байгаа гэж ойлгож болох юм.

Аппликэйшний зээлүүдээр иргэд зэрэг гар утас асааж байгаад аваад байна гэсэн тийм шүүмжлэл ирж байгаа. Тэгэхээр хэрвээ зээлийн мэдээллийн сан нь өөрөө бодит горимоор мэдээллээ нийлүүлдэг болчихвол энэ чинь өөрөө эргээд нөгөө шинээр зээл олгож байгаа зээлдэгчийн мэдээлэл нь байж байгаа болохоор бас тодорхой хэм хэмжээний хязгаар үүсээд эхлэх юм. Санхүүгийн зохицуулах хороо энэ дээр илүү дэлгэрэнгүй хариулт нь байх.

Мөн Монголбанкнаас нэмж хариулт байгаа бол бас өгнө байх. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батшугар гишүүн ээ, Мандхай гишүүний асуулт дээр зүгээр тодруулаад нэг юм асуучихъя гэж бодоод байна. Саяын ярьсан кредит скорингийн компаниуд байгуулагдсан гэж ойлгож байгаа тээ. Тэгээд хуучин одоо иргэд, аж ахуйн нэгжийн зээлийн мэдээллийг Монголбанк гаргаж өгдөг байсныг нь компани байгуулагдаад төлбөр төлж мэдээллээ иргэн өөрөө авдаг болсон хэлбэртэй болчихсон тээ. Тэгээд энэ дээр би бас өмнө нь нэг асууж байсан шүү дээ. Зээлдүүлж байгаа, зээлдэж байгаа 2 хүн хоёулаа ижил үүрэг хүлээх, ялангуяа жишээ нь тэр зээлийн мэдээлэл авч байгаа төлбөр дээр ижил тэнцүү хэмжээний үүрэг хүлээж төлбөрийг нь 2 талаас гаргах шаардлагатай байтал ганцхан иргэн, аж ахуйн нэгж дээр төлбөр төлдгийг нь үүсгэчихсэн байна гэдэг асуудал яригдаад байгаа шүү дээ. Энэ өөрөө шударга тогтолцоо юм уу. Банк бас зээлээ өгөхийн тулд тодорхой хэмжээний судалгаагаа явуулахын тулд зардал мөнгөө хуваалцаж байх ёстой биз дээ. Тэгэхээр дээр ер нь ямар байдлаар зохицуулалт хийгдэж явах юм бэ. Энэ чинь бас хүний эрхийн асуудал шүү дээ.

2 дугаарт нь жишээлбэл, тэтгэврийн зээл. Банкнуудын өгч байгаа мэдээллээр тэтгэврийн зээл 18-19,6 хувийн хүүтэй гэдэг ерөнхий мэдээлэл тавьчихаад,

тэтгэврийн зээл авах гээд ахмадууд банкны салбар дээр яваад очихоор зээлийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг нь хөндөөд, 22, 24 хувийн хүүтэй зээл олгож байгаа байдал байгаад байна. Тэгэхээр энэ тогтоож байгаа байдал, зээлийн мэдээлэлтэй холбогдоод энэ хүү тэгж огцом өсөж байгаа байдал ер нь ямар учиртай юм бэ. Энэ дээр бас нэмэлт тайлбар хийж өгөөч Батшугар гишүүн.

Э.Батшугар: Баярлалаа. Таны ярьж байгаа маш зөв. Банк болон санхүүгийн байгууллагууд болон иргэн, аж ахуйн нэгжүүд эрх тэгшид харьцаатай байх ёстой. Өнөөдрийн нөхцөл байдалд яалт ч үгүй банкнууд болон банк санхүүгийн байгууллага илүү давуу эрхтэй үйл ажиллагаа явуулаад байгаа юм. Яг үүнтэй холбоотой бас нэг том зах зээл гарч ирэх гээд байгаа юм. Нэг ёсны би өөрийнхөө зээлийн мэдээллийн оноогоо харахад 1000 төгрөг төлөөд байгаа И-Монголиагаар ороод. Энэ нь ч гэсэн бас банканд тухайн төлбөрөө төлөөд, нөгөө тусгай зөвшөөрөлтэй 2 компаниас авах бололцоо нь байгаа. Гэхдээ тэрийгээ хийх ёстой тэр журмыг нь бас Монголбанк батлах бүрэн бололцоотой. Мөн үүнтэй холбоотойгоор нөгөө хяналт шалгалтын газар ч гэсэн бас тодорхой хэмжээнд өөрчлөлт хийх зүйтэй гэж би харж байгаа юм. Энэ утгаараа ч гэсэн би тогтоолын төсөлдөө бас илүү энэрэнгүй байх, ялангуяа тухайн иргэн нь өөрөөс нь хамаарахгүйгээр зээлийн доголдол үүсвэл тэрийг нь нэг ёсны уян хатан ханддаг тийм .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван Мандхай гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Мандухай гишүүний асуултад хариулъя. Тэр зээлийн мэдээллийн санд өөр бусад тэр СӨХ-ны төлбөр, гар утасны лизингтэй холбоотой өр төлбөрийн асуудал ороод, энэ нь бас хэрэглэгчийн санхүүгийн хууль ёсны эрх ашгийг бас зөрчөөд байна гэж. Ер нь бол зээлийн мэдээллийн санд дан ганц зээлээс гадна тухайн хэрэглэгчийн хуулиар буюу гэрээгээр хүлээсэн өр төлбөр, авлагууд бол ордог. Гэхдээ лизингээр утас авсан ч байдаг юм уу. Хэрэглээний зардлаа төлөөгүй, СӨХ-ны төлбөрөө төлөөгүй өр төлбөртэй гэсэн мэдээлэл нь арилжааны банкны зээлтэй ижилхнээр муу зээлийн түүх үүсээд ангилагдаад явдаггүй. Ангилагдаад явдаггүй. Тухайн хэрэглэгч нь өөрийн хэрэглээний зардал, СӨХ-ны төлбөрөө төлөөд барагдуулсны дараа бол тухайн төлөв нь бол хэвийн болоод явдаг. Ер нь бол гишүүн бас хөндөж байна. Хар жагсаалт гээд байдаг. Хар жагсаалт гэсэн яг тийм жагсаалт гэж бол ерөөсөө байдаггүй. Энэ бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Энхтайван: Тийм жагсаалт гэж байдаггүй. Энэ бол ерөөсөө зээлийн түүх., зээл авсан, өгсөн, зээлээ төлсөн, зээлийн нөхцөл тийм байсан гэсэн ийм мэдээллийн сангийн л үүргийг зээлийн мэдээллийн сан бол оруулж өгдөг.

Тэгээд нэмээд хэлэхэд зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч нь өөрөө төлбөрөө төлөөд, зээлийн мэдээллээ нийлүүлдэг. Зээлийн мэдээллийн сангаас үйлчилгээ авагч, хэрэглэгч санхүүгийн бүтээгдэхүүн авч байгаа тэр хэрэглэгч маань өөрөө бас төлбөрөө төлж, өөрийнхөө мэдээллийг бол авдаг. Тэгэхээр аль аль талдаа бол төлбөр нь төлөгдөөд явдаг гэсэн үг. Мэдээлэл нийлүүлэгч нь ч төлдөг, нөгөө тал нь ч гэсэн төлдөг гэсэн үг.

Тэгэхээр Зээлийн мэдээллийн сангийн хуульд өөрчлөлт орсноор дахиж ийм ямар нэгэн тэмдэглэлт ойг тохиолдуулан хувь хүний зээлийн мэдээллийн түүхийг хөшиг татаж, бусдад харагдуулахгүй байдаг тийм тогтолцоо бол байхгүй болно гэсэн үг. Яагаад гэхээр тухайн хэрэглэгч тус бүр дээр өөрийнх нь зээлийн түүхтэй холбоотой оноо нь бодогдоод гараад явахаар тэр дээр бол өөрчлөлт ерөөсөө орохгүй гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандухай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Зээлийн мэдээллийн хар жагсаалт гэж зүгээр гэж ярьсан. Би хар жагсаалт гэж хэлээгүй шүү. Нөгөө зээлээ цаг хугацаандаа төлөөгүй, эсвэл 7 хоног ч юм уу хоцорсон, магадгүй сар санхүү мөнгөний асуудлаас болоод зээлээ төлж чадаагүй хоцрогдолтой байснаас болоод муу зээлдэгчийн тэр жагсаалтад бүртгэгддэг, муу зээлдэгч гэж болдог гэдэг тийм утгаар хэлсэн шүү. Тэгээд хэрэв одоо танай дээр муу зээлдэгчээр бүртгэгдчихсэн бүртгэлд орчихоод, буцаад нэр нь сэргээгдэхдээ тэр дата өөрөө хэр удаан хадгалагддаг вэ. Жишээлбэл тэр хүн магадгүй 1 удаа үнэхээр хариуцлагагүй асуудлаас болоод зээлээ удаан төлөөгүй байгаад, муу нэрст орчихлоо гэж бодъё. Эргээд тэр хүн санхүү мөнгөний боломжтой болоод эргээд төллөө. Гэтэл тэр хүн дараагийн удаа байр сав авах ч гэдэг юм уу худалдан авалт хийгээд лизинг энэ тэрд хамрагдах болоод зээлд хамрагдах болонгуут таны дата чинь ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батшугар гишүүн нэмж хариулт өгье.

Э.Батшугар: Яг албан ёсны хар жагсаалт гэсэн зүйл байхгүй. Гэхдээ зээлийг 5 ангилдаг. Муу, анхаарал хандуулсан, чанаргүй гэх мэтчилэн. Гэхдээ эхний 2 нь хэвийн, дээрээс нь нэмээд анхаарал хандуулсан нь тодорхой зээл олгоод банк санхүү байгуулаад явдаг юм байна лээ. Нөгөө доошоо 3 руугаа орчихоор бид нээрээ нөгөө хар жагсаалт руу орчихдог. Тэгэхээр банк санхүүгийн байгууллагууд тас хаалгаа барьчихдаг. Энэ мэдээлэл нь 6 жил хадгалагдаад явчихдаг. Энэ утгаар энэ хуульд нэмэлт, өөрчлөлт орсноороо мөн дагалдах тогтоол батлагдсанаараа ямар өөрчлөлт орох вэ гэхээр илүү уян хатан болно. Тэгээд бодит горимоор хэрвээ зээлээ эргээд төлчихвөл тэр нь оноо нь сэргээд явчихна. 6 жил гэсэн зүйл байхгүй болно. Доголдол үүсвэл нөгөөдөх нь буцаад буурчихна. Тэгээд ингээд явна.

Тэгэхдээ би түрүүн хэлсэн. Өөрөөс нь хамаарахгүйгээр давагдашгүй хүчин зүйлсээс болоод доголдол үүсвэл тэрийг нь уян хатан байлгах тийм журам Монголбанк батална гэсэн тийм тогтоол орчихсон явж байгаа юм гэж танд хэлье.

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Мандхай гишүүний асуултад нэг тодруулга өгье. Хэрвээ гэрээний үүргийн дагуу зээлийн хугацаат төлбөрөө 90 хоногийн дотор төлбөр хийгдээгүй тохиолдолд анхаарал хандуулах зээл рүү ордог. Дахиад 90 хоногийн хугацаа өнгөрсний дараа чанаргүй зээл рүү ордог. Тэгэхээр ерөнхийдөө үндсэндээ зээлийн төлбөрийг 180 хоног буюу 6 сарын хугацаанд төлөхгүй явсан тохиолдолд бол зээлийн ангилал өөрчлөгддөг байгаад байгаа. Тэгэхээр энэхүү журмаар бол төв банкны зүгээс зүйл бас харьцангуй уян хатан тийм хугацааг бол олгодог. Ямар нэгэн хэлбэрээр зээлийн муу түүхтэй байлаа гээд дан ганц түүхэнд үндэслэж зээлийн хорооны шийдвэр ерөөсөө гардаггүй. Зээлийн хорооны шийдвэр гэдэг маань тухайн

зээлдэгч өөрөө санхүүгийн хэр сахилга баттай вэ гэдэг нь бол зээл олгохдоо нэг л үзүүлэлт. Тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө, барьцаа санхүүгийн орлого, чадвар, мөнгөн урсгал гээд маш олон хүчин зүйлсийн улмаас зээл олгогддог. Зээлийн түүх бол ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн алга байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орох гэж байна. Энэ хууль батлагдсанаар зээлдэгч нарын зээлжих зэрэглэлийг тогтооно гэж ойлгож байгаа. Ингэж зээлжих зэрэглэлийг тогтоосноор зээлийн хүртээмж бодитойгоор хэдэн хувь, хэрхэн яаж яг нэмэгдэх вэ. Иргэдэд бол банкны зээлийн хүртээмж муу, шаардлага өндөртэйгөөс шалтгаалан ББСБ, ломбардуудаас өндөр хүүтэй зээл авч байгаа юм. Өрөөс өрний хооронд. Орон байр, хашаа байшингаа алдах тохиолдлууд маш ихээр гарч байгаа. Тэгээд шүүх рүү явдаг. Энэ нөхцөл байдлыг нэгэнт зээлийн мэдээллийн тухай хууль дээр өөрчлөлт орж байгаа. ББСБ, ломбардуудыг ямар зохицуулалт хийх юм бэ. Дээр нь өдрийн зээл гэдэг нэг айтхтар эд байгаа. Зах худалдааны төвүүдээр мөнгө хүүлэлт явагдаж байгаа. Аман байдлаар тохиролцдог. 7 хоног, 1 сарын хугацаатай зээл яваад, хүү нь бол маш өндөр. Тэгээд энийг бол зах худалдааны төвүүдээр байгаа худалдаа эрхлэгчид маань өөрсдөө авч хэрэглэж, маш өндөр хүү төлж байгаа. Энэ дээр ямар зохицуулалт цаашдаа хийх юм бэ. Онцгойлон анхаарах юм бэ гэж байгаа.

Цахим зээлийн асуудал бас давхар яригдаад байгаа. Цахим зээлийг мөн бас маш ихээр материал бүрдүүлж, залуучууд өөрсдөө маш ихээр авч байгаа. Тэгээд ерөөсөө яг өрнөөс өрний хооронд банк санхүүгийн байгууллагаас авсан өрөө тэр цахим зээлээр ингээд л авч нөхсөн ийм хүнд байдалтай байгаа. Тэгэхээр энэ дээр яг бодит шийдвэрүүдийг бас Монголбанкныхан яг ямар юм баримталж байгаа вэ.

Маш тодорхой миний асууж байгаа асуулт бол ББСБ, ломбард байна, мөн дээр нь өдрийн зээл гэдэг юм ямар ч зохицуулалтгүй явж байгаа. Тулсан үед яг энийг л авч хэрэглэж байгаа. Мөн ломбардад өөрсдийнхөө хашаа байшин, унах унаа бүгдийг нь тавиад зээл авч байгаа. Энэ зээл бол ерөнхийдөө тулгамдсан асуудлуудаа шийдэх сургалтын төлбөр, эмчилгээний зардал гээд дандаа яг иргэдийн өдөр тутам хүн дээр тусгаж байгаа асуудлууд дээрээ л авч байгаа зээлүүд байгаа. Энэ дээр бодит бодлого хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Баярлалаа. Энэ кредит скоринг болон зээлдэгчийн зээлжих зэрэглэл тогтоодог болсноор банк болон санхүүгийн байгууллагуудын хүртээмж нэмэгдэнэ. Судалгаа асуусан та. Латин Америкийн улс орнуудад ийм систем рүү шилжсэнээр зээлийн хүртээмж 16 хувиар нэмэгдсэн. Бүр тодруулбал Колумбиа улс бол 31,7 хувиар нэмэгдсэн байна. Энэтхэг улс ч гэсэн 2000 оны эхээр онооны систем рүү шилжсэнээр 119 сая иргэн шинээр банк болон санхүүгийн банктай үүсэх харьцааг нь шинээр нээж өгсөн. Үүд хаалгыг нь нээж өгсөн ийм судалгаа гарсан. Ялангуяа эмэгтэйчүүд байгаа юм. Мөн алслагдсан дүүрэг, нутаг дэвсгэрт амьдардаг хүмүүст бүр хүртээмж нь илүү нэмэгдсэн. Яагаад гэвэл нөгөө банк нь заавал судалгаа хийгээд байх шаардлагагүй, онооны системд нь тулгуурлаад зээлээ болон бусад санхүүгийн үйлчилгээгээ олгох бололцоотой болчихож байгаа юм. Үүнийгээ

дагаад бас зээлийн хүү нь өөрөө буух бололцоотой болчихсон. Яагаад гэвэл эрсдэлийг нь тодорхойлж болно.

Бас нэг чухал зүйл хэлмээр байна л даа. Одоо жишээлбэл том банкны харилцагч байна. Тэгвэл тэр банк дотор нь тухайн харилцагчийн бүх мэдээлэл нь байгаад байгаа юм. Тэгэхээр тэр иргэн, аж ахуйн нэгж өөр банк руу шилжээд очихоор нөгөө мэдээлэл нь байхгүй юм чинь бусад банкнууд нь бас үйлчилгээгээ өгдөггүй. Тэгэхээр ямар нөхцөл байдал үүсэж байна гэвэл нөгөө нэг сурсан гэдэг юм уу бид нарын ярьдгаар тэр том харилцагч банкныхаа л нөхцөлөөр зээлээ аваад байгаа юм. Тэгэхээр энэ онооны систем рүү шилжсэнээр өөр шинэ тоглогч болон аль болох илүү өрсөлдөөний чадвартай гэх юм уу, илүү зөөлөн нөхцөлтэй банк санхүүгийн байгууллага дээр очоод, тэгээд зээл авах бололцоо нээгдчихэж байгаа юм. Яагаад гэвэл оноо нь тэр иргэний эрсдэлийг нь тодорхойлчихно. Тэгэхгүй бол жишээлбэл Хаан банк байна, Төрийн банк байна, Голомт банк байна. Эд нар дотор байгаа мэдээлэл чинь бусад банк санхүүгийн байгууллагатай хуваалцдаггүй. Тэгэхээр үүн дээр маш том блок үүсгэгдээд байдаг юм. Тэгэхээр бол шинэ тоглогч нар орж ирэхийг зах зээл нээж өгч байгаа. Мөн өрсөлдөөн үүсгэж байгаа. Хүүгийн өрсөлдөөн үүсэх бололцоо нь нээгдэж байгаа юм.

Аппликэйшний зээлийн асуудлууд байгаад байна л даа. Үүнийг зохицуулдаг үндсэн зүйл нь бол Монголбанкны талаас нь өр зээлийн харьцаа гэж байдаг. Мөнгөний бодлогын зөвлөлөөс тодорхойлдог. Энэ бол 50/50 байгаад байгаа. Санхүүгийн зохицуулах хорооны тэр үзүүлэлт нь коэффициент нь бол 60/40 байгаад байгаа юм. Тэгэхээр бас тодорхой хэмжээний энэ 2 ч гэсэн бодлогоо нэгтгэх ёстой гэж би хувьдаа боддог юм. Тэгж байж өдрөөс өдөрт зээлээс зээл гэж авах тийм нөхцөл байдал нь арилна.

Өдрийн зээл ломбардыг бол илүү Санхүүгийн зохицуулах хороо тайлбарлая гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Саяын Батшугар гишүүний өр зээлийн харьцаатай холбоотой асуудал яг арилжааны банкнуудын хувьд бол 50/50 байсан. Санхүүгийн зохицуулах хороо 70/30 байсан. Тийм ээ. Одоо өөрчлөгдөөд адилхан 50/50 болсон тийм үү. 60/40 болсон уу. 60/40 болж байгаа юм.

Тэгэхээр Алтаншагай гишүүний хөндөж байгаа асуудал ер нь яг иргэдэд ирж байгаа хамгийн том зээлийн дарамт, хүүгийн дарамт гэж зүйл хөндөгдөж яригдаж байгаа юм. Иргэд хэрэгцээ гарангуут хүү хамаагүй, богино хугацаатай мөнгө зээлдэг. Тийм ээ. Одоо 1 сая төгрөг зээлээд авчихдаг. Сарын хугацаатай юм уу, 2 сарын хугацаатай зээлээ эргээд төлчхөж байгаа юм. Тэр сард төлж байгаа хүү нь магадгүй 3 хувьтай, 4 хувьтай шахуу болоод ирэхээр хүү нь нөгөө 1 сарын хугацаанд их мэдрэгддэггүй. Гэхдээ банк бус санхүүгийн байгууллагууд, ломбардууд энийг богино эргэлттэй, өндөр хүүтэй мөнгө хүүлэх тийм байдал газар авчихсан байна гэдэг зүйл ажиглагдсан.

Ирэх 7 хоногт Монголбанкны удирдлагуудтай хамт арилжааны банкнуудтай уулзалтыг хийж эхлэх гэж байна. Их Хурлын зүгээс зээлийн хүү буурахтай холбоотой, зээлийн хүүгийн бүтэцтэй холбоотой асуудлаар банкнуудтай нээлттэй ярилцах энэ ажлыг зохион байгуулна. Ахиад банкнууд дэргэдээ ББСБ байгуулчихсан. Банкаас арилжааны зориулалттай зээл аваад, тэрийгээ ББСБ-аар цаашаа иргэдэд хэрэглээний зээл болгож өгч байгаа байдал бол бас их анхаарал

татаж байгаа асуудал болсон. Зөвхөн 2024 оны байдлаар гэхэд банкнуудаас зээл авсан банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн дүн нь 700-аад тэрбум төгрөг болчихсон байж байгаа. Тэгээд тэрийгээ жилийн хүү нь магадгүй банк дээрээс олгогдож байгаа 20-24 хувийн хүүтэй байсан бол ББСБ-д аваачаад 36-50 хувийн хүүтэй зээл олгож хувиргасан тохиолдол, ахиад ББСБ-аас цаашаагаа ломбардуудад эх үүсвэрийг нь бий болгож өгөх замаар илүү өндөр хүүтэйгээр богино хугацаатай иргэдэд зээл олгож байгаа байдал байна.

Тэгээд энийг л бид ерөөсөө Улсын Их Хурлын түвшинд цэгцэлж өгөх ажил бол их чухал юм байна гэж ингэж үзэж байгаа. Магадгүй Улсын Их Хурлаас иймэрхүү ажил арга хэмжээ яриад унахаар яг иргэдэд олгодог хэрэглээний зээлүүдийг зориудаар багасгах ажил хүртэл энд зохион байгуулалттай хийгдэж иргэдийг бухимдуулах ажил бас давхар явагддаг юм байна лээ. Тэгэхээр энэ асуудлыг ерөөсөө л Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны Хяналтын зөвлөл, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөл, Хяналтын Хороо зэрэг байгууллагууд бас анхааралдаа авч ажиллах ийм шаардлагатай гэж үзэж байгаа. Санхүүгийн зохицуулах хорооноос энэ дээр Итгэлсүрэн дарга нарийвчилсан мэдээлэл өгөөдөх өө. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Б.Итгэлсүрэн: Сайн байцгаана уу. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Банк бус санхүүгийн байгууллагууд бол Зээлийн мэдээллийн тухай хуулиар зээлийн мэдээллээ нийлүүлэх үүрэгтэй этгээд гэж явдаг. Тэгэхээр яг адилхан арилжааны банкнуудтай адил Монголбанкнаас зээлийн үйлчилгээ үзүүлэх 2 тусгай зөвшөөрөл авсан 2 компаниас мэдээллээ аваад, үйлчилгээгээ аваад явж байгаа. Энэ онооны схем орж ирснээр банк бус санхүүгийн байгууллагууд онооны схемийн дагуу шууд зээл өгөх боломжтой. Ингэснээр үйл ажиллагааны зардал дээр нь хүртэл тодорхой буурах ийм ач холбогдол үүснэ гэж бодож байгаа юм. Ингэснээр бол мэдээж хамгийн гол нөлөөлөл нь бол зээлийн хүү буурах ийм боломж бүрдэнэ гэж ойлгож байгаа.

Алтаншагай гишүүний тодруулсан дээр нэмж хэлэхэд 2022 онд Улсын Их Хурлаас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль гэж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энэ дээр хэдүүлээ их тодорхой ажиллана шүү. Одоо ингээд л зээлийн мэдээллийн сангийн талаар компаниуд мэдээллийг нь гаргаж өгдөг болсон гээд л ахиад л иргэдээс авдаг мөнгө, төлбөр хураамж бас нэгээр нэмэгдээд л явчхаж байгаа юм. Тийм ээ. Арилжааны банкнуудын мөнгөн шилжүүлэгтэй холбоотой төлбөр гээд л бас ахиад л олон төрлийн асуудал үүсэж л байдаг. Тэгээд иргэд, аж ахуйн нэгжийн төлдөг төлбөрийн тоо л нэмэгдээд байдаг. Дүн нэмэгдээд байдаг. Эргээд үзүүлж байгаа хөнгөлөлт гэдэг зүйл нь их сул байгаад байгаа учраас энэ дээр хэдүүлээ яг тийм иргэдийнхээ эрхийг хамгаалах, хангах чиглэлээс бодож ажиллах шаардлагатай. Тэгээд Санхүүгийн зохицуулах хороо энэ дээрээ бас тодорхой бодлогоо хэрэгжүүлээд ажиллаж байгаа юм байна лээ. Тэгээд ирэх 7 хоногоос бас уулзалтуудаар гишүүдэд бас мэдээллүүд өгөгдөөд явна гэж ингэж бодож байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн тодруулж асууя.

Н.Алтаншагай: Ломбардтай холбоотой болон өдрийн зээлийн талаар мэдээлэл өгсөнгүй. Би зах худалдааны төвүүдээр өнгөрсөн 7 хоногт орж үзсэн. Худалдаа эрхлэгчидтэй уулзсан. Сарын 10 хувийн хүүтэй, жилийн 120 хувийн хүү юм уу даа. Энэ чинь маш далд хэлбэрт байгаад байгаа шүү дээ. Энэ дээр яг ямар

арга хэмжээ авч, энэ худалдаа эрхлэгчдэдээ ямар боломжийг олгох юм бэ. Энд бол худалдаа эрхлээд байгаа нөхдүүд маань дандаа л гэр хорооллын чиглэлийн яг бор зүрхээрээ өөрсдийгөө авч явж байгаа иргэд байгаа байхгүй юу. Гэтэл өдрийн болон 7 хоног, тэгээд 20 хоногоор хүүгээ тооцож өгдөг. Тэгээд сарын 10 хувь, жилийн 100, 120 хувийн хүүтэй яг ийм зээлийг бодитоор авч хэрэглэж байгаа шүү дээ. Энэ нь тэгээд бүр далд хэлбэрт шилжчихсэн. Мөнгө хүүлэгч нар гээд ердөө бүгд тодорхой байж байдаг. Өдөр болгон очоод 500 мянган төгрөг аваад, орой нь эргэлдүүлээд өгдөг. 40-50 мянган төгрөг хүүд нь өгдөг яг л ийм бодит нөхцөл байдал байгаа шүү дээ. Энэ дээрээ нэг бодлого гаргаж дорвитойхон шийдвэр гаргахгүй бол ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Алтаншагай гишүүн тэр өдрийн зээлтэй холбоотой асуудал ярьж байна. Яг энэ дээр бол мэдээж бид бүхэн өнгөрсөн жил бол хэд хэдэн судалгаа хийгээд явсан. Яг энэ дээр өдрийн зээлтэй холбоотойгоор иргэд бол хэт өндөр хүүтэй зээлийг бусдаас богино хугацаатай аваад, түүгээрээ санхүүгийн дарамтад ороод байгаа тухай асуудал бол маш олон жил яригдаж байгаа. Тэгээд энэ дээр бол Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль гэдгийг бол төв банкнаас ажлын хэсэгт нь ороод ажиллаад явж байгаа. Ерөнхийлөгчийн Тамгын газар дээр бол ажиллаад өргөн барихаар бол явж байгаа. Тэгээд Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийн тухай хууль дээр санхүүгийн хэрэглэгчийг хамгаалсан тийм бүлэг зохицуулалт бол орж ирнэ. Яг энэ дээр бол өдрийн зээлтэй холбоотойгоор зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон тийм зохицуулалтыг бол хийж өгөхөөр ажиллаж байгаа.

Тэр ломбардтай холбоотой дээр бол ломбард гэдэг маань өөрөө тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрлөө авдаг. Энэ дээр бол Санхүүгийн зохицуулах хорооны тэр зөвлөлөөс хүүгийн дээд хязгаарыг бол тогтоогоод явдаг.... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт орсноор зээлийн мэдээллийн санг бүрдүүлж байгаа үйл ажиллагаанаас хамааралтайгаар ямар нэг байдлаар санхүүгийн хариуцлага хүлээх асуудал дараа нь үүсэх үү, үгүй юу гэдэг талаар бодолцсон зүйл байгаа юу.

2 дахь асуулт нь Засгийн газар, Улсын Их Хурал бүгдээрээ зөвшөөрлийн олон зөвшөөрлийг, журмуудыг цэгцэлье. тоог нь цөөлье л гэж яриад байгаа. Энэ чинь дахиад журам шинээр нэмэгдэх үүд хаалга нээж өгч байгаа асуудал байна уу. Ер нь шат шатны байгууллагуудын янз бүрийн гаргасан журмууд бол хүнд суртал, авлига, иргэний эрх чөлөөнд халдсан ийм л журам болчихоод байгаа юм. Хууль тогтоох чиглэлээр процессын хуулиудыг Улсын Их Хурал батлах чиглэл рүүгээ явдаг байвал яадаг юм бэ. Бас нэг журам нээгээд байх нь тийм зөв зүйл мөн үү, биш үү гэдэг тухай асууж байна.

3-д нь Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт орсноор банкнуудын эрх ашиг нэмэгдэж байгаа юу. Хасагдаж байгаа юу. Тэд нарын магадгүй нөгөө эрсдэлийг нь хаах байдаг юм уу, үгүй бол ашгийг нь дээшлүүлэх чиглэл рүү энэ хуулийн

өөрчлөлт чинь үйлчлэх үү, үйлчлэхгүй юу. Иргэдийн зээл авч байгаа өөрсдийнхөө амьдрал ахуйг болгоод явж байгаа иргэдийн амьдрал ахуйд сайнаар нөлөөлөх үү, муугаар нөлөөлөх үү гэдэг тал дээр ямар бодолтой байгаа юм.

Дээрээс нь өнөөдөр Монгол Улсын 3 сая хүмүүс чинь бүгдээрээ л банк, ББСБ, ломбардын ажилчид болчихлоо шүү дээ. Бүтээгээд л байдаг, хийгээд л байдаг, тэд нарын дааж давшгүй хүүнүүдийг нь төлсөөр байгаад хамгийн сүүлд нь өөрт нь үлдсэн юм байдаггүй. Нөгөө банкнуудынхаа ашиг нь хэдэн 100 тэрбум төгрөгөөр тоологдож байдаг. Банкнууд нь эргээд бизнесийн зах зээл дээр төсөл хэрэгжүүлэгч болоод, иргэдийнхээ санаачилсан мэдээ мэдээллийг булааж авдаг, бизнес эрхэлдэг ийм болчихсон. Банкны хувьцаатай, банкны хөрөнгө оруулагчид, банк өөрөө өөр зах зээл дээр бусад зах зээл дээр бизнес эрхлэх нь зөв юм уу, буруу юм уу. Монголбанкны болон бусад газруудын Монголбанк, Сангийн яам гээд л яригдаж байдаг. Олон дарга нар банк бус санхүүгийн байгууллагуудтай хүүгийн орлого олж байдаг гэдэг ийм зүйл яригдаад байдаг. Энэ чиглэл рүүгээ яаж ажиллах юм бэ.

Мөнгө хүүлэлт одоо Гобсик гээд зохиол дээр гардаг шиг мөнгө хүүлэлт бол Монголд хязгаараа алдсан шүү дээ. Аль ч гудамж талбайгаар явахад 10 хаягийн 3-аас дээш нь, 5 ч юм уу банк бус, ломбард гэсэн хаягууд л байгаад байгаа шүү дээ. Монголд явж байгаа, Улаанбаатар хотод явж байгаа бизнесийн компаниуд, гудамжны хаягуудыг, байшин барилга дээр байгаа хаягуудыг харахад тэр аягыг тоолоход л хэчнээн хүүтэй мөнгө зээлдүүлдэг газрууд байна вэ гэдэг. Албан ёсны эрхтэй буюу эрхгүй өөрөөр тэр өдрийн зээл гэж ярьдаг шиг ийм зүйлүүд замбараагүй явж байна. Энэ чиглэл рүүгээ өөрчлөлтүүд хэр орж байгаа юм бэ. Санхүүгийн эрх чөлөөтэй Монгол хүнийг бий болгох, бүтээхийн төлөө бид нар ажиллах ёстой. Тэгэхээр ийм журам нь зөв явж байна уу. Тэр чиглэлд.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Энхбаярын Батшугар гишүүн хариулт өгье.

Э.Батшугар: Яах вэ, зээлийн онооны системд орсноор бол хэний эрх ашиг хөндөгдөх вэ гэвэл нэг ёсны зээлдэгч болон иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашиг нь бол давуу байдалтай болно. Ямар байдлаар үйлчлэх вэ гэхээр 1 дүгээрт тэр оноогоо үзүүлээд ямар ч банк санхүүгийн байгууллагад очоод, шууд үйлчилгээгээ авах бололцоо нээгдэж байгаа юм. Үүнийгээ дагаад бас чанаргүй зээлийн түвшин ч багасна. Тэгэхээр нь энэ бол нөгөө талдаа банкнууд ч гэсэн харахдаа эрсдэл нь өөрөө багасаад, тэгээд хүүгээ бууруулах бас нөхцөл байдал үүснэ. Тэгэхээр тал талдаа л ашигтай тийм систем л дээ. Тогтолцооны өөрчлөлт ороод байгаа юм л даа. Заавал 6 жилийн хар жагсаалт гэхгүйгээр байнгын динамикаар хөдөлж байдаг онооны систем рүү ороод, үүнийгээ дагаад хэрэглэгч болон аж ахуйн нэгжүүд бага хүүтэй зээл авах бололцоо нь үүснэ. Иргэн ч мөн адилхан. Банк талдаа, санхүү байгууллага талдаа чанаргүй зээлийнх нь хувь нь нийт системээрээ буурна. Мөн үүнийгээ дагаад хүү буурна. Мөн барьцаа хөрөнгийн шаардлага ч гэсэн тодорхой хэмжээгээр буурна. 13 хувиар буурч байсан, буурсан тийм судалгаа гарсан.

Заавал журам уу гэхээр Монголбанкнаас журам батлаад яг тоглоомынхоо дүрмээ батлах юм. Энэ үйлчилгээг нь зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээг нь 2 тусгай зөвшөөрөлтэй компани гүйцэтгэнэ. Өнөөдрийн байдлаар. Тэгэхдээ үүнээс ч олон компаниуд бий болох бололцоотой. Хуулиар хаасан зүйл байхгүй байгаа. Гол нь шаардлагаа л хангаж байгаа бол тэгээд шинээр бүртгүүлээд тусгай зөвшөөрлөө аваад үйл ажиллагаагаа явуулах бүрэн эрх байгаа. Тэгэхээр яг төрийн талаас тодорхой хэмжээний хяналт тавьдаг юм байна лээ. Нөгөө компаниуд нь яг Хувь

хүний тухай нууцын хуулиа хангаж байна уу, зээлийн мэдээллийн хуулиа хэрэгжүүлж байна уу. Яг шударгаар нөгөө хүнийхээ оноог нь тавьж зээлжих зэрэглэлийг нь оноожуулж байна уу гэх мэтчилэн. Яах вэ бүх дэлхийн жишгээр бол яг л тийм байдаг юм байна лээ. Солонгос, Япон, Энэтхэг, Герман, Австри, Канад гэх мэтчилэн улс оронд онооны системд хамгийн шилдэг онооны системтэй улс оронд бол яг л төрийн байгууллага нь хянадаг, хувийн хэвшил нь тэр үйлчилгээгээ өгөөд явдаг. Тэгээд тэр үйлчилгээ өгч байгаа хувийн хэвшил нь хоорондоо бас өрсөлдөх бололцоог нь нээнэ. Яагаад гэвэл хэрэглэгчид сонголт байгаа.

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван нэмж хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Хуулийн төслийн 2.14.3 дахь хэсэгт заасан тэр журмын тухай бол гишүүн хөндлөө. Төв банкны тухай хуулийн 5 дугаар зүйл дээр бол Монголбанк нь банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах гэж Монголбанкны үндсэн зорилгуудын нэгийг бол тодорхойлсон байдаг. Тэгэхээр бид бүхэн бол үүнээсээ хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэгээд зээлийн мэдээлэлтэй холбоотой дэд бүтцийг тэнцвэртэй зохистойгоор ашиглах, тэгээд зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн оноог тогтооход баримтлах үндсэн шаардлага, зарчмуудыг бол тодорхойлох, хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах байдлаар банк болон санхүүгийн байгууллагуудын эрсдэлийг бууруулах гэсэн тийм үндсэн зарчмыг энэхүү журамдаа тусгаж өгөх. Энэ журмыг баталснаар тухайн санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд нь тухайн хэрэглэгч хууль ёсны эрх ашгаа ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болсон уу. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх 2 гишүүн нэр ирсэн байна. Энхбатын Болормаа гишүүн. 2 дугаар индэр дээрээ хууль санаачлагч Батшугар гишүүг рүү харж байж дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлнэ.

Э.Болормаа: Батшугар гишүүний санаачилсан Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь энэхүү системийг илүү уян хатан болгож, олон харилцагч иргэдэд боломжийг нээх зорилготой гэж ойлгож байгаа тул асуудлыг хэлэлцэхийг бол дэмжиж байна.

Өнөөдрийн байдлаар бол Монгол Улсад зээлийн хар жагсаалт гэх зүйл бодитоор хэрэгжиж байна. Хэдий албан бус боловч гэсэн 1 удаа алдсанаасаа болж 6 жил зээлийн харилцаанд албан ёсоор орох ийм боломжгүй нөхцөл байдал бүрдсэн байгаа нь бусад улс орнуудтай харьцуулахад бол хэтэрхий харгис ийм тогтолцоо байгаа. Энэ тогтолцоог өөрчлөх гэж зээлийн мэдээллийн зээлийн чадварыг оноогоор тогтоох систем буюу бид нарын ярьж байгаа скорын системийг бүрэн хэрэгжүүлснээр ер нь муу түүхтэй ч гэсэн зээл авах боломжийг бол нээж өгөх зорилготой. Ер нь тухайн харилцагчид өөрийнх нь зээлийн түүхт нь, тухайн оноонд нь таарсан байдлаар л банк бол зээлийг олгох боломжтой, хүүг нь тухайн оноонд нь тохируулаад олгох ийм зорилготой гэж үзэж байгаа учир дэмжиж байна.

Харин оруулж ирсэн нэмэлт, өөрчлөлтөөр 2 саналыг онцгойлон цаашид анхаарч, хэлэлцүүлэх явцад анхаараасай гэж үзэж байгаа нь эхнийх нь бол 14.3-д оруулж ирж байгаа зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас баталсан онооны аргачлалын дагуу тогтооно гэдэг нь өөрөө зохимжгүй гэж үзэж байна. Яагаад гэвэл Монголбанк өөрөө зохицуулагч байгууллага. Нөгөө аж ахуйн

нэгжүүдэд скорын систем байгуулах аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлөө олгодог байгууллага. Монголбанкнаас нэг аргачлал тогтоодог, тэр нь хэтэрхий хатуу ч юм юм уу, хэтэрхий зөөлөн ийм систем байх нь энэхүү салбар нь яг скоринг систем хийх эдгээр байгууллагууд нь аргачлалаа сайжруулахыг нь хааж байгаа.

Тэгэхээр нэгэнт түрүүн Батшугар гишүүний хэлсэнчлэн том зах зээл үүсэж байгаа. Скоринг үүсгэх тэдгээр аж ахуйн нэгжүүддээ дотоод хяналт хийдэг аргачлалыг нь хянаж шалгах үүднээс зохицуулагч байгууллага оролцох нь зүйтэй гэж үзэж байна. Тэрнээс биш Монголбанк бүх зүйлийг яг ийм байдлаар хийх ёстой гэвэл эргээд нөгөө скоринг системийнх нь илүү боловсронгуй болох боломжийг нь хааж байна гэж үзэж байна.

Нөгөө 2 дахь зүйл нь болохоор энэ хууль дээр их тийм зөв санаагаар гэж бодож байна. Уг нь бол уян хатан болгох зорилгоор 6 жил зээлийн мэдээллийг хадгалдгийг 6 хүртэлх болгож өөрчлөх санал оруулж ирж байгаа нь цаашдаа бас магадгүй морал хаусерт үүсэх боломжтой юм уу. Нөгөө хар жагсаалтад байдаг хүмүүсээс нэг арай танил талтай нь зээлийн мэдээллээ 6 сарын дараа хаалгуулчихдаг, арилгачихдаг. Тэгээд танил талгүй нь 6 жил зээлийн мэдээллээ байлгаж байдаг, яг бодит хэрэгжилт дээр ийм нөхцөл байдал үүсэх вий дээ гэсэн эрсдэлийг харж байна.

Тийм учраас энэ дүрэм нь бол анхнаасаа тодорхой бүх хүнд ижил тэгш үйлчилдэг байх ёстой. Нэг талдаа зөвхөн хар жагсаалт гэж яриад байгаа энэ муу түүхээсээ болоод зээл авч чадахгүй байгаа нөхцөлийг арилгах гэж скоринг системээ хийж байгаа учир нэгэнт тэр скоринг систем дээрээ л анхаарах ёстой. Аль алийг нь барих гээд байх биш, скоринг системтэй муу түүхтэй ч гэсэн зээл авах боломжийг л бид нар нээх гэж байгаа учир тэр түүх нь бүгдэд ижил тэгш үйлчлэх ёстой гэж харж байна. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцэхийг бол дэмжиж байна. Харин цаашдаа хэлэлцэх асуудал дээр энэ 2 зүйлийг онцгойлон анхаараач гэж хууль санаачлагчид онцгойлон хүсэж байна.

Ер нь бол 1 удаа алдаад л бүх хаалга нь хаагддаг, бүх банк санхүүгийн системээс хязгаарлагдаж, өндөр хүүтэй зээл рүү банк бус руу түлхэгддэг энэ системийг арилгах зорилготой хийж байхдаа энэ хэрэгжилтийн хэд хэдэн алдаа үүсэх вий гэдэг эрсдэлийг анхаараач ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болормаа гишүүн дэмжиж үг хэллээ. Батын Батбаатар гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэр дээр урьж байна.

Б.Батбаатар: Өнөөдөр Зээлийн мэдээллийн сангийн хуульд өөрчлөлт оруулахаар Их Хурлын гишүүн санаачлан өргөн барьж байгаа. Хуулийг хэлэлцэх эсэх дээр бол хэлэлцэх нь зүйтэй. Энэ асуудлыг хэлэлцэхээс гадна бид нар өнөөдөр сүүлийн 30 гаруй жилийн Монголын санхүү, эдийн засгийн нөхцөл байдал зөвхөн банкнуудын хамааралтайгаар явж ирлээ. Банкнаас буюу хүүтэй мөнгө зээлдүүлэгчээс бусад санхүүгийн зах зээл Монгол Улсад өсөж хөгжиж тэнийхгүй байна. Санхүүгийн эрх чөлөөтэй Монгол хүн өнөөдөр Монголд хэд байгаа юм бэ гэхэд хэтэрхий бага тоо харагдаж байна. Нийт 100 орчим хүн 6,8 их наяд төгрөгийн хадгаламжтай байж байна. Ийм цөөхөн хүнд дунджаар 1 хүнд 70 орчим тэрбум төгрөгийн хадгаламжтай 100 орчим хүн байна гэдэг ийм мэдээлэлтэй байж байна.

Тэгэхээр өнөөдөр бид нар санхүүгийн зах зээлийг яаж өөрчлөх юм бэ гэдэг дээр анхаарал, дүгнэлт хийх ёстой. Банк, ББСБ, ломбардын ажилчин болсон 3 сая

монголчуудаа энэ хүчир хүнд ажлаас нь салгах чиглэлд ажиллах ёстой. Мөнгө хүүлэлтийн эсрэг Улсын Их Хурал анхаарлаа хандуулж, ажлын хэсэг байгуулж, мөнгө хүүлэгчдийн эсрэг хууль, эрх зүйн орчныг өөрчлөх чиглэл рүү ажиллах хэрэгт. 30 жилийн санхүүгийн үйл явц, хөрөнгийн бирж, хоёрдогч үнэт цаасны зах зээл, бусад санхүүгийн арга хэрэгслүүд Монголд хөгжихгүй байгаа нь Монголын банкнуудын лобби Улсын Их Хуралд үеийн үед ноёрхож ирснээс үүдэлтэй. Тэдний лобби явсаар ирснээс үүдэлтэй гэж харж байна.

Өнөөдөр байгаа мэдээллийн сангийн хуульд өөрчлөлт оруулахдаа иргэдээ оноожуулж, хүртээмжтэй зээлтэй болгож гэдэг тайлбарууд явж байгаа боловч журмын төслүүдийг нөгөө зөвшөөрөл олгодог журам олгодог зүйлүүдийг дахиад нөгөө эрх мэдэлтэй хэсэг рүү шилжүүлэх, захиргааны байгууллагад шилжүүлэх тэр чиглэл рүүгээ орж ирж байгаа нь харамсалтай байна. Монголд өнөөдөр монгол төгрөгийн ханшийн уналт 1төгрөг өнөөдөр тэр хэмжээний талбай бүрдэг обойноос хямд үнэтэй болчихсон. Магадгүй 100 төгрөг ч тийм болсон байгаа. Монгол төгрөгийн ханшийн уналт, инфляц, өндөр хүү энэ бүгдээс иргэдээ аврахын төлөө Улсын Их Хурал анхааран ажиллаж, зайлшгүй яаралтай санхүүгийн зах зээлийн өөрчлөлтийг хийх нь зүйтэй гэж харж байна.

Монголд бүх төрлийн бизнес санхүүгийн байгууллагуудынх болж хувирсан. Монголд өнөөдөр аливаа зүйлийг ивээн тэтгэж байгаа, шоу тэмцээнийг ивээн тэтгэж байгаа газар бол санхүүгийн байгууллагууд л байгаа. Мөнгө хүүлэгчдээс 3 сая монгол иргэнээ аврахын төлөө Улсын Их хурал өөрөө ажлын хэсэг байгуулж, энэ чиглэлээр бас ажиллаасай гэж хуулийг хэлэлцэж байгаа ташрамд дахин сануулж, Их Хурлын даргад хаяглаж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Бүртгэлийн санал хураалт, ирц бүртгэл хийнэ. 52 гишүүн байгаа юм байна. Гишүүд орж ирж санал хураалтад орьё. Дараачийн асуудал 64 гишүүнээр босготой шүү дээ. Транс-Азийн төмөр зам соёрхон батлах асуудал. Санал хураалтаа явуулах уу. Гишүүд анхааралтай санал хураалтдаа оролцохыг хүсье. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Загджавын Мэндсайхан гишүүн микрофон өгье.

3.Мэндсайхан: Их Хурлын дарга аа, санал хураалт дээр төхөөрөмж улайчихлаа гацаад. Тэгэхээр санал хураалтыг дахин хурааж өгнө үү гэж хүсье. Хүчингүй болгоод.

Д.Амарбаясгалан: Загджавын Мэндсайхан гишүүний горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Хэрлэн гишүүнийх яагаад уншихгүй байгаад байна. Алив Хэрлэн гишүүний төхөөрөмжийг очоод шалгаадах даа Ган-Эрдэнэ дарга. Тэгвэл Загджавын Мэндсайхан гишүүний горимын саналыг хүчингүй болгох санал хураалтыг

явуулаадахъя. Санал хураалт. 50 гишүүн буюу 50,5 хувиар санал хүчингүй болгох санал. Одоо үндсэн санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураах ёстой. Хэрлэн гишүүнийх яагаад болохгүй байна вэ. Болсон уу. Одоо үндсэн нөгөө түрүүн гишүүд бас санал өгсөн боловч төхөөрөмж дээрээ саналаа өгч чадаагүй гишүүд байгаад байгаа. Тэгэхээр үндсэн нөгөө дэмжигдээгүй саналыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт. Санал хураалт хүчингүй боллоо. Тэгэхээр яах юм. Тийм яах вэ, нөгөө түрүүн үндсэн нөгөө санал хураалт дээр гишүүд бас зарим нь саналаа өгч чадаагүй тэгээд нөгөө санал хураалт дэмжигдээгүй дүн гарсан юм. Тэрийг Мэндсайхан гишүүн саналаа өгч чадаагүй учраас горимын санал гаргаад хүчингүй болгуулах санал гаргасан. Үгүй үгүй. Үндсэн санал хураалтыг хүчингүй болгуулах горимын саналаар санал хураасан байхгүй юу. Сая тэгээд тэр горимын санал дэмжигдчихсэн. Тэгэхээр одоо Байнгын хорооны саналаар Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 57 гишүүн буюу 57 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Гишүүд ээ, Мөнхсоёл гишүүн ээ санал хураалт явагдаж байна.

Улсын Их Хурлын чуулган хуралдаж байхад давхардуулсан ажил арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүнд чөлөө олгохгүй гэдгийг би үдээс өмнөх хурал дээр хэлсэн. Тэгэхээр уулзалттай гээд чуулганаас гарч явах зохимжгүй шүү. Үндсэн ажил чинь энд байгаа шүү. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт. 56 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

16.12 цаг.

Өнөөдрийн сүүлийн хэлэлцэх асуудал орж ирж байна.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулна. Индэрт урьж байна. Дэлгэрсайхан гишүүн байж байгаарай.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь гишүүдийн олонх дэмжсэн тул Эдийн засгийн байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүллээ.

16.13 цаг.

Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2006 онд НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын чуулганаар баталсан бөгөөд Монгол Улсын Их Хурал 2007 онд соёрхон баталсан. Энэхүү хэлэлцээр нь олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамуудыг тодорхойлсон бөгөөд хэлэлцээрт оролцогч талууд тус тусын бодлогын бичиг баримтын хүрээнд хэрэгжүүлбэл зохих уялдуулсан төлөвлөгөө хэлбэрээр батлагдсан.

2024 оны 12 дугаар сарын байдлаар хэлэлцээрт оролцогч 25 улс байгаагаас манай 2 хөрш болох Орос, Хятад 2 багтаж байгаа юм. Транс-Азийн төмөр замын сүлжээний ажлын хэсгийн 2023 оны хуралдаанаар тус хэлэлцээрт Төмөр замын тээврийн мэдээллийг цахимаар солилцох ерөнхий зарчмуудыг шинэ 3 дугаар хавсралтаар нэмж баталсан.

Тус зарчмуудын зорилго нь Транс-Азийн төмөр замын сүлжээ нь төмөр замуудын хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллага гаалийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл солилцохтой холбоотой зохицуулалтыг уялдуулах үндэс суурийг бий болгосон.

Монгол Улс нь тус хэлэлцээрт оролцогч улсын хувьд хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор бусад улс орнуудтай нэг зарчимд тулгуурлан төмөр замын тээврийн цахим мэдээлэл солилцох, энэ талаар нарийвчилсан 2 талт болон олон талт гэрээ хэлэлцээр байгуулах боломж бүрдэх бөгөөд ингэснээр төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөхөд түлхэц үзүүлнэ гэж үзэж байна.

Иймд “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөх хэлэлцүүлэхээр ирүүлсэн “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд дээрх хэлэлцээр хэрэгжих тохиолдолд эдийн засгийн симуляцыг тодорхой хийх, эдийн засгийн эргэлтийг түргэтгэх, үр өгөөжийг тооцоолох, эдийн засгийн хувьд Монгол Улсын

өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх талаар хийсэн судалгаа, шинжилгээ, хэрэгжих тодорхой үечлэл хугацааны талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд танилцуулдаг байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат транзит тээврийн үнэ өртгийн талаар, зорчигч тээврийн болон ачаа тээвэрлэлтийн хугацааг нарийн баримтлах талаар, төмөр замд хэчнээн ажилтан, албан хаагчид ажилладаг талаар тодруулан асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Д.Ганбат нар хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд далайд гарцгүй Монгол Улсын хувьд олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэх нь зөв зүйтэй бөгөөд цаашид экспортын бодлого, худалдааны бодлого, эдийн засгийг илүү бэхжүүлэх бодлогод анхаарч, идэвх санаачилгатай ажиллах, төмөр замын бүтээн байгуулалтад онцгойлон анхаарч, цахилгаан галт тэрэгтэй болох боломж нөхцөлийг судлах, транзит тээврийн асуудлыг нарийн төлөвлөж боловсруулах шаардлагатай талаар үг хэлсэн болно.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хүчитбаатарын Итгэлт мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхээгийн Мяндасмаа мөн яамны Төрийн захиргааны удирдлагын Хуулийн хэлтсийн дарга, Данзан-Яринпилын Мөнхбат мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын Төмөр замын тээврийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баттогтохын Батнасан Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 3 гишүүн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Дэлгэрсайхан сайдаас бас нэг зүйлийг асууя. Тэгэхээр Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого бичиг баримтыг 2010 онд баталсан. Энэ бодлогын бичиг баримтаар хэрвээ Улаанбаатарын төмөр замын тэр замаас салаалсан болон давхацсан тохиолдолд заавал өргөнөөр байна гэсэн ийм заалттай. Тэрний дараагийн заалт нь бол хэрвээ уул уурхайн ордоос хилийн боомт хүртэл төмөр зам тавих тохиолдолд өргөн байх уу, нарийн байх уу. Өөрөөр хэлбэл

Орос руу өргөн байх уу, БНХАУ руу нарийн байх уу гэдгийг Засгийн газрын өргөн барьснаар Их Хурал тогтооно гэсэн ийм заалттай.

Тэгэхээр ер нь бол саяхан манай намын бүлэг дээр Ерөнхий сайд орж ирээд, дээрээс нь яг асуудлаар бас Баттулга ерөнхийлөгч ч бас нэлээн төмөр замын асуудал ярьдаг. Тэгээд 2 хоорондоо бол асуулт, хариулт ярьж байхад бол ер нь царигийн асуудал цаашдаа нэг их асуудал биш болсон гэж хоёулаа хүлээн зөвшөөрч байх шиг байна лээ. Тэгэхээр энэ тохиолдолд төмөр замын тээврийг хурдан шуурхай явуулахын тулд дээрээс нь 2 хөрштэйгөө бодлого нэг байхын тулд Орос руу өргөн төмөр замаар, Хятад руу уул уурхайн ордоос нарийн царигаар төмөр зам тавих тухай асуудал ер нь бол Засгийн газрын бодлого байж чадаж байгаа юу. Цаашаа яаж энэ асуудлаа шийдэх вэ. Би өнгөрсөн Парламентын үед бол нарийн цариг нь уул уурхайн боомтоос тухайн улс руу ямар цариг байна тэрэнтэй нь адилхан төмөр зам тавих тухай тогтоолын төслийг өргөн барьж байсан. Тэгэхээр энэ дээр ер нь Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм. Цаашдаа ямар эрх зүйн актыг дагаж шийдвэрлэх юм. Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ер нь Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын бичиг баримтад бол Монгол Улс бол анхнаасаа Орос Монголын хамтарсан хувьцаат нийгэмлэг гэж ярьдаг. Бид нарын нэрлэдгээр Улаанбаатар төмөр зам маань өргөн царигийн төмөр зам. Тэгээд мөн ялгаагүй өмнө нь бас Ганцмод-Гашуунсухайтын зам дээр бас өргөн нарийн гэж Улсын Их Хурлаас 10 гаруй жил бас маргалдсаны эцэст нарийнаар анхны шийдвэр гараад, дараагийнх нь шийдвэр бол өргөн болж ингэж тавигдсан.

Цаашдаа бол би өөртэй чинь бол санал нэг байгаа. Яагаад вэ гэхээр бид 2 адилхан хөрш зэргэлдээ 2 ийм хөрштэй. Тэгэхээр зэрэг 2 хөршийн маань төмөр замын цариг хоёулаа өөр өөр учраас ялангуяа өөрийн чинь хэлдгээр юуны уул уурхайн бүтээгдэхүүн рүү Хятад руу экспортолж байгаа тохиолдолд аль улс руу экспортолж байгаагаас хамаараад тэр улсын царигаар зөөвөрлөвөл Монгол Улсын эдийн засагт ач холбогдолтой. Гэхдээ энэ асуудлыг бол яаж шийдэх, нарийн байх уу, өргөн байх уу гэдгийг бол зөвхөн Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Энд Засгийн газар бол зөвхөн санал оруулж ирээд, Улсын Их Хурлаар шийдүүлэх ёстой болохоор зэрэг Засгийн газар бол бодлогын хувьд цаашдаа өнөөдөр, дэлхий нийтээрээ бий болж байгаа геополитикийн нөхцөл байдал Трамп тарифтай холбоотойгоор энэ асуудал дээр бас ер нь аль болохоор уул уурхайн бүтээгдэхүүнээ экспортолж байгаа орныхоо царигаар төмөр замаа хийх нь илүү ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Тийм учраас бол энийг бид Улсын Их Хурлаар оруулж ирж байж шийднэ гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Цогтгэрэл: Монгол Улсын эдийн засгийн тухай ярихад өрсөлдөх чадварын тухай ярихад тээврийн тухай бараг хамгийн гол яриа бол тээврийн тухай л ярьж таарна.

Монгол Улсын тээврийн тухай ярихад төмөр замын тээврийн тухай яриа бид нар зайлшгүй ярих ёстой хамгийн чухал сэдэв. Тэгээд бүгдээрээ л улиг болтол бас зүйлүүдийг ярьдаг, Монголын төмөр зам, Улаанбаатар төмөр зам 40, 50 километр цагийн хурдтай гээд л бид нар баахан л ярьдаг. Энэ асуудал бүтээмж ярих юм би бас энэ дээр тоо уншиж байсан. Канад Улс 32 мянган км төмөр замтай, 1700 ажилтан ажилладаг юм гэнэ лээ. Манайх 1800км төмөр замтай, 17 мянган ажилтан ажилладаг. Нөгөө бүтээмж ярих юм бол бараг 200 дахин зөрүү, тэр нөгөө эдийн засгийн өрсөлдөх чадвар, техник технологи, менежмент бүх юм ийм л түвшинд оччихсон. Энийг бид нар улиг болтол ярьдаг. Энэ дээр гарц шийдэл ярихаар 1949 оны гэрээ хувь хувьцаа 50/50 хувийн хувьцаа шийдэл гаргаж болдоггүй гээд ийм асуудлууд ингээд ярьдаг. Тэгэхээр эндээс бид нарт өөрсдөө шийдэх хууль, эрх зүйн ямар гарц гаргалгаа байгаа юм гэдэг асуудлууд эндээс заавал яригдаж таарна.

Тэгэхээр танаас нэг тодорхой зүйл асуух гэж байгаа нь бид нар ер нь хууль, эрх зүйн хүрээнд, сая бас яригдаж байгаа зүйлүүдийнхээ хүрээнд Эрээн Замын-Үүдээс Улаанбаатар хүртэл нарийн царигтай төмөр зам тавьчих боломж ер нь байдаг юм уу. Энэ бол хуулиар бид нарт тэр гэрээ хэлэлцээр элдэв зүйлээрээ харшлах юм байна уу. Энэ өргөнтэйгөө бараг огтлолцохгүйгээр авчраад аль нэг газраа авчраад Чойртоо байдаг юм уу, Богд уулын урдаа байдаг юм уу, хаана байдаг юм, авчраад тээвэр логистик олон зүйлээ шийдчихвэл ер нь яадаг юм. Нефть бүтээгдэхүүний тухай ярьдаг яриа дээр хүртэл гардаг юм байна лээ. Урд талд бид нарт вагон цэс дээр нь шилжүүлэн ачих байгууламж байхгүй л гэдэг. Тэр нефть бүтээгдэхүүн чинь хүртэл нарийн царгаараа шууд Улаанбаатартаа хүрээд ирдэг. Олон янзын цаг хугацаа зөвхөн өртөг зардлаас гадна бизнест чинь цаг хугацаа гээд олон зүйлүүд байдаг. Бүгдээрээ л энийг ярихаар Эрээн Замын-Үүд шилжүүлэн ачих анги өргөн, нарийн цариг гээд л нэг ийм зүйл рүү аваачаад бүгдээрээ бид нар чихчихдэг. Тэгчхээд л тэрийгээ явсаар явсаар байгаад л Зөвлөлт Монголын гэрээ олон олон зүйл рүү.

Тэгэхээр саяын тэр нарийн царигийг Эрээн Замын-Үүдээс шилжүүлэн ачихгүйгээр, солихгүйгээр Улаанбаатарт авч ирээд, эндээс Монгол Улсынхаа тээвэр логистикийн бусад сүлжээндээ холбох, задлах энэ боломж ер нь байдаг уу. Энэ дээр та хууль, эрх зүйн боломжоо энд талуудаасаа нэг байр суурь илэрхийлээч.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь бол би тантай санал нэг байгаа. Улаанбаатар төмөр зам маань бол 75 жилийн өмнө ер нь байгуулагдаад, өнгөрсөн жил 75 жилийн ойгоо хийсэн. Тухайн үедээ бол үүргээ бол сайн биелүүлсэн. Үнэхээр Монгол Улсын өнөөдрийн эдийн засгийг өдий зэрэгтэй болгоход бол Улаанбаатар төмөр замын гүйцэтгэсэн үүргийг бол ярих юм байхгүй. Гэхдээ харамсалтай нь цаг үе өөр болсон. Мөн дэлхий нийтийн хөгжил ч гэсэн өөр хандлага, чиг хандлагатай болсон учраас бид цаашдаа бол төмөр замаа зайлшгүй шинэчлэх шаардлагатай. Өнөөдөр хурдны хувьд ч тэр, төмөр замын царигийн хувьд ч тэр энд бол манай улсын хувьд бол нэлээн маргаантай хэвээрээ байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт Улаанбаатар төмөр зам нь өөрөө бол өнөөдөр 16 мянган ажилтантай байгаа. Таны хэлж байгаа бол тоо би санал нэг байна. Тэгээд энд юу байдаг вэ гэхлээр зэрэг Улаанбаатар төмөр зам тухайн үедээ байгуулагдахдаа өөрийн бас нөгөө бүхэл бүтэн энд ажиллаж байгаа ажилчдын нийгмийн асуудлыг хамт авч явах үүднээс цэцэрлэгтэй, сургуультай, эмнэлэгтэй бүх л төрлийн соёлын төв гээд ингээд

дамжиж өнгөрч байгаа бүх суурин газруудын орон сууц энэ тэр гээд бүх Монгол Улсын маш олон иргэдийг ажилтай байлгаж байгаа учраас ийм том данхар бүстэй байгаа юм. Одоо орчин үеийн төмөр зам бол хөгжлөө дагаад ялангуяа хүн цөөтэй ажиллах ийм нөхцөл бололцоо бий болчихсон. Бид энэ рүү шилжих зайлшгүй шаардлагатай.

Цаг үеийн шаардлага маань өөрөө ийм болсон байгаа. Тэгэхээр таны хэлж байгаагаар Замын-Үүдээс ядахдаа бид Хөшигтийн хөндий хүртэл нарийн царигийн төмөр зам тавьж болох уу гэдэг асуудал бол бид өөрсдөө шийдэх асуудал. Монгол Улс тэр дундаа Улсын Их Хурлаар шийднэ. Гэхдээ нэг ийм заалт бий. Та бас санаж байгаа байх. 2018 онд ОХУ-тай хийсэн бид нарын иж бүрэн түншлэлийн гэрээнд өргөн төмөр замыг давхцуулж нарийн царигаар зам тавихгүй гэсэн ийм заалт хийсэн байдаг юм тухайн үедээ. Тийм учраас бид нар өөр боомтоор дамжиж ийм нарийн царигийн замыг наашаа төв рүүгээ оруулж ирж, таны хэлдгээр нефтийн хангамж болон бусад ачааг хийх ийм боломж бололцоотой. Тэрнээс яг өргөн царигийн төмөр замаа давхардуулж дагуулж нарийн царигийн төмөр зам хийх тийм тэр нөгөө ОХУ-тай хийсэн иж бүрэн түншлэлийн гэрээн дээрээ бол энүүгээр хаачихсан юм байна лээ.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тэгэхээр харин та тэр давхцахгүйгээр гэж байна. Тэгэхээр давхцахгүйгээр, угталцахгүйгээр параллель байж болохгүй юм уу.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Баярлалаа. Монголчууд нөгөө саалиа бэлдэхээр саваа бэлд гэж ярьдаг. Яг үүнтэй адилхан төмөр замаа бариад л байх юм бол Монгол Улсын эдийн засаг томроход, ард иргэдийн амьдрал сайжрахад импортоор авч байгаа бараа бүтээгдэхүүн хурдан шуурхай хугацаанд бага зардлаар ирж, үнэ өртөг нь хямдрахад мөн бас уул уурхайн бүтээгдэхүүнээ аль болох ахиу экспортолж Монгол Улсын валютын нөөц нэмэгдэж, төсвийн орлого бүрдэхэд чухал ач холбогдолтой. Энэ үүднээсээ бид нар бас Транс-Азийн төмөр замын сүлжээнд холбогдох асуудлыг 2007 онд Засгийн газраар, Улсын Их Хурлаар баталж байсан. 2023 онд өөрчлөлт нь ороод Тайландад хуралдаад Иран улсын саналаар үндсэндээ өнөөдрийн хэлэлцээр орж ирж байгаа.

Ингээд аваад үзэхээр үндсэндээ Монголчууд бид бүхэн өнгөрсөн 70 жилийн хугацаанд Орос, Хятадтай ганц ганцхан Оростой Сэлэнгээр, Алтанбулагаар, Сүхбаатараар, Хятадтай, Замын-Үүд, Эрээнээр холбогддог байсан бол бидний бодлого цаашаа бол Хятад Улстай 5 боомтоор эхний ээлжид төмөр замаар холбогдъё. ОХУ-тай 3 боомтоор төмөр замаар холбогдъё. Орос, Хятад, Ази Европыг холбосон ганцхан төмөр замтай байсан бол одоо 3 төмөр замтай болъё. Баруун талдаа 1 төмөр замтай, зүүн талдаа зүүн босоо төмөр замтай болъё. Энэ төмөр замууд нь цаашлаад Тяньжин гэсэн ганцхан боомт руу гардаг биш Жинжөү гэсэн 2 дахь боомтоор хурдан хугацаанд бараа бүтээгдэхүүн гардаг 2 дахь боомттой болъё. Мөн бас баруун талаараа бид нар Иран Улсаар дамжаад эндхийн далай руу Бандарбасс боомтоор гаръя гэсэн энэ л бодлогуудын хүрээнд хийгдэж байгаа ажил. Тэгээд энэ үүднээсээ бол энэ асуудлыг дэмжиж байгаа. Бид нар аль болох ингэж том харах ёстой асуудлаа. Тэгэхгүй зөвхөн Орос Хятадыг холбосон төмөр зам, Хятад руу нөгөө 5 гарцтай болгох гээд өчнөөн жил болдог, ингээд гацдаг биш, илүү

энэ хэлэлцээрээ батлаад цааш нь үүгээрээ дамжаад саяын ярьж байгаа ганцхан Тяньжинээр дамждаг биш яавал тэр Жинжөү боомтоор хурдан хугацаанд бараа бүтээгдэхүүн авчирдаг, гаргадаг болгох вэ. Мөн Хятадын төмөр зам Европ руу явж байгаа төмөр замд холбогдоод Европ руу бараа бүтээгдэхүүн яаж хурдан гаргах вэ. Мөн түүгээрээ дамжаад, цаашаа Төв Азиар дамжаад бид бүхэн бас Иран руу Энэтхэгийн далай руу яаж гарах вэ гэдэг юмаа бас томоор нь харах ёстой. Энэ дээр манай Дэлгэрсайхан сайд маань бас нэлээн санаачилгатай, анхаарч ажиллах байх. Ажиллаж байгаа. Тийм болохоор бид бүхэн бас иймэрхүү байдлаар энэ дээр Монгол Улсын Их Хурал төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогодоо бас өөрчлөлт оруулаад, одоо баригдаж байгаа төмөр замаа зөвхөн 5 боомтоор Хятад руу гарахаас гадна дотооддоо бас төмөр замын өргөн байна уу, нарийн байна уу төмөр замуудаа бас барих бүтээн байгуулах ажлуудаа бас нэлээн жоохон эрчимтэйхэн шиг дэмжээд ингээд явчихмаар байгаа юм. Ингэх юм бол бараа бүтээгдэхүүний үнэ өртөг буурна. Хурдан шуурхай хугацаанд Тяньжин дээр бараа бүтээгдэхүүн хэдэн сараар гацахаа болино. Мөн бас экспортын бүтээгдэхүүнээ аль болох ахиу экспортолж, Монгол Улсын валютын нөөц нэмэгдэж төсвийн орлого бас бүрдэх ийм бас боломжууд бүрдэх юм. Тийм үүднээс бас оруулж ирж байгаа төслийг дэмжиж байгаа. Дэлгэрсайхан сайд маань бас илүү хурдацтай, санаачилгатай ажиллана гэдэгт найдаж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтыг маргааш үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан дээр явуулна.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж байна.

Би өглөө бас зарласан байгаа. Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлыг хэдэн цагаас эхлээд, хэдэн цагт дуусах вэ, яг ямар ямар асуудлыг хэлэлцэж байх вэ гэдгийг маш тодорхой хуваарьтай болгоно.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд яг чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудал дээрээ бүрэн суудаг болох тэр нөхцөл шаардлагыг тавьж ажиллана.

Нөгөөтээгүүр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тов дараалал 7 хоногийн өмнө гардаг. Тэгэхээр энэ тов дараалалтай давхцсан ажил, арга хэмжээг төрийн бусад байгууллагууд зохион байгуулахгүй байх шаардлагыг бас Улсын Их Хурлын зүгээс тавина. Улсын Их Хурлын гишүүдийг олноор нь хурал семинар, зөвлөгөөнд, арга хэмжээнд урьж оролцуулдаг энэ байдал бас чуулганы хуралдаантай давхцахаар үр дүнгүй болоод байдаг учраас энэ асуудлыг эмхэлж цэгцэлнэ гэдгийг бас дахин сануулж хэлье. Тамгын газраас энэ ажлыг бас Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудад бас мэдээлэх үүрэг өгье.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

16.30 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ